



PSD3

стандарт

Монголын Банкны Холбоо болон Монголын Финтекийн
Холбоо хамтран орчуулав





Brussels, 28.6.2023
COM(2023) 366 final

2023/0209 (COD)

Proposal for a

DIRECTIVE OF THE EUROPEAN PARLIAMENT AND OF THE COUNCIL

**on payment services and electronic money services in the Internal Market amending
Directive 98/26/EC and repealing Directives 2015/2366/EU and 2009/110/EC**

(Text with EEA relevance)

{SEC(2023) 256 final} - {SWD(2023) 231 final} - {SWD(2023) 232 final}



Брюссель, 2023.06.28
COM(2023) 366 эцсийн хувилбар
2023/0209(COD)

ЕВРОПЫН ПАРЛАМЕНТ БОЛОН ЗӨВЛӨЛИЙН
98/26/ ЕХ тоот удирдамжид нэмэлт өөрчлөлт оруулах, 2015/2366/ ЕХ болон 2009/110/ ЕХ
тоот удирдамжуудыг хүчингүй болгох
Дотоод зах зээл дээрх Төлбөрийн үйлчилгээ болон Цахим мөнгөний үйлчилгээний
УДИРДАМЖ

(ЕЭБ хамааралтай текст)

ТАЙЛБАР САНАМЖ

1. САНАЛЫН АГУУЛГА

• Саналын үндэслэл, зорилго

Төлбөрийн үйлчилгээний хоёр дахь удирдамж (ТҮҮ2¹) нь Европын Холбоон дахь евро болон бусад мөнгөн тэмдэгтээрх дотоодын болон хил дамнасан бүх жижиглэнгийн төлбөр тооцоо (бага дүнтэй төлбөр тооцоог ойлгох бөгөөд цаашид “жижиглэнгийн төлбөр тооцоо” гэдэгээр явав. Орч.тэмд)-ны хууль эрх зүйн зохицуулалтаар хангана. 2007 онд батлагдсан Төлбөрийн үйлчилгээний анхны удирдамж (ТҮҮ1²) нь ЕХ-ны төлбөрийн нэгдсэн зах зээлийг бий болгоход чиглэгдсэн хууль эрх зүйн орчныг бүрдүүлсэн. ТҮҮ1 дээр тулгуурлан ТҮҮ2 нь төлбөрийн шинэ төрлийн үйлчилгээнд тулгарч буй саад бэрхшээлийг шийдэж, хэрэглэгчийн хамгаалалт, аюулгүй байдлын түвшинг дээшлүүлсэн. ТҮҮ2-т тусгагдсан ихэнх дүрмүүдийг 2018 оны 01-р сараас эхлэн мөрдөгдөж эхэлсэн боловч Харилцагчийн найдвартай баталгаажуулалт (SCA) гэх мэт зарим дүрмийг 2019 оны 09-р сараас эхлэн мөрдөж эхэлсэн.

ТҮҮ2 нь төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийн зүгээс төлбөрийн үйлчилгээ үзүүлэх дүрмийг тодорхойлдогос гадна бусад ангилалд хамаарах төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч буюу тодорхой нэг төлбөр тооцооны байгууллагад олгох тусгай зөвшөөрөл болон түүнд тавих хяналтын зохицуулалтыг агуулдаг. Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн бусад ангилалд ЕХ-ны банкны хууль тогтоомжийн³ дагуу зохицуулагддаг зээлийн байгууллагууд болон Цахим мөнгөний удирдамжийн⁴ дагуу зохицуулагддаг Цахим мөнгөний байгууллагууд (EMIs) ордог.

2020 оны ЕХ-ны Сайд нарын Комиссийн жижиглэнгийн төлбөрийн стратегийн⁵ тухай (RPS) мэдэгдлээр Комиссийн бүрэн эрхийн хугацаанд (2019-2024) Комиссийн зүгээс жижиглэнгийн төлбөрийн салбарт баримтлах тэргүүлэх чиглэлийг тодорхойлсон. Түүнчлэн, тухайн стратегийн баримт бичгээр төлбөр тооцооноос бусад санхүүгийн салбар дахь цахим санхүүгийн стратегийн мөрийн хөтөлбөрийн тэргүүлэх чиглэлийг баталсан. Жижиглэнгийн төлбөрийн стратегиар "2021 оны сүүлээр Комисс нь ТҮҮ2-н хэрэгжилт болон түүний нөлөөллийн талаар цогц шалгалтыг эхлүүлнэ" гэж мэдэгдэв. Энэхүү хяналт шалгалтыг үндсэндээ 2022 онд зохих ёсоор хийж гүйцэтгэсэн бөгөөд Комиссоос ТҮҮ2-ын үйл ажиллагааг сайжруулахын тулд хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргах шийдвэрт хүрсэн. Эдгээр нэмэлт, өөрчлөлтүүд нь төлбөрийн байгууллагуудын тусгай зөвшөөрөл, хяналтад чиглэгдсэн төлбөрийн үйлчилгээ, цахим мөнгөний үйлчилгээний

¹ Дотоод зах зээл дэх төлбөрийн үйлчилгээний тухай 2015 оны 11-р сарын 25-ны өдрийн (ЕХ) 2015/2366 тоот удирдамж.

² Зээлийн байгууллагуудын зохистой байдлын шаардлагын тухай (ЕХ) 575/2013 тоот удирдамж.

³ Зээлийн байгууллагуудын үйл ажиллагаанд нэвтрэх эрх, зээлийн байгууллагын зохистой байдлын хяналтын тухай 2013/36/ЕХ-ны журам.

⁴ Цахим мөнгөний байгууллагуудын үйл ажиллагаа эрхлэх, эрэлхийлэх, зохистой хяналт тавих тухай 2009/110/ЕС удирдамж.

⁵ 2020 оны 9-р сарын 24-ний эцсийн COM (2020) 592.

талаархи удирдамжийн санал (мөн бусад зарим удирдамжид нэмэлт өөрчлөлт оруулах) болон ЕХ дахь төлбөрийн үйлчилгээний тухай журмын санал гэсэн хоёр саналд тусгагдсан. ТҮҮ2-т тусгагдах дээрх саналууд нь Комиссийн 2023 оны Ажлын хөтөлбөрт төлбөрийн данснаас гадна илүү өргөн хүрээний санхүүгийн үйлчилгээг ашиглах санхүүгийн мэдээллийн хүртээмж болон түүний ашиглалтыг нэмэгдүүлэх төлөвлөгөөт эрх зүйн шинэчлэлтийн хамтаар тусгагдсан.

- **Хүчин төгөлдөр бодлогын шалгууртай нийцэх байдал**

Энэхүү санаачилгатай холбоотой хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бодлогын зохицуулалтууд жижиглэнгийн төлбөрийн салбарын бусад хууль тогтоомж, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийг хамарсан санхүүгийн үйлчилгээний бусад хууль тогтоомж, жижиглэнгийн төлбөрийн салбарт нөлөөлж буй өргөн хүрээний Холбооны хууль тогтоомж зэргийг багтаасан болно. Энэхүү саналыг эдгээр заалттай уялдуулан нийцүүлэхэд онцгой анхаарах замаар боловсруулсан.

Дээр дурьдсанаас гадна жижиглэнгийн төлбөрийн салбарын бусад хууль тогтоомжид 2012 оны Евро төлбөрийн нэгдсэн бүс (SEPA)-н журам багтсан бөгөөд энэ нь еврогоорх зарлагын болон орлогын шилжүүлэгт⁶ тавигдах техникийн шаардлагуудыг уялдуулсан. 2022 оны 10-р сарын 26-нд Комиссоос Европын холбоон дахь еврогоорх төлбөр тооцоог хурдасгах, хөнгөвчлөх зорилгоор Евро төлбөрийн нэгдсэн бүсийн журамд нэмэлт, өөрчлөлт оруулахаар санал болгосон⁷. Хил дамнасан төлбөрийн тухай журамд дотоод болон хил дамнасан еврогоорх шилжүүлгийн шимтгэлийг ижил түвшинд байхаар зохицуулалт хийгдсэн⁸. Банк хоорондын шимтгэлийн тухай журамд ийм төрлийн төлбөрийн дээд хэмжээг тогтоосон байдаг⁹.

Санхүүгийн үйлчилгээний бусад холбогдох хууль тогтоомжид Төлбөр тооцоо эцэслэх удирдамж¹⁰ (SFD), Крипто хөрөнгийн зах зээлийн зохицуулалт¹¹ (MiCA), Кибер аюулгүй байдлын хүрээн дэх дижитал үйл ажиллагааны тогтвортой байдлын тухай хууль¹² (DORA) болон Мөнгө угаахтай тэмцэх (AML) удирдамж зэрэг багтаж байгаа бөгөөд түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийн саналын багцыг хууль тогтоогчидтой хамтран хэлэлцэж байна. Энэхүү санаачилга нь жижиглэнгийн төлбөрийн стратегитай хамт батлагдсан ЕХ-ны дижитал санхүүгийн стратегид¹³ тусгагдсан Комиссийн бусад санаачилгатай бүрэн нийцэж байгаа бөгөөд ЕХ-ны эдийн засгийн дижитал өөрчлөлтийг дэмжих, дижитал дотоод зах зээл дэх саад бэрхшээлийг арилгах зорилготой юм.

⁶ 2012 оны 3-р сарын 14-ний өдрийн (ЕХ)260/2012 тоот удирдамж.

⁷ СОМ(2022) 546 эцсийн хувилбар.

⁸ Холбооны хил дамнасан төлбөрийн тухай 2021 оны 7-р сарын 14-ний өдрийн (ЕХ) 2021/1230 журам.

⁹ 2015 оны 4-р сарын 29-ний өдрийн (ЕХ) 2015/751 картаарх төлбөрийн гүйлгээний хураамжийн тухай журам.

¹⁰ Төлбөрийн болон үнэт цаасны төлбөр тооцооны систем дэх төлбөр тооцоог дуусгавар болгох тухай 1998 оны 5-р сарын 19-ний өдрийн 98/26/ЕС удирдамж.

¹¹ Крипто хөрөнгийн зах зээлийн тухай 2023 оны 5-р сарын 31-ний өдрийн (ЕХ) 2023/1114 тоот журам.

¹² Санхүүгийн салбарын дижитал үйл ажиллагааны уян хатан байдлын тухай 2022 оны 12-р сарын 14-ний өдрийн (ЕХ) 2022/2554 тоот журам.

¹³ 2020 оны 9-р сарын 24-ний СОМ (2020) 591-ийн эцсийн хувилбар.

- **Европын хобооны бусад бодлоготой нийцэх байдал**

Энэхүү санаачилга нь санхүүгийн үйлчилгээний нэгдсэн зах зээлийг бэхжүүлэхэд жижиглэнгийн төлбөрийн стратеги болон санхүүгийн дижитал инновацийн ач холбогдлыг дахин цохон тэмдэглэсэн 2021 оны Комиссийн мэдэгдэлд "Европын эдийн засаг, санхүүгийн систем нь нээлттэй, хүчирхэг, уян хатан¹⁴" гэсэнтэй нийцэж байгаа. Түүнчлэн тухайн мэдэгдэлд Комисс болон Европын Төв банкны албадууд дижитал еврог нэвтрүүлэхтэй холбоотойгоор үүдэн гарах өргөн хүрээний бодлого, хууль эрх зүй, техникийн асуудал дээр ЕХ-ны гэрээ, хууль эрх зүйн хүрээнд тус бүрийн эрх үүргийн дагуу техникийн түвшинд хамтран ажиллахаа мэдэгдсэн.

Комисс нь ТҮҮ2-д нэмэлт, өөрчлөлт оруулах хоёр саналтай хамт танилцуулсан санхүүгийн мэдээлэлд нэвтрэх эрх зүйн зохицуулалтын тухай ЕХ-ны саналыг өргөн барьж байна; Энэхүү санал нь төлбөрийн тухай хууль тогтоомжид хамаарах төлбөрийн дансны мэдээллээс бусад санхүүгийн мэдээлэлд хандах хандалтыг хамарна. ЕХ-ны холбогдох илүү ерөнхий хууль тогтоомжид Мэдээлэл хамгаалах ерөнхий журам багтдаг¹⁵.

2. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ, СУБСИДИАР БОЛОН ПРОПОРЦИОНАЛЬ БАЙДАЛ

- **Хууль эрх зүйн үндэслэл**

ТҮҮ2-ын эрх зүйн үндэс нь Европын Холбооны үйл ажиллагааны тухай гэрээний (ЕХҮАГ-ТФЕУ) 114-р зүйл бөгөөд Европын холбооны байгууллагуудад тус гэрээний 26 дугаар зүйлд заасны дагуу дотоод зах зээлийг бий болгох, түүний хэвийн үйл ажиллагааг хангах заалтуудыг тогтоох үүрэг хүлээдэг. Гэсэн хэдий ч Цахим мөнгөний тухай заавар¹⁶ нь ЕХҮАГ-ний 53, 114-р зүйлд үндэслэж энэ нь удирдамжийн саналд тусгагдсан тул цахим мөнгө гаргах байгууллагуудад зөвшөөрөл олгох журмыг тусгасан аливаа шинэ эрх зүйн акт нь мөн адил давхар эрх зүйн суурьтай байх ёстой.

- **Субсидиар байдал (онцгой бус чадамжийн хувьд)**

Үйлчилгээ үзүүлэх эрх чөлөө, байгуулах эрх чөлөөг төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид өргөнөөр ашигладаг. Жижиглэнгийн төлбөрийн үйлчилгээний дотоод зах зээлд нийцтэй нөхцөл, тэгш өрсөлдөөний нөхцлийг хангахын тулд Европын холбооны түвшний хууль тогтоомж шаардлагатай. Энэхүү санаа нь эхний болон хоёр дахь Төлбөрийн үйлчилгээний удирдамжийн үндэс суурь бөгөөд энэхүү саналд тусгагдсан хэвээр байна.

- **Пропорциональ байдал**

Энэхүү удирдамжийн санал нь төлбөрийн үйлчилгээнд төрөл бүрийн эхлэлтийн хөрөнгө, өөрийн хөрөнгийн зэрэг зорилтот пропорциональ хэмжүүрүүдийн шалгуурыг багтаасан

¹⁴ 2021 оны 1-р сарын 19-ний СОМ (2021) 32 эцсийн хувилбар.

¹⁵ 2016 оны 4-р сарын 27-ны өдрийн (ЕХ) 2016/679 тоот журам. "Үндсэн эрх" хэсгээс үзнэ үү.

¹⁶ 2009 оны 9-р сарын 16-ны өдрийн 2009/110/ЕХ тоот "Цахим мөнгөний байгууллагын үйл ажиллагаа эрхлэх, эрэлхийлэх, зохистой хяналт тавих тухай" удирдамж.

болно. Уг саналд тусгагдсанаар гишүүн орнуудын 3 сая еврогоос бага эргэлттэй жижиг төлбөрийн үйлчилгээний байгууллагуудад зөвшөөрөл олгохдоо зарим шалгууруудаас чөлөөлөхийг зөвшөөрдөг. Саналд тусгагдсан дэлгүүрээс эсвэл бие даасан АТМ байршуулагчдаас бэлэн мөнгө авах үйлчилгээнд санал болгож буй шинэ заалтууд нь мөн пропорциональ байна.

- **Хэрэгжүүлэх арга хэрэгслийн сонголт**

ТҮҮ2 нь одоогоор гишүүн орнуудад хууль тогтоомжийг шилжүүлэх замаар хэрэгждэг заавар юм. Гэсэн хэдий ч Европын холбооны санхүүгийн үйлчилгээний хууль тогтоомжийн янз бүрийн салбарт¹⁷ гишүүн орнуудын хэрэгжилтийн уялдаа холбоог нэмэгдүүлэхийн тулд санхүүгийн байгууллагуудад хамаарах дүрмийг шууд холбогдох журамд оруулах нь зүйтэй гэж үзсэн. ТҮҮ2-ын тойм нь энэхүү арга төлбөрийн хууль тогтоомжид тохиромжтой гэж дүгнэсэн бөгөөд энэ нь ТҮҮ2-д санал болгож буй нэмэлт, өөрчлөлтийг хоёр өөр хууль тогтоомжийн актад тусгахад хүргэсэн бөгөөд үүнд: төлбөрийн байгууллагад тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавихтай холбоотой дүрэм журмыг агуулсан удирдамжийн энэхүү санал болон дагалдах төлбөрийн болон цахим мөнгөний үйлчилгээ үзүүлдэг төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийн (төлбөрийн байгууллага болон бусад зарим ангиллын төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийг оролцуулан) дүрмийг агуулсан зохицуулалтын санал орж байна. Одоогийн нөхцөл байдалд Санхүүгийн байгууллагуудын тусгай зөвшөөрөл, хяналтыг ерөнхийд нь (түүний дотор зээлийн байгууллагууд гэх мэт төлбөрийн байгууллагууд болон бусад ангиллын төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчүүдийг оруулаад) гишүүн орнуудын дотоодын эрх мэдлийн хүрээнд хэвээр байгаа бөгөөд Европын холбооны түвшний тусгай зөвшөөрөл, хяналт байхгүй гэдгийг харгалзан үзвэл удирдамж хэлбэртэй байх нь тохиромжтой гэж үзэж байна.

3. ҮНЭЛГЭЭНИЙ ДАРААХ ҮР ДҮН, ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЗӨВЛӨЛДӨӨН, НӨЛӨӨЛЛИЙН ҮНЭЛГЭЭ

- **Үнэлгээний дараах үр дүн/Одоо мөрдөгдөж буй хууль тогтоомжид нийцэж буй байдлын сорил**

ТҮҮ2-н үнэлгээг 2022 онд хийсэн. Үнэлгээнд бие даасан гүйцэтгэгчийн тайлан болон олон нийтийн хэлэлцүүлэгт оролцогч талуудын саналыг тусгасан. Үнэлгээний тайланг энэхүү саналын дагалдах нөлөөллийн үнэлгээний хавсралт болгон нийтэлсэн болно¹⁸. Үнэлгээний тайланд Үнэлгээний тайлангаар ТҮҮ2-р тавьсан зорилтууд янз бүрийн түвшний амжилтанд хүрсэн гэж дүгнэсэн. Ерөнхийдөө, үнэлгээний дүнд одоогийн ТҮҮ2 -н бүтэц нь зарим дутагдалтай талуудыг үл харгалзан өмнөө тавсан зорилгодоо хүрэх ахиц дэшил гаргасан төдийгүй харьцангуй хэмнэлттэй, ЕХ-нд нэмүү өртөг бүтээхэд чиглэгдсэн гэж дүгнэжээ.

¹⁷ Үнэт цаасны зах зээл дэх Банкны зохистой дүрэм гэх мэт.

¹⁸ SWD 2023/231 финал.

- **Оролцогч талуудын Зөвлөлдөөн**

Комиссийн саналд бүх оролцогч талуудын сонирхолыг тусгах үүднээс Зөвлөлдөх стратегид дараахь хэлэлцүүлгүүдийг зохион байгуулсан болно. Үүнд:

- 2022 оны 5-р сарын 10-наас 2022 оны 8-р сарын 2-ны хооронд нээлттэй олон нийтийн хэлэлцүүлэг¹⁹;
- 2022 оны 5-р сарын 10-наас 2022 оны 7-р сарын 5-ны хооронд нээлттэй, олон нийтийн хэлэлцүүлгээс илүү нарийвчилсан асуулт бүхий зорилтот (гэхдээ олон нийтийн болон нээлттэй) хэлэлцүүлэг²⁰;
- 2022 оны 5-р сарын 10-аас 2022 оны 8-р сарын 02 хүртэл нээлттэй тодорхой асуудлаар мэдээлэл, өгөгдөл, санал, нотлох баримтыг ирүүлэх албан ёсны хүсэлт²¹;
- 2021 оны 2-р сарын 12-оос 2021 оны 5-р сарын 7-ны хооронд нээлттэй Төлбөр тооцоог эцэслэх удирдамж(Settlement Finality Directive)-аарх зорилтот зөвлөгөөн;
- Комиссийн шинжээчийн бүлэг, Төлбөрийн системийн зах зээлийн шинжээчдийн бүлэгт оролцогч талуудын зөвлөгөөн;
- Төрөл бүрийн сонирхогч талуудтай тэдний санаачилгаар эсвэл Комиссийн санаачилгаар шаардлагатай тухай бүр зохион байгуулах зөвлөгөөн;
- Комисс дэх Банкны төлбөр тооцоо, даатгалын шинжээчдийн бүлэг дэх Гишүүн орнуудын шинжээчдийн зөвлөгөөн.

Эдгээр хэлэлцүүлэг болон зөвлөгөөний үр дүнг нэгтгэн энэхүү саналын нөлөөллийн үнэлгээний 2-р хавсралтад харуулав.

- **Туршлага цуглуулах, ашиглах**

-

Энэхүү санаачилгыг бэлтгэхдээ дараах хэд хэдэн мэдээллийн эх сурвалжийг ашигласан болно. Үүнд:

– дээр дурьдсан янз бүрийн зөвлөгөөний болон сонирхогч талуудаас тусгайлан ирүүлсэн мэдээ, баримтууд,

– Европын Банкны эрх бүхий этгээдийн зөвлөмжөөр²² өгөгдсөн баримт мэдээлэл,
– 2022 оны 9-р сард гэрээт гүйцэтгэгч “Valdani Vicari & Associati Consulting” зөвлөх компанийн хийсэн “Төлбөрийн үйлчилгээний удирдамжийн хэрэгжилт болон төлбөрийн үйлчилгээн дэх Удирдамж (EU)20125/2366-н нөлөөллийн судалгаа²³”.

¹⁹ https://ec.europa.eu/info/law/better-regulation/have-your-say/initiatives/13331-Payment-services-review-of-EU-rules/public-consultation_en

²⁰ https://finance.ec.europa.eu/regulation-and-supervision/consultations/finance-2022-psd2-review_en

²¹ https://ec.europa.eu/info/law/better-regulation/have-your-say/initiatives/13331-Payment-services-review-of-EU-rules_en

²² 2022 оны 6-р сарын 23-ны ЕВА/Ор/2022/06.

²³ Энэ холбоосоор үзэх боломжтой: <https://data.europa.eu/doi/10.2874/996945>. Гэрээний лавлагаа FISMA/2021/OP/0002.

– хувийн хэвшлийн операторуудаас авсан мэдээлэл.

- **Нөлөөллийн үнэлгээ**

Энэхүү саналыг (мөн Дотоод зах зээл дэх төлбөрийн үйлчилгээний тухай журмын саналыг) 2023 оны 3-р сарын 1-ний өдөр Зохицуулах хяналтын Комисс (RSB)-р хянагдсан нөлөөллийн үнэлгээний хамт оруулсан болно. Зохицуулах хяналтын Комиссоос 2023 оны 3-р сарын 3 өдөр нөлөөллийн үнэлгээнд эерэг дүгнэлт өгсөн. Гэсэн хэдий ч ТҮҮ2-н ололт амжилтыг үл харгалзан ЕХ-ны төлбөрийн зах зээлд дөрвөн гол асуудал байгааг олж тогтоосон ба үүнд:

- хэрэглэгчид залилан мэхлэх эрсдэлд өртөмтгий, төлбөр тооцоонд итгэх итгэл дутмаг;
- банкны салбарын үйл ажиллагаа төгс бус;
- ЕХ-ны гишүүн орнуудын хянан шалгагч нар харилцан адилгүй эрх, үүрэг хүлээдэг;
- банк болон банк бус Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн хооронд тэгш бус өрсөлдөөн зэрэг байна.

Эдгээр асуудлын үр дагавар нь дараахь байдлаар илэрч байгаа бөгөөд үүнд:

- хэрэглэгчид (худалдан авагч, худалдаачид болон ЖДҮ эрхлэгчид) залилангийн эрсдэлд өртсөөр байгаа бөгөөд төлбөрийн үйлчилгээний сонголт хязгаарлагдмал, үнэ нь байх ёстой хэмжээнээс өндөр;
- банкны үйлчилгээ үзүүлэгчдээс банкны үндсэн үйлчилгээг санал болгоход саад бэрхшээл тулгардаг бөгөөд банкны бүтээгдэхүүн, үйлчилгээнд шинэлэг байдлыг нэвтрүүлэхэд хүндрэлтэй;
- төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид үүргийнхээ талаар тодорхойгүй байдалтай тулгардаг ба банк бус ТҮҮ нь банкуудтай өрсөлдөхөд хүндрэлтэй;
- ЕХ-ны өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж буй эдийн засгийн үр ашиггүй байдал, арилжааны үйл ажиллагааны зардал өндөр;
- Төлбөрийн дотоод зах зээлийн үйл ажиллагаа нэгдсэн нэг загвартай бус, “форумын худалдаа буюу аль ашигтай хувилбар”-г сонгох замаар явагддаг.

Дээрх тодорхойлсон асуудлыг шийдвэрлэх 4 арга зам нь:

1. Хэрэглэгчийн хамгаалалт, төлбөрт итгэх итгэлийг бэхжүүлэх;
2. Банкны үйлчилгээний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх;
3. Гишүүн орнууд дахь хууль журам сахих, түүний хэрэгжилтийг сайжруулах;
4. Банк бус ТҮҮ-ийн төлбөрийн систем болон банкны данс руу нэвтрэх (шууд болон шууд бус) боломжийг сайжруулах зэрэг юм.

Нөлөөллийн үнэлгээ нь тодорхой зорилгод хүрэхэд чиглэсэн хамгийн боломжит хувилбаруудын багцыг харуулж байгаа (доорх жагсаалт нь энэхүү заавар болон дагалдах журамд тусгагдсан арга хэмжээг хамарна) бөгөөд үүнд:

- 1-р зорилтын хүрээнд Харилцагчийн найдвартай баталгаажуулалт (ХНБ – SCA)-ийн хэрэглээг сайжруулах, үйлчлүүлэгчдэд залилангийн талаар сургах залилангийн

талаарх мэдээлэл солилцох эрх зүйн үндэс, бүх зарлагын шилжүүлэгт IBAN баталгаажуулалтыг сунгах, залилангийн гүйлгээний хохирлыг албадан төлүүлэх, буцаах нөхцөлтэйгөөр хариуцлагаас хөнгөлөх; Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчээс хөгжлийн бэрхшээлтэй хэрэглэгчид, өндөр настан болон Харилцагчийн найдвартай баталгаажуулалтыг ашиглахтай холбоотойгоор аливаа нэг саад бэрхшээлтэй тулгарсан хүмүүст чиглэсэн ХНБ-н хэрэглээний хүртээмжийг сайжруулах; бэлэн мөнгөний хүртээмжийг сайжруулах; хэрэглэгчийн эрх, мэдээллийг сайжруулах.

- 2-р зорилтын хүрээнд ТҮҮ (мөн Дансны үйлчилгээ болон төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч-ДҮТҮҮ)-дэд тавиглах шаардлага нь өгөгдөлд нэвтрэх тусгай интерфэйсийг бий болгохуйц байх; "Зөвшөөрлийн хяналтын самбар" нь хэрэглэгчдэд олгосон нээлттэй банкны хандалтын зөвшөөрлөө удирдах боломжийг олгодог байх; нээлттэй банкны системийн өгөгдлийн интерфэйсд тавигдах хамгийн бага шалгуурыг тогтоох нарийвчилсан үзүүлэлтүүдийг тодорхойлох;
- 3-р зорилтын хүрээнд ТҮҮ2-ын ихэнх хэсгийг шууд зохицуулах холбогдох журмаар солих; торгуулийн тухай заалтыг бэхжүүлэх; хоёрдмол утгатай ухагдахуунуудыг тодруулах; Төлбөрийн байгууллага (ТБ-PI-Payment Institution) болон Цахим мөнгөний байгууллага (ЦМБ- EMI-Electronic money institution) -дад тусгай зөвшөөрөл авахад тавигдах зохицуулалтын үйл явц, шаардлагыг нэгтгэх буюу оновчтой болгох.
- 4-р зорилтын хүрээнд Төлбөрийн байгууллага (ТМ) болон Цахим мөнгөний байгууллага (ЕМI)-ийн банкны данс руу нэвтрэх, үйл ажиллагаандаа ашиглах боломжийг нэмэгдүүлэх, баталгаажуулах замаар бэхжүүлэх; Төлбөрийн байгууллага (ТМ) болон Цахим мөнгөний байгууллага (ЕМI)-дыг үйлчилгээний төлбөрийн болон эрсдэлийн үнэлгээний журмын нэмэлт тодруулга хийсний үндсэн дээр Төлбөр тооцоо эцэслэх удирдамж (SFD)-аар тогтоосон гишүүн орнуудын болон бүх төлбөрийн системд шууд оролцох боломжийг олгох.

Нөлөөллийн үнэлгээнд хэрэгжүүлэх зардал өндөр, үр ашиг нь тодорхойгүй гэсэн үндэслэлээр хэд хэдэн хувилбараас татгалзсан. Сонгогдсон хувилбаруудын зардал нь голчлон нэг удаагийн зардал бөгөөд үүний дийлэнх хэсэг нь Дансны үйлчилгээ болон төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч (ДҮТҮҮ, үндсэндээ банк)-д оногдож байгаа. Нээлттэй банкны үйл ажиллагаанд тодорхой зардлуудыг хэмнэлтээр(нөөц интерфэйсийн зардлыг бууруулах, зарим нэг шаардлага, шалгуураас чөлөөлөх г.м) эсвэл тодорхой нөхцөл байдалд тохируулан өөрчлөх (ДҮТҮҮ гэх мэт төрөлжсөн байгууллагад хөнгөлөлт, буцаалт үзүүлэх) зэрэг пропорциональ арга хэмжээ авах замаар нөхдөг. Гишүүн орнуудын хэрэгжилт, хэрэгжилтийг сайжруулахад гарах зардал хэт өндөр бус байна. Төлбөрийн байгууллагын төлбөрийн гол системд шууд нэвтрэх зардал хэт өндөр бус, хязгаарлагдмал байх бөгөөд энэ нь тухайн төлбөрийн системээс хамаарна. Нөгөөтэйгүүр, үүний ашгийг хувь нийлүүлэгчид болон төлбөрийн үйлчилгээний хэрэглэгчид (хэрэглэгч, бизнесүүд, худалдаачид болон төрийн захиргааны байгууллагууд), түүнчлэн ТҮҮ (ялангуяа банк бус финтек ТҮҮ) өөрөө зэрэг өргөн хүрээний оролцогч талууд хүртнэ. Ашиг нь тогтмол байх ба зардал нь ихэвчлэн нэг удаагийн тохируулгын зардал байх учир хуримтлагдсан ашиг нь цаг хугацааны явцад нийт зардлаас давсан байх ёстой.

- **Зохицуулалтын нөлөөллийн сорил болон хялбаршуулалт**

Одоогийн санаачилга нь Зохицуулалтын нөлөөллийн үнэлгээ ба гүйцэтгэлийн хөтөлбөр (REFIT)-н санаачилга биш юм. Гэсэн хэдий ч үнэлгээ, хяналтын үйл явцын нэг хэсэг болгон захиргааны үйл ажиллагааг хялбарчлах боломжийг эрэлхийлсэн. Энэхүү санаачилгад тусгагдсан хялбаршуулсан байдлын жишээ бол ЦМУ2 (Цахим мөнгөний 2-р удирдамж)-ийг ТҮҮ2-т нэгтгэх, Цахим мөнгөний байгууллага (EMI) болон Төлбөрийн байгууллага (PI)-ийн зохицуулалтын горимуудын ялгааг бодитоор бууруулсан (өөрийн хөрөнгийн шаардлага дээр ялгаатай зөрүүтэй байдал хэвээр үлдсэн). Энэхүү саналд Цахим мөнгөний т хоёрдугаар удирдамжийг хүчингүй болгох асуудал багтаж байна.

- **Үндсэн эрх**

Энэхүү санаачилгатай холбоотой үндсэн эрх бол хувийн мэдээллийг хамгаалах явдал юм. Энэхүү санаачлагыг дагаж мөрдөхийн тулд хувийн мэдээллийг боловсруулах шаардлагатай бол энэхүү боловсруулалт нь энэхүү саналд өртсөн бүх төлбөрийн үйлчилгээнд шууд хамаарах Ерөнхий мэдээлэл хамгаалалтын журам (GDPR)²⁴-ийг дагаж мөрдөх ёстой.

- **Шинэ журам гаргах, хуучин журмыг хүчингүй болгох буюу “Нэгийг харьцах нэг” зарчмыг хэрэгжүүлэх.**

Энэхүү санаачилга нь ТҮҮ2 -д тусгаагүй тайлагналын шинэ үүрэг эсвэл ТҮҮ-д тавих хяналт, шалгалтыг нэмэгдүүлэхэд хүргэхгүй тул бизнес болон хэрэглэгчдэд удирдлагын шинэ зардал гаргахгүй. Мөн энэхүү санаачилгатай холбоотой зохицуулалтын төлбөр, хураамж байхгүй. Комиссийн зүгээс энэхүү санаачилга нь шинэ эрх зүйн баримт гаргахад хуучин эрх зүйн баримт бичгийг хүчингүй болгох “нэгийг харьцах нэг” зарчимтай хобоотойгоор гарах зардлыг үүсгэхгүй боловч шинэ эрх зүйн баримт бичгийг нэвтрүүлэх, хэрэгжүүлэхтэй холбоотой зардал үүсгэхийг үгүйсгэхгүй гэж үзэж байна. ЦМБ болон ТБ-ийн хууль тогтоомжийг нэгтгэх нь, тухайлбал тодорхой нөхцөл байдалд шинээр лиценз авах шалгуурыг зөөллөх, чөлөөлөх зэрэг арга хэмжээ нь удирдлагын зардлыг бууруулах юм гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

- **Уур амьсгал ба тогтвортой байдал**

Энэхүү санаачилгаас үүдэлтэй дэлхийн уур амьсгалд үзүүлэх ямар нэгэн сөрөг нөлөө илрээгүй. Энэхүү санаачилга нь НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилт 8.2: “*Өндөр нэмүү өртөг шингэсэн, хөдөлмөр их шаарддаг салбаруудад анхаарлаа төвлөрүүлэх болон эдийн засгийг төрөлжүүлэх, технологийн шинэчлэл, инноваци хийх замаар эдийн засгийн бүтээмжийн өндөр түвшинд хүрэх*”-д хувь нэмэр оруулах болно.

²⁴ 27-ны өдрийн Европын Парламент болон Зөвлөлийн (ЕХ)2016/679 тоот Хувийн мэдээллийг боловсруулахтай холбоотой хувийн мэдээллийг хамгаалах, эдгээр мэдээллийг чөлөөтэй шилжүүлэх тухай журам.

4. ТӨСӨВТ ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛ

Энэхүү санал нь ЕХ-ны төсөвт ямар ч нөлөө үзүүлэхгүй.

5. БУСАД ЗҮЙЛ

- **Хэрэгжүүлэх төлөвлөгөө болон хяналт-шинжилгээ, үнэлгээ, тайлангийн зохицуулалт**

Санал нь хүчин төгөлдөр болсноос хойш 5 жилийн дараа эргэн хянан хэлэлцэгдэхээр тусгагдсан.

- **Саналын тодорхой заалтуудын талаар дэлгэрэнгүй тайлбар**

Төлбөрийн байгууллагуудад тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих тухай удирдамжийн энэхүү санал нь зөвхөн төлбөрийн байгууллагуудад хамаарах "Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч"-ийн тухай ТҮҮ2-ын Гарчиг II дээр үндэслэсэн болно. Энэ нь ТБ-тай холбоотой заалтуудыг шинэчилж, тодруулж, өмнөх ЦМУ-г ТБ-н дэд ангилал болгон нэгтгэсэн (үүний улмаас 2009/110/ЕС цахим мөнгөний удирдамжийг хүчингүй болгосон). Цаашилбал, жижиглэн худалдаачид (худалдан авалтгүйгээр) эсвэл бие даасан АТМ байршуулагчдаас бэлэн мөнгө авах үйлчилгээтэй холбоотой заалтуудыг багтаасан бөгөөд Төлбөр тооцоог эцэслэх удирдамж(98/26/ЕС удирдамж)-г өөрчилсөн.

- **Саналын хамрах хүрээ, тодорхойлолт**

Энэхүү санал нь Төлбөрийн байгууллагуудын (зээлийн байгууллага биш) төлбөрийн болон цахим мөнгөний үйлчилгээнд хамрагдах үйл ажиллагаатай холбоотой. Саналыг дагалдах журмын төсөлд хэд хэдэн үндсэн тодорхойлолтыг тодорхой болгож, уялдуулан оруулсан болно.

- **Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийн лиценз, хяналт**

Лицензийн хүсэлтийг татан буулгах төлөвлөгөөний хамт ирүүлэх өөрчлөлтийг эс тооцвол лицензийн хүсэлт гаргах болон хувьцаа эзэмшлийн хяналтын үйл явц ТҮҮ2-с ерөнхийдөө өөрчлөгдөөгүй ба энэхүү өөрчлөлт нь төлбөрийн болон цахим мөнгөний үйлчилгээний аль алиныг үзүүлдэг байгууллагуудын хэрэглээний стандартыг хангадаг.

Бусад өөрчлөлтүүдийг дурьдвал, Төлбөр эхлүүлэх үйлчилгээ үзүүлэгч болон дансны мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч нь тусгай зөвшөөрлийн шатанд өмнөх туршлагыг харгалзан үзэхэд мэргэжлийн хариуцлагын даатгалд хамрагдах шаардлагыг биелүүлэхэд хүндрэлтэй байж болзошгүй тул мэргэжлийн хариуцлагын даатгалд бус эхлэлтийн хөрөнгөтэй байж болно гэдгийг хүлээн зөвшөөрсөн. ТҮҮ2-г нэвтрүүлснээс хойш эхлэлтийн хөрөнгөд тавигдах шаардлагыг инфляцийн өөрчлөлттэй уялдуулан шинэчлэгдсэн (Төлбөр эхлүүлэх үйлчилгээ үзүүлэгч нь харьцангуй богино хугацаанд ажиллаж байгаа тул энэ нь тохиромжгүй гэж үзсэн). ТҮҮ2-д хамрагдсан төлбөрийн байгууллагууд эсвэл хуучин цахим мөнгөний байгууллагуудын хувьд өөрийн хөрөнгийг тооцоолох боломжит аргууд өөрчлөгдөөгүй; Өөрийн хөрөнгийг тооцоолох гурван боломжит аргын аль нэгийг

өрсөлдөөний тэгш байдлыг нэмэгдүүлэхийн тулд үндсэн хувилбар гэж үзэхийг заасан боловч зарим бизнесийн загваруудад энэхүү стандартаас чөлөөлсөн.

Төлбөрийн байгууллагуудын аюулгүй байдлын дүрэм өөрчлөгдөөгүй боловч ТҮҮ нь Төв банк дахь дансанд хөрөнгөө байршуулах (заавал бус) боломжийг нээсэн ба иймэрхүү төрлийн боломжуудын хүрээг нэмэгдүүлэх, түүнчлэн “аюулгүй” дансанд хөрөнгө төвлөрүүлэх эрсдлээс зайлсхийх шаардлагатайг нэмж оруулсан. Үүнтэй холбогдуулан хамгаалагдсан хөрөнгийн эрсдэлийн удирдлагын талаархи зохицуулалтын техникийн стандартыг Европын Банкны Газраас гаргах болно. Цахим мөнгөний үйлчилгээ үзүүлдэг төлбөрийн байгууллагуудын хувьд аюулгүй байдлын дүрмийг зөвхөн төлбөрийн үйлчилгээ үзүүлдэг төлбөрийн байгууллагуудад хамаарах дүрэм журамтай бүрэн нийцүүлсэн. Төлбөрийн байгууллагуудын дотоод засаглалын талаар илүү нарийвчилсан заалтуудыг тусгасан журмыг нэвтрүүлсэн ба үүнд Европын Банкны Газрын зөвлөмжийг оруулсан болно. Агентууд, салбарууд болон аутсорсингийн талаарх заалтууд ТҮҮ2-с өөрчлөгдөөгүй боловч цахим мөнгө түгээгчийн шинэ тодорхойлолт болон агентуудад хамаарах заалтуудтай нягт уялдсан холбогдох заалтуудыг нэмсэн. ТБ-аас хил дамнасан үйлчилгээ үзүүлэх тухай заалтууд, эдгээр үйлчилгээнд тавих хяналт нь ерөнхийдөө өөрчлөгдөөгүй байна.

ҮБ-ууд төлөөлөгч, дистрибьютер, салбараа ашигладаг байгууллага байгуулах эрх, үйлчилгээ үзүүлэх эрх чөлөөний тухайд гурван гишүүн улс (ТМ-ийг үүсгэн байгуулсан гишүүн улс, тус улсын гишүүн улс) оролцож байгаа тохиолдолд тусгай заалтуудыг тусгасан болно. төлөөлөгч, мөн төлөөлөгч нь хил дамнасан үндсэн дээр үйлчилгээ үзүүлдэг гуравдагч гишүүн улс), ингэснээр тодорхой байдлыг нэмэгдүүлнэ. ТБ-ууд төлөөлөгч, дистрибьютер, нэгдмэл сонирхолтой этгээдийг ашиглан үүсгэн байгуулах болон үйлчилгээ үзүүлэх эрх чөлөөг хэрэгжүүлэх үед гурван гишүүн улс (төлөөлөгчийн ТБ байгуулагдсан гишүүн улс, төлөөлөгчийн гишүүн улс болон төлөөлөгч нь хил дамнасан үндсэн дээр үйлчилгээ үзүүлдэг ЕХ-ны гуравдагч улс) оролцох тохиолдолд тусгай заалтуудыг тусгаж тодорхой байдлыг нэмэгдүүлсэн.

Гишүүн улсууд болон Европын банкны газар нь эрх бүхий төлбөрийн байгууллагуудын бүртгэлийг үргэлжлүүлэн хөтөлж, үүнээс гадна машинаар уншигдах боломжтой төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэгч болон дансны мэдээллийн үйлчилгээ үзүүлэгчдийн жагсаалтыг боловсруулах болно.

ТҮҮ2 болон Цахим мөнгөний удирдамжид Гишүүн орнууд тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих зохих эрх мэдэл бүхий эрх бүхий байгууллагуудыг томилох ёстой. Үндэсний эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагааны талаарх дүрмийг тодорхой болгож, бусад Үндэсний эрх бүхий байгууллагуудын хооронд гарч болзошгүй санал зөрөлдөөнийг шийдвэрлэхэд Евродын Банкны Газраас тусламж хүсэх боломжийг нэмж тусгасан. ТҮҮ2-т дансны мэдээллийн үйлчилгээ эрхэлдэг Төлбөрийн байгууллага нь зөвшөөрлийн үндсэн дээр бус бүртгэлийн үндсэн дээр үйл ажиллагаа явуулах шаардлага тавигдсан бөгөөд энэхүү саналд бүртгүүлэх хүсэлт гаргах өргөдөлд хавсаргах бичиг баримтыг зааж өгсөн болно. Дансны мэдээллийн үйлчилгээ үзүүлэгчид эрх бүхий байгууллагуудын хяналтад байх зохицуулалт хэвээрээ хадгалагдсан. Гишүүн орнуудаас жижиг төлбөрийн байгууллагуудыг зарим заалтын шалгуураас чөлөөлөх боломжууд өөрчлөгдөөгүй хэвээр байна.

- **Бэлэн мөнгө авах тухай заалтууд**

Жижиглэнгийн дэлгүүрүүд дэх операторууд өөрсдийн байранд худалдан авалт хийхгүйгээр 50 еврогоос хэтрэхгүй бэлэн мөнгө авах үйлчилгээ үзүүлдэг бол төлбөрийн байгууллагын лиценз авах шаардлагаас чөлөөлөгдөх боловч үүнийг сайн дурын үндсэн дээр хийх ёстой. Энэхүү чөлөөлөлт нь АТМ байршуулагчидтай шударга бус өрсөлдөөнөөс урьдчилан сэргийлэх зорилготой юм. Төлбөрийн дансанд үйлчилгээ үзүүлдэггүй АТМ-аар дамжуулан бэлэн мөнгө түгээгч ("бие даасан АТМ байршуулагч" гэж нэрлэдэг) нь төлбөрийн байгууллагуудын тусгай зөвшөөрөл авах шаардлагаас чөлөөлөгддөг бөгөөд зөвхөн бүртгэлийн шаардлагыг хангах ёстой. Бүртгэлийн явцад тодорхой бичиг баримт бүрдүүлсний үндсэн дээр бүртгэлд хамрагдана.

- **Шилжилтийн үеийн заалтууд**

Хуулийн тусгай зөвшөөрлийн шинэ дэглэм бий болсон нөхцөлд ТҮУ2-ын хүрээнд одоо байгаа үйл ажиллагаатай холбоотой шилжилтийн арга хэмжээ нь тохиромжтой. Жишээлбэл, одоо байгаа ТБ болон ЦМБ-н лицензийг энэхүү удирдамжийн дагуу тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүчин төгөлдөр болсноос хойш 24 сарын дотор гаргасан тохиолдолд 30 сар хүртэл (шилжүүлэх, өргөдөл гаргах эцсийн хугацаанаас хойш нэг жилийн дараа) сунгана.

- **Бусад хууль тогтоомжийг хүчингүй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах**

Цахим мөнгөний удирдамж 2 (Удирдамж 2009/110/ЕС) нь энэхүү удирдамжиж эхэлсэн өдрөөс хүчингүй болсон.

Төлбөрийн үйлчилгээний удирдамж 2 (Удирдамж 2015/2366/ЕС) мөн адил тухайн өдрөөс хүчингүй болсон. Хуулийн тасралтгүй байдлыг хангах үүднээс ТҮУ2 болон ЦМУ2-ын харгалзах зүйлд хамаарах нийтлэлүүдийн хүснэгтийг хавсаргав.

Энэхүү удирдамжийн дагуу Гишүүн улсаас тогтоосон төлбөрийн системд шууд оролцох боломжтой (гэхдээ үнэт цаасны төлбөр тооцооны тусгай системд хамаарахгүй) байгууллагуудын жагсаалтад ТБ-г нэмэхийн тулд Төлбөр тооцоо эцэслэх удирдамжид (98/26/ЕС Захирамж) нэмэлт өөрчлөлт оруулсан. Түүнчлэн Төлбөр тооцоог эцэслэх удирдамжид шууд бус оролцооны тодорхойлолтыг Удирдамж (ЕХ)2019/879²⁵-р өөрчилсөн байсныг 2019 оноос өмнөх тодорхойлолтоор буцаан оруулсан өөрчлөлт хийгдсэн.

47 дугаар зүйлд санхүүгийн мэдээлэлд нэвтрэх тухай (ЕХ) 20../ зохицуулалтыг хамрах хүрээнд (ЕХ) 2020/1828 удирдамжид нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгасан. Энэхүү нэмэлт, өөрчлөлтийн үр дүнд дээрх журмыг зөрчсөн тохиолдолд хуулийн дагуу арга хэмжээ авах боломжтой болох юм.

²⁵ Зээлийн байгууллага болон хөрөнгө оруулалтын компаниудын алдагдлыг шингээх, дахин хөрөнгөжүүлэх чадавхитай холбоотой 2014/59/ЕХ-ны удирдамжид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2019 оны 5-р сарын 20-ны өдрийн (ЕХ) 2019/879 тоот болон 98/26/ЕС удирдамжууд.

- **Бусад заалтууд**

Төлөөллийн хууль (Delegated Act)-р инфляцийг харгалзан өөрийн хөрөнгийн хэмжээг шинэчлэх эрх Комиссд байдаг. Уг удирдамж нь “бүрэн уялдсан” (full harmonization - бүх гишүүн улсууд нэг бүрчлэн баталж, дагаж мөрдөх ёстой нарийвчилсан, тодорхой дүрэм бөгөөд тус удирдамжид тусгагдсан бүс нутгуудад нэмэлт, эсвэл ялгаатай үндэсний дүрмийг хэрэгжүүлэх боломжийг гишүүн улс бүрд маш бага эсвэл огт үлдээдэггүй гэсэн утгатай. Орч.тэмд). Энэхүү удирдамж Official Journal албан ёсны сэтгүүлд нийтлэгдсэнээс хойш 20 хоногийн дараа хүчин төгөлдөр болно.

Гишүүн орнууд энэхүү удирдамжийг хүчин төгөлдөр болсноос хойш 18 (ТТЭУ-д нэмэлт, өөрчлөлт оруулахаас бусад тохиолдолд 6 сар байна) сарын дотор баталж, хэрэгжүүлэх ёстой. Удирдамж хүчин төгөлдөр болсноос хойш 5 жилийн дараа хяналтын тайланг танилцуулах ёстой бөгөөд энэ нь удирдамжийн хамрах хүрээний зохистой байдал, төлбөрийн систем, техникийн үйлчилгээг өргөтгөх боломж, төлбөрийн хамгаалалтад үзүүлэх нөлөө зэрэгт анхаарлаа хандуулах ёстой. 2023 оны 4-р сарын 18²⁶-ны өдөр Комиссоос санал болгосон дүрмийн сангууд нь батлагдвал хадгаламжийн баталгааны тогтолцооны тухай Европын Парламент болон Комиссийн 2014/49/ЕХ-ны 2014/49/ЕХ-ны удирдамжид нэмэлт өөрчлөлт оруулах болно.

**ЕВРОПЫН ПАРЛАМЕНТ БОЛОН ЕВРОПЫН ХОЛБООНЫ КОМИССИЙН
дотоод зах зээл дэх төлбөрийн болон цахим мөнгөний үйлчилгээний Удирдамж
98/26/ЕС-д нэмэлт өөрчлөлт оруулах болон Удирдамж 2015/2366/ЕХ болон
2009/110/ЕС-г хүчингүй болгох
санал**

(ЕЭЗБ-д хамааралтай текст)

ЕВРОПЫН ПАРЛАМЕНТ БОЛОН ЕВРОПЫН ХОЛБООНЫ КОМИСС НЬ

Европын Холбооны үйл ажиллагааны тухай гэрээ болон гэрээний 53 болон 114 дүгээр зүйл,

Европын холбооны Комиссийн санал,

Үндэсний парламентад Хууль тогтоомжийн төслийг хүргүүлсэн,

Европын холбооны Эдийн засаг, Нийгмийн хорооны²⁷ санал,

Бүс нутгийн²⁸ хороодын санал,

Европын эдийн засаг, нийгмийн хорооны санал болон
Хууль тогтоох ердийн журмын дагуу ажиллах зэргийг харгалзсан үзсэний үндсэн дээр:

²⁶ СОМ(2023)228 финал.

²⁷ ОJ C , , р . .

²⁸ ОJ C , , р . .

- (1) Европын Парламент болон Комиссийн ²⁹ (ЕХ) 2015/2366 тоот удирдамжийг баталснаас хойш жижиглэнгийн төлбөрийн үйлчилгээний зах зээлд карт болон бусад дижитал төлбөрийн хэрэгслийн хэрэглээ нэмэгдэж, бэлэн мөнгөний хэрэглээ багасч, төлбөрийн чадвар буурсантай холбоотой дижитал түрийвч, контактгүй төлбөр зэрэг шинэ тоглогчид, үйлчилгээнүүд нэмэгдэж томоохон өөрчлөлтүүд гарсан. Ковид-19 цар тахал болон түүний төлбөрийн хэрэглээ болон төлбөрийн практикт авчирсан өөрчлөлтүүд нь найдвартай, үр ашигтай дижитал төлбөр тооцооны ач холбогдлыг нэмэгдүүлсэн.
- (2) ЕХ-ны Жижиглэнгийн төлбөрийн стратегийн³⁰ тухай Комиссийн мэдэгдэл "Үүнд зах зээлийн хөгжлийг харгалзан зорилгодоо нийцэж байгаа эсэх талаар ерөнхий үнэлгээ орсон байх ёстой" хэмээн Удирдамж (ЕХ) 2015/2366-н хэрэглээ, үр нөлөөг иж бүрэн хянаж эхэлснийг зарлав.
- (3) (ЕХ) 2015/2366 тоот заавар нь төлбөрийн шинэ төрлийн үйлчилгээнд учирч буй саад бэрхшээлийг арилгах, хэрэглэгчийн хамгаалалт, аюулгүй байдлын түвшинг дээшлүүлэхэд чиглэгддэг. Комиссоос гаргасан (ЕХ) 2015/2366 тоот удирдамжийн нөлөөлөл, хэрэгжилтийн үнэлгээний үр дүнд (ЕХ) 2015/2366 удирдамж нь олон зорилттойгоо уялдуулан амжилттай хэрэгжсэн болвч уг удирдамжийн зорилгод хүрч чадаагүй зарит нэг хэсгийг мөн тодорхойлсон байна. Тодруулбал, үнэлгээгээр (ЕХ) 2015/2366 тоот удирдамжийн хэрэгжилт гишүүн орнуудад харилцан адилгүй хэрэгжиж, мөрдөгдөж байгаа нь зохицуулалтын янз бүрийн нөхцөл байдалд хүргэж байгааг үнэлгээгээр тогтоосон. Энэхүү үл нийцэл нь төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийн дунд зохицуулалтын орчны ялгааг ашиглах нөхцөл байдлыг үүсгэж шударга өрсөлдөөнд сөргөөр нөлөөлөх байдлыг бий болгосон байна.
- (4) Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид Холбооны илүү таатай дүрэмтэй гишүүн орнуудыг үндсэн үйл ажиллагаа болгон сонгох буюу өөрт ашигтай байдлыг сонгох "Форум худалдааны"-ы боломжийг үгүй хийх ёстой. Энэхүү практик нь тэдэнд дүрэм журмыг илүү хатуу мөрддөг эсвэл төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийн эсрэг илүү идэвхтэй хэрэгжүүлэх бодлого бүхий гишүүн орнуудад хил дамнасан үйлчилгээг санал болгох боломжийг олгодог. Энэ нь өрсөлдөөнийг гажуудуулж байна. Холбооны хүрээнд төлбөрийн үйлчилгээ явуулах нөхцөлүүдийг журам болгон нэгтгэх замаар уялдуулах ёстой. Энэ нь тэдгээрийг төлбөрийн байгууллагуудын зөвшөөрөл, хяналттай холбоотой дүрмээс тусгаарлах бөгөөд одоогийн мөрдөгдөж ТҮ удирдамж (PSD2)-н оронд шинэ ТҮ удирдамж 3 (PSD3) -аар хянагдах ёстой.

²⁹ 2002/65/ЕС, 2009/110/ЕХ болон 2013/36/ЕХ удирдамжуудад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Европын парламент болон Зөвлөлийн 2015 оны 11-р сарын 25-ны өдрийн (ЕХ) 2015/2366 тоот удирдамж, Дотоод зах зээл дэх төлбөрийн үйлчилгээний тухай, (ЕХ)1093/2010, 2007/64/ЕС удирдамжийг хүчингүй болгох тухай (OJ L 337, 2015.12.23, х. 35).

³⁰ СОМ/2020/592 эцсийн жижиглэнгийн төлбөрийн стратегийн талаар Европын парламент, Зөвлөл, Европын эдийн засаг, нийгмийн хороо, бүсүүдийн хороонд гаргасан Зөвлөлийн мэдэгдэл.

- (5) Цахим мөнгө гаргах үйл ажиллагаа нь Европын Парламент болон Комиссийн³¹ 2009/110/ЕС тоот удирдамжийн явагддаг ч төлбөрийн гүйлгээнд цахим мөнгийг ашиглах үйл ажиллагаа нь дийлэнх тохиолдолд (ЕХ) 2015/2366 тоот удирдамжаар зохицуулагддаг. Үүний үр дүнд цахим мөнгөний байгууллага, төлбөрийн байгууллагуудын хууль эрх зүйн орчин, ялангуяа бизнесийн үйл ажиллагааны дүрмийн хувьд ерөнхийдөө нийцэж байгаа. Гэсэн хэдий ч Төлбөрийн байгууллага, цахим мөнгөний байгууллагуудын зөвшөөрөл, хяналт хариуцсан эрх бүхий байгууллагууд олон жилийн туршид эдгээр хоёр горимыг тодорхой зааглаж, цахим мөнгөний бүтээгдэхүүн, үйлчилгээг төлбөрийн байгууллагаас санал болгож буй төлбөрийн болон цахим мөнгөний үйлчилгээнээс ялгахад практик хүндрэлтэй тулгарсан. Зохицуулалтын зөрүүтэй байдал нь цахим мөнгө гаргаж буй төлбөрийн байгууллагуудад төлбөрийн болон цахим мөнгөний үйлчилгээний ижил төстэй байдлыг ашиглаж тэгш бус өрсөлдөөнийг талбар бий болгох, 2009/110/ЕС-ийн удирдамжийн шаардлагуудыг тойрч гарах, төлбөрийн байгууллагын зөвшөөрөл авар зэрэг нөхцөл байдлыг үүсгэсэн. Цаашид эдгээр асуудлыг шийдвэрлэхийн цахим мөнгөний байгууллагуудад мөрдөгдөж буй зөвшөөрөл, хяналтын дэглэмийг төлбөрийн байгууллагуудад мөрдөгдөж буй горимтой уялдуулах нь зүйтэй байна. Гэсэн хэдий ч лицензийн шаардлага, тухайлбал, эхлэлтийн хөрөнгө, өөрийн хөрөнгө, цахим мөнгөний бизнесийг зохицуулах зарим үндсэн ойлголтууд, тухайлбал цахим мөнгө гаргах, цахим мөнгө тараах, эргүүлэн авах зэрэг нь төлбөрийн байгууллагаас үзүүлж буй үйлчилгээнээс ялгаатай байдаг. Тиймээс (ЕХ) 2015/2366 болон 2009/110/ЕС удирдамжийн заалтуудыг нэгтгэхдээ эдгээр онцлог шинж чанаруудыг хадгалах нь зүйтэй.
- (6) Хорооноос хийсэн хяналт шалгалтын дүнгээс харахад тухайн зах зээл, аж ахуйн нэгжийн хувьсал өөрчлөлт, үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийг харгалзан төлбөрийн байгууллагууд, тэр дундаа цахим мөнгө гаргах, цахим мөнгөний үйлчилгээ эрхэлдэг хадгаламж авдаггүй байгууллагуудаас төлбөрийн үйлчилгээ, цахим мөнгөний үйлчилгээнд зөвхөн нэг лиценз шаарддаг байхаар шалгуурын горимыг шинэчлэх шаардлагатай байна. Европын Парламент болон Комиссийн³² (ЕХ) 2023/1114 тоот журмын 48 дугаар зүйлийн 2-т цахим мөнгө гаргагчдыг цахим мөнгө гэж үзнэ гэж заасан байдаг ба төлбөрийн үйлчилгээний байгууллагуудад олгох лиценз нь цахим мөнгөний үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудад олгох лицензийг орлох тул тус журам нь цахим мөнгөний токен гаргагчдад мөн адил хамаарах ёстой. Хадгаламж хүлээн авдаггүй, төлбөрийн үйлчилгээ үзүүлдэг хуулийн этгээдийн үйл ажиллагаа хэд хэдэн хатуу, иж бүрэн нөхцөлүүд бүхий шалгуур үзүүлэлтүүдэд үндэслэсэн олгогдсон зөвшөөрөөл байх ёстой. Төлбөрийн байгууллагуудад мөрдөгдөж буй зохистой дэглэм нь Холбооны хэмжээнд төлбөрийн үйлчилгээний үйл ажиллагаанд ижил нөхцөл үйлчлэхийг баталгаажуулах ёстой.

³¹ 2009 оны 9-р сарын 16-ны өдрийн Европын Парламент болон Зөвлөлийн 2009/110/ЕС-ийн удирдамж, цахим мөнгөний байгууллагуудын үйл ажиллагааг эхлүүлэх, хэрэгжүүлэх, зохистой хяналт тавих, 2005/60/ЕС болон 2006/48/ЕС удирдамжид нэмэлт, өөрчлөлт оруулах, 2000/46 удирдамжийг хүчингүй болгох. /ЕС (OZh L 267, 2009.10.10, хуудас 7).

³² Европын Парламент болон Зөвлөлийн 2023 оны 5-р сарын 31-ний өдрийн 2023/1114 тоот крипто хөрөнгийн зах зээлийн тухай журам (ЕХ) 1093/2010, (ЕХ) 1095/2010, 2013/36/-ын удирдамжид нэмэлт өөрчлөлт оруулах тухай. ЕХ ба (ЕХ) 2019/1937 (OJ L 150, 06/09/2023, хуудас 40).

- (7) Төлбөрийн данснаас бэлэн мөнгө гаргах үйлчилгээ эрхлэгчид төлбөрийн дансанд үйлчилгээ үзүүлэхгүй тул төлбөрийн данснаас бэлэн мөнгө авах үйлчилгээг төлбөрийн дансанд үйлчлэх үйл ажиллагаанаас салгах нь зүйтэй. (ЕХ) 2015/2366 тоот Удирдамжийн Хавсралтын 5-р зүйлд төлбөрийн хэрэгсэл гаргах болон төлбөрийн гүйлгээг хүлээн авах үйлчилгээ нь нэгийг нь авахгүйгээр нөгөөг нь санал болгох боломжгүй мэтээр хамтад нь жагсаасан байгааг салгаж хоёр өөр төлбөрийн үйлчилгээ хэлбэрээр танилцуулах ёстой. Төлбөрийн хэрэгсэл гаргах болон төлбөрийн гүйлгээг хүлээн авах үйлчилгээ тус бүрд нарийн тодорхойлолт өгснөөр төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь бие биенээсээ хамааралгүйгээр үйлчилгээ үзүүлж чадна гэдгийг тодорхой болох юм.
- (8) Жижиглэнгийн төлбөрийн зах зээлийн хурдацтай өөрчлөлт, төлбөрийн шинэ үйлчилгээ, шийдлүүдийг тасралтгүй нэвтрүүлж буйг харгалзан (ЕХ) 2015/2366-д заасан тодорхой тодорхойлолтуудыг шинэчлэх шаардлагатай байгаа бөгөөд үүнд төлбөрийн данс, сан, төлбөрийн хэрэгслийн тодорхойлолтыг зах зээлийн динамиктай уялдуулан өөрчлөх шаардлагатай. Үүний зорилго нь Холбооны хууль тогтоомжийг үр дүнтэй, технологийн дэвшилд дасан зохицох чадвартай хэвээр байлгахын зэрэгцээ төрөл бүрийн технологид төвийг сахисан байр суурийг баримтлах явдал юм.
- (9) Комиссийн (ЕХ)2015/2366 тоот удирдамжийн хэрэгжилтийн талаарх санал болон ЕБГ-ын 2022 оны 6-р сарын 23-ны өдрийн 2015 оны удирдамжийг хянан үзсэн талаар гаргасан дүгнэлтийн зөрүүтэй байр суурийг харгалзан төлбөрийн дансны тодорхойлолтыг тодруулах шаардлагатай байна. Дансыг төлбөрийн данс гэж ангилах шалгуур нь ийм данснаас өдөр тутмын төлбөрийн гүйлгээ хийх чадвар юм. Гуравдагч этгээдэд данснаас төлбөрийн гүйлгээ хийх, эсвэл гуравдагч этгээдийн хийсэн гүйлгээний үр шимийг хүртэх боломж нь төлбөрийн дансны ойлголтыг тодорхойлох шинж чанар юм. Тиймээс төлбөрийн дансыг гуравдагч этгээдэд мөнгө илгээх, хүлээн авахад ашигладаг данс гэж тодорхойлох ёстой. Эдгээр шинж чанарыг агуулсан аливаа дансыг төлбөрийн данс гэж үзэж, төлбөр эхлүүлэх, дансны мэдээллийн үйлчилгээ үзүүлэхийн тулд хандах ёстой. Гуравдагч этгээдээс болон гуравдагч этгээдтэй төлбөрийн гүйлгээ хийхэд өөр зуучлагч данс шаардлагатай нөхцөл байдал нь төлбөрийн дансны тодорхойлолтод хамаарах ёсгүй. Хадгаламжийн дансыг гуравдагч этгээдэд мөнгө илгээх, хүлээн авахад ашигладаггүй тул төлбөрийн дансны тодорхойлолтод оруулаагүй болно.
- (10) Төлбөрийн хэрэглүүрүүдийн шинэ төрлүүд бий болж, тэдгээрийн хууль эрх зүйн чадамжийн хувьд зах зээлд тодорхой бус байдал бий болж байгаа тул "төлбөрийн хэрэгсэл"-ийн тодорхойлолтыг төлбөрийн хэрэгсэлд юу хамаарах, юу хамаарахгүй байх талаар дэлгэрэнгүй тайлбарлах хэрэгтэй бөгөөд ингэхдээ технологийн төвийг сахих зарчмыг баримтлах шаардлагатай.
- (11) Ойролцоох талбарт харилцаа холбоо (NFC) нь төлбөрийн гүйлгээг эхлүүлэхэд тус дөхөм болдог хэдий ч үүнийг бүрэн “төлбөрийн хэрэгсэл” болгон тодорхойлох нь тодорхой бэрхшээлүүдийг дагуулдаг. Үүнд борлуулалтын цэг дээр контактгүй төлбөр хийх Хэрэглэгчийн найдвартай баталгаажуулалтыг хэрэгжүүлэх, төлбөрийн

үйлчилгээ үзүүлэгчдийн хариуцлагын дэглэмийг тодорхойлох зэрэг багтана. Тиймээс Ойролцоох талбарт харилцаа холбоо(NFC)-ийг төлбөрийн хэрэгсэл биш харин төлбөрийн хэрэгслийн функц гэж үзэх нь зүйтэй.

- (12) Удирдамж (ЕХ)2015/2366-д заасан "төлбөрийн хэрэгсэл"-ийн одоогийн тодорхойлолтод "хувийн төхөөрөмж" гэж дурдсан байдаг. Зарим урьдчилсан төлбөрт картууд нь карт эзэмшигчийн нэрийг харуулдаггүй тул энэ хэллэг нь асуудал үүсгэж болзошгүй юм. Энэ нь ийм картуудыг төлбөрийн хэрэгслийн тодорхойлолтод оруулахгүй байж болно. Үүнийг шийдвэрлэхийн тулд тодорхойлолтыг шинэчилж, "хувийн" гэхийн оронд "хувь хүний" гэсэн нэр томъёог ашиглах хэрэгтэй. Энэхүү нэмэлт өөрчлөлтөд төлбөрийн хэрэгслийн хүрээнд карт эзэмшигчийн нэрийг бичээгүй урьдчилсан төлбөрт картуудыг тодорхой тусгана.
- (13) Одоо байгаа төлбөрийн хэрэгсэл, түүний дотор төлбөрийн картыг токенжуулахтай холбоотой дижитал "дамжуулах түрийвч"-г техникийн үйлчилгээнд тооцож төлбөрийн хэрэгслийн тодорхойлолтоос хасах хэрэгтэй. Учир нь токенийг төлбөрийн хэрэгсэл гэж үзэхээс илүүтэйгээр Европын Парламент болон Комиссийн³³ (ЕХ) 2015/75 тоот Журмын 2-р зүйлийн 21-д заасны дагуу төлбөрийн хэрэглүүр юм. Гэсэн хэдий ч хэрэглэгчид ирээдүйн онлайн гүйлгээнд зориулж мөнгө хадгалах боломжтой "үе шаттай түрийвч" гэх мэт урьдчилсан төлбөрт цахим түрийвч зэрэг бусад төрлийн дижитал түрийвчийг төлбөрийн хэрэгсэл гэж үзэх бөгөөд тэдгээрийг гаргах нь төлбөрийн үйлчилгээнд хамрагдах ёстой.
- (14) Мөнгө гуйвуулга гэдэг нь төлбөр төлөгчөөс төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид өгдөг бэлэн мөнгөтэй холбоотой төлбөрийн үйлчилгээ юм. Энэ процесст төлбөр төлөгч болон төлбөр авагчийн нэр дээр төлбөрийн данс үүсгэдэггүй. Үүний оронд төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь төлбөр хүлээн авагч эсвэл төлбөр хүлээн авагчийн өмнөөс үйл ажиллагаа явуулж буй өөр төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч рүү харгалзах дүнг шилжүүлдэг. Зарим Гишүүн орнуудад супермаркетууд, худалдаачид болон бусад жижиглэнгийн худалдаачид нийтийн үйлчилгээний болон бусад ердийн өрхийн орон сууцны хэрэглээний төлбөрийг төлөх боломжтой үйлчилгээг иргэдэд үзүүлдэг. Энэхүү хэрэглээний төлбөрийн үйлчилгээг мөнгө гуйвуулга гэж үзэх ёстой.
- (15) Сангийн тодорхойлолтод Төв банкны жижиглэнгийн хэрэглээнд зориулан гаргасан мөнгөн тэмдэгт, зоос, ирээдүйд гаргах Төв банкны дижитал валют, цахим мөнгө, арилжааны банкны мөнгө зэрэг бүх хэлбэрийг хамруулах ёстой. Төв банк болон арилжааны банкуудын хооронд ашиглах, өөрөөр хэлбэл бөөний худалдаанд зориулж гаргасан Төв банкны мөнгө (Төв банк, арилжааны банк хоорондын томоохон хэмжээний гүйлгээ, төлбөр тооцоонд голчлон ашиглагддаг мөнгийг хэлнэ. Орч.тэмд)-ийг хамруулж болохгүй юм.

³³ 2015 оны 4-р сарын 29-ний өдрийн Европын Парламент болон Зөвлөлийн (ЕХ) 2015/751 тоот Карт ашиглан хийсэн төлбөрийн гүйлгээний банк хоорондын шимтгэлийн тухай журам (OJ L 123, 2015 оны 5-р сарын 19, х. 1).

- (16) 2023 оны 5-р сарын 31-ний өдрийн (ЕХ) 2023/1114 тоот журамд цахим мөнгөний токеныг цахим мөнгө гэж үзэхээр заасан. Тиймээс цахим мөнгөний токеныг сангийн тодорхойлолтод цахим мөнгө болгон оруулах ёстой.
- (17) (ЕХ) 2015/2366 тоот удирдамжийн хэрэгжилтийн үнэлгээ нь төлбөрийн байгууллага эсвэл цахим мөнгөний байгууллагын зөвшөөрөл авах шалгуур, зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулах шалгуур зэрэгт томоохон өөрчлөлт оруулах нарийвчилсан шаардлагыг тодорхойлоогүй. Эдгээр шалгуурыг Европын парламент, Комиссийн³⁴ 2007/64/ЕХ тоот удирдамж, төлбөрийн байгууллага болон цахим мөнгөний байгууллагуудын тухай 2015/2366/ЕХ, цахим мөнгөний байгууллагуудын тухай 2009/110/ЕХ тоот удирдамжид тус тус тусгасан. Эдгээр нөхцлүүд нь төлбөрийн байгууллагууд, тэр дундаа цахим мөнгө гаргах болон түүнтэй холбоотой үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудад учирч буй үйл ажиллагааны болон санхүүгийн эрсдэлд тохирсон зохистой хэм хэмжээг хамарсан хэвээр байна. Төлбөрийн байгууллагын хувьд зөвшөөрөл авах өргөдөл гаргахад шаардагдах баримт бичиг татан буулгах төлөвлөгөөг оруулах замаар сайжруулахыг зөвлөж байна. Ирээдүйн төлбөрийн байгууллагын тодорхой бизнесийн загварт тохирсон энэхүү төлөвлөгөө нь дампуурлын нөхцөл байдал үүссэн үед үйл ажиллагаагаа цэгцтэй зогсооход туслах зорилготой байх ёстой. Түүнчлэн, татан буулгах төлөвлөгөө нь холбогдох үндэсний хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагааг жигд зогсооход тохиромжтой байх ёстой. Үүнд аутсорсинг үйлчилгээ үзүүлэгч, агент, дистрибьютерийн гүйцэтгэсэн аливаа чухал үйл ажиллагааны тасралтгүй байдал, сэргэлтийг хангах зэрэг орно. Төлбөрийн байгууллага эрхлэхээр төлөвлөөгүй үйлчилгээнд зөвшөөрөл олгохоос урьдчилан сэргийлэхийн тулд төлбөрийн байгууллагын үйл ажиллагааны хүрээнд хамаарахгүй төлбөрийн үйлчилгээнд зөвшөөрөл авах шаардлагагүй гэдгийг тодруулах нь чухал юм.
- (18) 2023 оны 1-р³⁵ сард нийтлэгдсэн (ЕХ) 2015/2366 тоот удирдамжийн дагуу Европын банкны газраас зөвшөөрөл олгох шалгалтын явцад түүнийг олгох үйл явцад дутагдалтай талууд илэрсэн. Энэ нь Холбооны хэмжээнд зөрчилтэй байдалд хүргэж байгаа бөгөөд зөвшөөрөл хүсэгчид төлбөрийн байгууллага эсвэл цахим мөнгөний байгууллагын лиценз авахдаа өөр өөр хяналтын хүлээлттэй тулгардаг. Нэмж дурдахад, зөвшөөрөл олгох үйл явц нь заримдаа хэтэрхий урт байж болохыг тоймд тэмдэглэв. Төлбөрийн байгууллагын тусгай зөвшөөрөл хүссэн аж ахуйн нэгжид зөвшөөрөл олгох шударга, стандартчилсан журмыг хангахын тулд эрх бүхий байгууллагад зөвшөөрөл олгох үйл явцыг 3 сарын хугацаатай байхаар тогтоох нь зүйтэй гэж үзлээ. Энэ хугацаа нь шийдвэр гаргахад шаардлагатай бүх мэдээллийг хүлээн авсан үеэс эхэлнэ. Үүний гол зорилго нь ижил төстэй нөхцөлийг бүрдүүлж, Холбооны хэмжээнд зөвшөөрөл олгох үйл явцыг хялбарчлах явдал юм.

³⁴ 97/7/ЕС, 2002/65/ЕС, 2005/60/ЕС, 2006/48/ЕС удирдамжид нэмэлт өөрчлөлт оруулах, мөн 97/5/ЕХ удирдамжийг хүчингүй болгох тухай Европын парламент болон Зөвлөлийн 2007 оны 11-р сарын 13-ны өдрийн 2007/64/ЕС тоот дотоод зах зээл дэх төлбөрийн үйлчилгээний тухай журам, (OJ L 319, 2007.12.5, хуудас 1).

³⁵ Европын Банкны Газар, ЕВА/РЕР/2023/01, ТҮҮ2-ийн дагуу зөвшөөрлийн талаарх хамтарсан үнэлгээний тайлан.

- (19) Төлбөрийн байгууллагын тусгай зөвшөөрлийн өргөдлийг шийдвэрлэхтэй холбоотой үйл явцын уялдаа холбоог сайжруулахын тулд зохицуулалтын болон техникийн стандартын төслийг боловсруулах эрхийг ЕБГ-т өгөхийг зөвлөж байна. Үүнд төлбөрийн байгууллагад зөвшөөрөл авах хүсэлт гаргахдаа эрх бүхий байгууллагад өгөх ёстой мэдээллийн тодорхойлолт, зөвшөөрөл олгох болон бүртгэхэд шаардлагатай стандарт үнэлгээний аргачлалыг боловсруулах, мэргэжлийн хариуцлагын даатгал болон үүнтэй дүйцэхүйц баталгааг тодорхойлох, мэргэжлийн хариуцлагын даатгал болон үүнтэй дүйцэхүйц баталгааны мөнгөн хэмжээний доод дүнг тогтоох зэрэг шалгуурууд орно. Энэхүү бүрэн эрхээ хэрэгжүүлэхдээ ЕБГ нь төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдэд зөвшөөрөл олгох, бүртгүүлэх журам, түүнчлэн мыг хэрэгжүүлэх явцад олж авсан мэдээлэлд тулгуурлан шийдвэр гаргана. хүсэлт гаргагчдаас шаардагдах мэдээллийн талаарх удирдамж, түүнчлэн мэргэжлийн хариуцлагын даатгал болон түүнтэй адилтгах баталгааны мөнгөн дүнгийн доод хэмжээг тодорхойлох удирдамж зэргийг хэрэгжүүлэх явцад олж авсан мэдээлэлд тулгуурлах ёстой.
- (20) Төлбөрийн байгууллагуудын зохистой зарчим нь төлбөрийн үйлчилгээний хэрэглэгчдээс хадгаламж авах эрхгүй гэсэн зарчмыг баримтлах ёстой. Тэд зөвхөн төлбөрийн үйлчилгээний хэрэглэгчдээс хүлээн авсан мөнгийг төлбөрийн үйлчилгээ үзүүлэхэд ашиглах эрхтэй. Тиймээс төлбөрийн байгууллагууд зээлийн байгууллагуудтай харьцуулахад илүү төвлөрсөн, хязгаарлагдмал үйл ажиллагаа явуулдаг гэдгээ хүлээн зөвшөөрөх нь зохистой. Үүний үр дүнд төлбөрийн байгууллагуудын үйл ажиллагаа нь зээлийн байгууллагуудын олон төрлийн үйл ажиллагаанаас илүү мэргэшсэн, хяналт тавихад хялбар байдаг тул тэдгээртэй холбоотой эрсдэлүүд илүү нарийсч, удирдах боломжтой байдаг.
- (21) Эрх бүхий байгууллагууд төлбөрийн байгууллагын тусгай зөвшөөрлийн өргөдлийг анхааралтай судалж, өргөдлийн хүрээнд ирүүлсэн засаглалын төлөвлөгөөнд онцгой анхаарал хандуулах хэрэгтэй. Төлбөрийн байгууллагууд эрсдэлийн зөв соёлыг байгууллагын бүх түвшинд нэвтрүүлэхэд хангалтгүй засаглалын бүтэцтэй зохицуулалт нь эрсдэлийн удирдлагад үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг анхаарч үзэх хэрэгтэй. Эрх бүхий байгууллагууд дотоод засаглалын зохицуулалтын хангалттай байдалд идэвхтэй хяналт тавих ёстой. ЕБГ нь төлбөрийн байгууллагуудын хэмжээ, бизнесийн загваруудын ялгаатай байдлыг харгалзан, пропорциональ зарчмыг баримтлан дотоод засаглалын зохицуулалтын талаар удирдамжийг батлах нь зүйтэй.
- (22) Зөвшөөрлийн шаардлагууд нь одоогоор мэдээлэл, харилцаа холбооны технологийн (МХТ) аюулгүй байдлын хяналт болон төлбөрийн үйлчилгээг санал болгох зөвшөөрөл авахад үзүүлэх нөлөөллийг бууруулах бүрэлдэхүүн хэсгүүдийн талаар тодорхой зохицуулалтуудыг тусгаж байгаа хэдий ч эдгээр шаардлагыг Европын парламент ба Комиссийн³⁶ (ЕХ)2022/2554 тоот журамд заасан заалтуудтай уялдуулах нь зүйтэй юм.

³⁶ Санхүүгийн салбарын дижитал үйл ажиллагааны уян хатан байдлын тухай Европын парламент болон Зөвлөлийн 2022 оны 12-р сарын 14-ний өдрийн (ЕХ) 2022/2554 тоот журам ба (ЕХ)1060/2009, (ЕХ)648/2012,

- (23) Төлбөр эхлүүлэх үйлчилгээ үзүүлэгч болон дансны мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч нь эдгээр үйлчилгээг үзүүлэхдээ харилцагчийн мөнгийг эзэмшдэггүй. Иймээс эдгээр зах зээлд оролцогчдод өөрийн хөрөнгийн шаардлага тавих нь зүй бус үйлдэл болно. Гэсэн хэдий ч төлбөр эхлүүлэх үйлчилгээ үзүүлэгч болон дансны мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд өөрсдийн үйл ажиллагаатай холбоотой хүлээсэн үүргээ биелүүлэх боломжтой байх нь чухал юм. Төлбөр эхлүүлэх эсвэл дансны мэдээллийн үйлчилгээтэй холбоотой эрсдэлийг зохих ёсоор шийдвэрлэхийн тулд эдгээр үйлчилгээг үзүүлж буй төлбөрийн байгууллагуудаас мэргэжлийн хариуцлагын даатгал эсвэл түүнтэй адилтгах баталгааг заавал хийлгэхийг зөвлөж байна. Нэмж дурдахад, ХХХ [Төлбөрийн үйлчилгээний журам-PSR] журамд заасан хариуцлагын заалтын дагуу даатгах эрсдэлийг тодорхойлсон тодорхой тодорхойлолтууд байх ёстой. Дансны мэдээллийн үйлчилгээ үзүүлэгч болон төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэгчдийн үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийг мэргэжлийн хариуцлагын даатгалд хамрагдахад тулгарч буй хүндрэлийг харгалзан эдгээр байгууллагуудад зөвхөн тусгай зөвшөөрөл олгох эсвэл бүртгэлийн шатанд мэргэжлийн хариуцлагын даатгалын нэг хувилбар болгож 50000 еврогийн эхлэлтийн хөрөнгийн сонголтыг өгөх нь зүйтэй. Тусгай зөвшөөрөл олгох, бүртгүүлэх шатанд дансны мэдээлэл, төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэгчдийн уян хатан байдал нь тухайн үйлчилгээ үзүүлэгчдийн тусгай зөвшөөрөл, бүртгэлээ авсны дараа мэргэжлийн хариуцлагын даатгалд цаг алдалгүй хамрагдах шаардлагыг хөндөхгүй байх ёстой.
- (24) Европын Парламент болон Комиссийн ³⁷ (ЕХ) 575/2013 тоот журмын дагуу төлбөрийн байгууллагын хяналтын хувьцааг эзэмших эрсдэлийг шийдвэрлэхийн тулд хувьцааны худалдан авалтын талаар холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэхийг шаардах нь зүйтэй.
- (25) Үйл ажиллагаатай холбоотой эрсдэлийг даван туулахын тулд төлбөрийн байгууллагууд хангалттай хэмжээний эхлэлтийн болон өөрийн хөрөнгөтэй байх шаардлагатай. Энэхүү удирдамжийн дагуу төлбөрийн байгууллагуудын эрхлэх олон төрлийн үйл ажиллагааг харгалзан үзээд тухайн үйлчилгээ бүрийн шинж чанар, түүнтэй холбоотой эрсдэлд үндэслэн тус бүрийн үйлчилгээний эхлэлтийн хөрөнгийн шаардлагыг тохируулах нь зүйтэй юм.
- (26) 2007/64/ЕС-ийн удирдамж батлагдсанаас хойш төлбөрийн байгууллагуудад тавигдах анхны шаардлага өөрчлөгдөөгүй хэвээр байгаа тул инфляцтай тохируулах зохицуулалт хийх нь зүйтэй. Гэсэн хэдий ч, зөвхөн төлбөр эхлүүлэх үйлчилгээ үзүүлдэг төлбөрийн байгууллагуудад хамаарах хөрөнгийн шаардлага нь (ЕХ) 2015/2366 удирдамжийг нэвтрүүлснээр л хүчин төгөлдөр болсон гэдгийг анхаарах нь

(ЕХ)600/2014, (ЕХ) 909/2014 ба (ЕХ) 2016/1011 журмуудад өөрчлөлт оруулах тухай (OJ L 333, 2022.12.27, х. 1).

³⁷ Европын парламент ба Зөвлөлийн 2013 оны 6-р сарын 26-ны өдрийн (ЕХ) №575/2013 тоот Зээлийн байгууллага, хөрөнгө оруулалтын компаниудад тавих хяналтын тухай болон (ЕХ) №648/2012 тоот журамд өөрчлөлт оруулах журам (OJ L 176, 2013.6.27, х. 1).

чухал юм. Эдгээр шаардлагууд хангалтгүй байгааг нотлох баримт байхгүй тул одоогоор өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзэж байна.

- (27) Жижиглэнгийн төлбөрийн салбар дахь олон тооны бизнесийн загварууд нь өөрийн хөрөнгийг тооцоолох янз бүрийн аргыг ашиглахыг зөвтгөдөг. Гэсэн хэдий ч эдгээр тооцоолол нь холбогдох эхлэлтийн хөрөнгийн түвшнээс доошгүй байх нь чухал юм.
- (28) Энэхүү удирдамж нь ЕХ-ны 2015/2366 тоот заавартай ижил төстэй арга барилыг баримталж, төлбөрийн үйлчилгээний бүх үйлчилгээ үзүүлэгчдийн ижил төстэй эрсдлийг шийдвэрлэхийн тулд өөрийн хөрөнгийн нэгдсэн шаардлагыг тооцоолох янз бүрийн аргуудыг ашиглах боломжийг олгодог. Төлбөрийн байгууллагын өмнөх жилийн төлбөрийн хэмжээг ашиглах нь ихэнх бизнесийн загварт хамгийн тохиромжтой, өргөн хэрэглэгддэг арга гэж тооцогддог. Өрсөлдөөний тэгш нөхцөлийг бий болгох, нэмэгдүүлэхийн тулд үндэсний эрх бүхий байгууллагууд энэ аргыг ашиглах нь зүйтэй юм. Гэсэн хэдий ч эрх бүхий байгууллагууд энэ зарчмаас хазайж, төлбөрийн байгууллагуудаас бага хэмжээний боловч өндөр дүнтэй гүйлгээ бүхий бизнесийн загварт хүргэх аргыг хэрэглэхийг шаардах боломжтой байх ёстой. Ийм бизнесийн загваруудын хууль эрх зүйн тодорхой байдлыг хангахын тулд зохицуулалтын техникийн стандартын төслийг боловсруулах эрх мэдлийг ЕБГ-д олгохыг санал болгож байна.
- (29) Төлбөрийн үйлчилгээ болон цахим мөнгөний үйлчилгээг санал болгож буй төлбөрийн байгууллагуудад тавих зохистой шалгууруудыг уялдуулах зорилго байгаа хэдий ч цахим мөнгө гаргах, цахим мөнгөний бизнесийн онцлог шинж чанарыг харгалзан үзэх нь зүйтэй гэж үзэж байна. Энэ нь цахим мөнгө гаргах, цахим мөнгөний үйлчилгээ эрхэлдэг төлбөрийн байгууллагуудад өөрсдийн хөрөнгийн хэрэгцээг тооцоолоход илүү тохиромжтой аргыг ашиглах боломжийг олгох юм.
- (30) Төлбөрийн байгууллага нь төлбөр төлөгч болон төлбөр хүлээн авагчийн аль алиных нь төлбөрийг гүйцэтгэж байгаа, төлбөр төлөгч нь зээлийн шугамаар хангагдсан зэрэг тохиолдолд төлбөр хүлээн авагчийн төлбөрийн байгууллагад хандах эрхийг төлөөлж байгаа хөрөнгийг хамгаалах нь зүйтэй.
- (31) Төлбөрийн байгууллагууд зээлийн байгууллагуудад төлбөрийн данс нээлгэх, хөтлөхөд тулгардаг хүндрэлийг харгалзан хэрэглэгчдийн мөнгийг хамгаалах нэмэлт хувилбар, тухайлбал тэдгээр хөрөнгийг төв банкинд байршуулах боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна. Гэсэн хэдий ч энэ боломж нь Төв банк өөрийн органик хуульд үндэслэн ийм сонголтыг санал болгохгүй байх боломжийг хязгаарлахгүй байх ёстой. Хэрэглэгчдийн мөнгийг хамгаалах, төлбөрийн үйлчилгээ, цахим мөнгөний үйлчилгээ үзүүлэхээс өөр зорилгоор ашиглахгүй байх шаардлагатайг харгалзан төлбөрийн үйлчилгээний хэрэглэгчийн хөрөнгийг төлбөрийн байгууллагын өөрийн хөрөнгөөс тусд нь байлгахыг шаардах нь зүйтэй. . Төлбөрийн үйлчилгээ үзүүлдэг төлбөрийн байгууллага болон цахим мөнгө гаргах, цахим мөнгөний үйлчилгээ үзүүлж буй төлбөрийн байгууллагуудын хооронд тэгш өрсөлдөөний нөхцөлийг хангахын тулд цахим төлбөрийн онцлогийг хадгалахын зэрэгцээ хэрэглэгчдийн мөнгөн хөрөнгийг хамгаалах дэглэмийг аль болох нийцүүлэх

нь зүйтэй. Төвлөрлийн эрсдэл нь төлбөрийн байгууллагуудад тулгардаг томоохон эрсдэл бөгөөд ялангуяа нэг зээлийн байгууллагад хөрөнгө хадгалагдаж байдаг. Тиймээс төлбөрийн байгууллагууд төвлөрлийн эрсдэлээс аль болох зайлсхийх нь чухал юм. Ийм учраас харилцагчийн хөрөнгийг хамгаалахад эрсдэлээс зайлсхийх техникийн зохицуулалтын стандартыг боловсруулахыг ЕБГ-т даалгах хэрэгтэй.

- (32) Төлбөрийн байгууллагуудад энэхүү удирдамжид зааснаас бусад үйл ажиллагаа явуулах, тухайлбал үндсэн үйл ажиллагаатай холбоотой туслах үйлчилгээ үзүүлэх, түүнчлэн Холбооны болон үндэсний хууль тогтоомжийн дагуу төлбөрийн системийн үйл ажиллагаа болон бусад бизнесийн үйл ажиллагаа явуулах боломжийг олгох хэрэгтэй.
- (33) Хадгаламж авах үйл ажиллагаа нь өндөр эрсдэлтэйг харгалзан төлбөрийн үйлчилгээ үзүүлдэг төлбөрийн байгууллагуудыг хэрэглэгчдээс мөнгө хүлээн авахыг хориглож, зөвхөн хэрэглэгчээс хүлээн авсан мөнгийг төлбөрийн үйлчилгээ үзүүлэхэд ашиглахыг шаардах нь зүйтэй. Цахим мөнгөний үйлчилгээ үзүүлдэг төлбөрийн байгууллагуудын төлбөрийн үйлчилгээ хэрэглэгчдээс хүлээн авсан мөнгө нь Европын Парламент, Комиссийн³⁸ 2013/36/ЕС удирдамжийн 9 дүгээр зүйлд заасны дагуу олон нийтээс хүлээн авсан хадгаламж болон бусад эргэн төлөгдөх хөрөнгө биш байх ёстой.
- (34) Төлбөрийн дансыг төлбөрийн гүйлгээ хийхээс өөр зорилгоор ашиглах боломжийг багасгахын тулд төлбөрийн байгууллагууд нэг буюу хэд хэдэн төлбөрийн үйлчилгээ, цахим мөнгөний үйлчилгээ үзүүлэхдээ зөвхөн төлбөрийг боловсруулахад зориулагдсан тусгай дансуудыг байнга хөтөлж байх ёстойг зааж өгөхийг зөвлөж байна.
- (35) Төлбөрийн байгууллагууд зээл олгох эрх мэдэлтэй байх ёстой, гэхдээ хатуу нөхцөлтэй. Тиймээс төлбөрийн байгууллагуудын зээлийн сунгалт, ялангуяа зээлийн шугам, зээлийн карт олгох хэлбэрээр зохицуулах нь зүйтэй юм. Эдгээр үйлчилгээ нь төлбөрийн үйлчилгээг хөнгөвчлөх, зээлийг 12 сараас илүүгүй хугацаагаар, түүний дотор эргэлтийн үндсэн дээр олгосон тохиолдолд энэхүү зохицуулалтыг мөрдөнө. Төлбөрийн үйлчилгээнд зориулагдсан харилцагчийн сангаас бусад төлбөрийн байгууллагын өөрийн хөрөнгө болон хөрөнгийн зах зээл дээрх бусад хөрөнгийг дахин санхүүжүүлэх тохиолдолд төлбөрийн байгууллагууд хил дамнан үйл ажиллагаандаа богино хугацааны зээл олгохыг зөвшөөрч болно. Гэсэн хэдий ч, энэхүү боломж нь нь Европын Парламент, Комиссийн³⁹ 2008/48/ЕС удирдамж болон бусад холбогдох Холбооны хууль, эсвэл хэрэглэгчийн зээлийн нөхцөлтэй холбоотой

³⁸ 2013 оны 6-р сарын 26-ны өдрийн Европын Парламент болон Зөвлөлийн 2013/36/ЕХ тоот Зээлийн байгууллагуудын үйл ажиллагаанд нэвтрэх, зээлийн байгууллага, хөрөнгө оруулалтын фирмүүдийн зохистой байдлын хяналтын тухай удирдамж, 2002/87/ЕС удирдамжид нэмэлт өөрчлөлт оруулах, 2006/48/ЕХ болон 2006/49/ЕХ тоот удирдамжуудыг хүчингүй болгох тухай удирдамж..

³⁹ Хэрэглэгчдэд зориулсан зээлийн гэрээний тухай Европын парламент болон Зөвлөлийн 2008 оны 4-р сарын 23-ны өдрийн 2008/48/ЕХ удирдамж, Зөвлөлийн 87/102/ЕЕС удирдамжийг хүчингүй болгох тухай (OJ L 133, 2008.22.5, х. 66).

үндэсний арга хэмжээнүүдтэй зөрчилдөх ёсгүй. "Одоо худалдаж ав, дараа нь төл" гэх мэт үйлчилгээнүүд нь үндсэндээ зээлээр тодорхойлогддог бөгөөд төлбөрийн үйлчилгээ гэж тооцогдох ёсгүй бөгөөд 2008/48/ЕС удирдамжийг орлож байгаа хэрэглэгчийн зээлийн тухай шинэ удирдамжийн хүрээнд багтах ёстой.

- (36) Энэхүү удирдамжид заасан үүргээ биелүүлж байгаа нотлох баримтыг зохих хугацаанд зохих ёсоор хадгалахын тулд төлбөрийн байгууллагаас дор хаяж таван жилийн хугацаанд бүртгэл хөтлөхийг шаардах нь зүйтэй. Хувийн мэдээллийг тухайн зорилгыг хангахад шаардагдах хугацаанаас илүү удаан хадгалах ёсгүй бөгөөд хэрэв зөвшөөрлийг цуцалсан бол түүнийг цуцалснаас хойш таван жилээс илүү хугацаагаар хадгалах ёсгүй.
- (37) Аж ахуйн нэгж төлбөрийн үйлчилгээ, цахим мөнгөний үйлчилгээг зөвшөөрөлгүйгээр үзүүлэхгүй байхын тулд энэхүү удирдамжид зөвшөөрлийн оронд бүртгүүлэхээр зааснаас бусад тохиолдолд төлбөрийн үйлчилгээ, цахим мөнгөний үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөж буй бүх аж ахуйн нэгжээс зөвшөөрөл авахыг шаардах нь зүйтэй. Цаашилбал, санхүүгийн болон төлбөрийн системийн тогтвортой, нэгдмэл байдлыг хангах, хэрэглэгчдийг хамгаалахын тулд Гишүүн улсад ийм төрлийн үйл ажиллагаа явуулж, үр дүнтэй хяналт тавих ёстой. Цахим мөнгөний институциуд цахим мөнгөний токен гаргах боломжтой холбоотой томоохон эрсдэлийг харгалзан цахим мөнгө гаргадаг төлбөрийн байгууллагуудыг мөн энэ шаардлагад хамруулах ёстой. Цахим мөнгө гаргагчдад ЕХ-нд хуулийн этгээд байгуулах шаардлагатай бөгөөд тэдгээр байгууллагуудад үр дүнтэй хяналт тавьж, 2023/1114/ЕХ-ны журамд нийцүүлэх шаардлагатай. Цахим мөнгөний токен нь хэмжээ нь мэдэгдэхүйц нэмэгдэж санхүүгийн тогтвортой байдал, мөнгөний бүрэн эрхт байдал, мөнгөний бодлогод нөлөөлөх эрсдэлтэй крипто хөрөнгийн нэг хэлбэр юм.
- (38) Төлбөрийн байгууллага гишүүн улсад ямар нэгэн үйл ажиллагаа явуулах хүсэлгүйгээр үүсгэн байгуулах эрхээ урвуулан ашиглахаас урьдчилан сэргийлэхийн тулд гишүүн улсад зөвшөөрөл авахыг хүссэн төлбөрийн байгууллага дор хаяж тухайн гишүүн улсын хүрээнд төлбөрийн үйлчилгээний бизнесийн тодорхой "хэсэг"-ийг эрхлэн явуулахыг шаардах нь зүйтэй. (ЕХ) 2015/2366 удирдамж нь байгууллагуудад зарим бизнесээ эх орондоо явуулахыг аль хэдийн үүрэг болгосон ч тайлбар нь өөр өөр байдаг бөгөөд зарим улс орнууд бизнесийн ихэнх хэсгийг орон нутагтаа явуулахыг шаарддаг. "Хэсэг" гэсэн нэр томъёо нь төлбөрийн байгууллагын хил дамнасан үйлчилгээ үзүүлэх эрх чөлөөг "үр дүнтэй" хэрэгжүүлэхийн тулд тухайн байгууллагын бизнесийн дийлэнх хувийг илэрхийлэхгүй байх ёстой.
- (39) Төлбөрийн байгууллага нь төлбөрийн үйлчилгээ, цахим мөнгөний үйлчилгээ үзүүлэхээс гадна өөр төрлийн үйл ажиллагаа эрхэлж болно. Төлбөрийн байгууллагад зохих хяналт тавихын тулд үндэсний эрх бүхий байгууллага нь шаардлагатай тохиолдолд төлбөрийн үйлчилгээ эсвэл цахим мөнгөний үйлчилгээ үзүүлэх тусдаа бие даасан байгууллага байгуулахыг шаардах эрхтэй байх нь зүйтэй. Эрх бүхий байгууллага ийм шийдвэр гаргахдаа бусад бизнесийн үйл ажиллагаанд нөлөөлж буй үйл явдал төлбөрийн байгууллагын санхүүгийн тогтвортой байдалд үзүүлж

болзошгүй сөрөг нөлөөлөл, эсвэл төлбөрийн байгууллага төлбөрийн чадваргүй нөхцөл байдлаас үүдэн гарч болзошгүй сөрөг нөлөөллийг харгалзан үзэх ёстой. Нэмж дурдахад, төлбөрийн байгууллага бусад үйл ажиллагаатай харьцуулахад төлбөрийн болон цахим мөнгөний үйл ажиллагааныхаа талаар өөрийн хөрөнгийн талаар тусад нь тайлагнаж чадахгүй байгаа нөхцөл байдлаас үүдэн гарч болзошгүй сөрөг үр дагаврыг тооцох ёстой.

- (40) Төлбөрийн байгууллагуудад үр дүнтэй, тасралтгүй хяналт тавьж, үнэн зөв, бодит мэдээллийн хүртээмжтэй байдлыг хангахын тулд төлбөрийн байгууллагууд зөвшөөрөл олгох явцад ирүүлсэн мэдээллийн үнэн зөв байдалд нөлөөлж болзошгүй аливаа өөрчлөлтийн талаар үндэсний эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэх үүрэг өгөх нь зүйтэй. Үүнд нэмэлт агентууд эсвэл үйл ажиллагаа нь аутсорсинг хийдэг байгууллагуудтай холбоотой өөрчлөлтүүд орно. Тодорхой бус тохиолдолд эрх бүхий байгууллага хүлээн авсан мэдээллийн үнэн зөвийг шалгах ёстой.
- (41) Холбооны хэмжээнд төлбөрийн байгууллагуудын зөвшөөрлийн тогтвортой байдлыг хангахын тулд үндэсний эрх бүхий байгууллагууд төлбөрийн байгууллагад олгосон зөвшөөрлийг цуцалж болох болох уялдаа холбоотой нөхцөлийг тогтоох нь зүйтэй.
- (42) Гишүүн улсын эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан, бүртгүүлсэн төлбөрийн байгууллага, түүний дотор төлөөлөгч, дистрибьютер, салбар зэрэг эрх бүхий байгууллагуудын үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулах, холбооны хүрээнд хэрэглэгчийн өндөр түвшний хамгаалалтыг баталгаажуулахын тулд төлбөрийн үйлчилгээ үзүүлж буй аж ахуйн нэгжүүдийн болон тэдгээртэй холбоотой брэндийг улсын бүртгэлд оруулсан жагсаалтад олон нийтэд нээлттэй, хялбар хандах боломжтой байх шаардлагатай байна.
- (43) Үндэсний хуулиар төлбөрийн болон цахим мөнгөний үйлчилгээг санал болгохыг зөвшөөрсөн эрх бүхий буюу бүртгэлтэй төлбөрийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн мэдээллийг агуулсан нэгдсэн бүртгэлийг Холбооны хэмжээнд хүртээмжтэй болгохын тулд ЕБГ ийм бүртгэлийг удирдан зохион байгуулах ёстой. Энэхүү бүртгэлд ЕБГ нь төлбөрийн үйлчилгээ, цахим мөнгөний үйлчилгээ үзүүлэх эрх бүхий буюу бүртгэлтэй байгууллагуудын нэрсийн иж бүрэн жагсаалтыг нийтлэх үүрэгтэй. Энэ нь хувийн мэдээллийг боловсруулахтай холбоотой тохиолдолд төлөөлөгч, дистрибьютерээр ажилладаг хувь хүмүүсийн талаарх мэдээллийг Холбооны түвшинд нийтлэх нь зөвхөн эрх бүхий төлөөлөгч, дистрибьютерүүд дотоод зах зээлд үйл ажиллагаа явуулахыг баталгаажуулах шаардлагатай гэж үзнэ. Энэ нь төлбөрийн үйлчилгээний дотоод зах зээлийг үр дүнтэй ажиллуулахад маш чухал юм. Гишүүн улсууд нь холбогдох байгууллагууд, түүний дотор төлөөлөгч, дистрибьютер, салбаруудынхаа талаар өгсөн мэдээллийн үнэн зөв, цаг алдалгүй, шуурхай, автоматжуулсан хэрэгслээр ЕБГ-т дамжуулах үүрэгтэй. Иймд ЕБГ нь ийм мэдээллийг дамжуулах арга, зохион байгуулалтыг тодорхойлох техникийн зохицуулалтын стандартыг боловсруулж, өндөр нарийвчлалтай, тасралтгүй байдлыг хангаж ажиллахыг зороох ёстой юм. Европын Банкны Газар зохицуулалтын

техникийн стандартын шинэ төслийг боловсруулахдаа EX2019/411⁴⁰ тоот Комиссийн Төлөөллийн эрх шилжүүлэх журам (Commission Delegated Regulation)-н практик хэрэглээ, үр дүнгээс суралцах ёстой. Ил тод байдлыг нэмэгдүүлэхийн тулд дамжуулж буй мэдээлэл нь төлбөр болон цахим мөнгөний бүх үйлчилгээтэй холбоотой брэндүүдийг хамрах ёстой бөгөөд хувийн мэдээллийг нийтлэх нь мэдээлэл хамгаалах хууль тогтоомжид нийцсэн байх ёстой. Түүнчлэн хувийн мэдээллийг нийтэлсэн тохиолдолд цаашид цахим орчинд санамсаргүй мэдээлэл түгээхээс сэргийлэхийн тулд зохих хамгаалалтыг хийх ёстой.

- (44) Төлбөр эхлүүлэх, дансны мэдээллийн үйлчилгээ үзүүлэгчдийн үзүүлж буй үйлчилгээний ил тод байдал, мэдлэгийг дээшлүүлэхийн тулд ЕБГ нь эдгээр ажил, үйлчилгээний талаарх үндсэн мэдээллийг агуулсан машинаар унших боломжтой жагсаалтыг хөтлөх нь зүйтэй. Энэхүү жагсаалтад орсон мэдээлэл нь төлбөр тооцоо хийх болон дансны мэдээллийн үйлчилгээ үзүүлэгчийг тодорхой болгох боломжийг олгоно.
- (45) Төлбөрийн байгууллагууд үйлчилгээнийхээ хүрээг өргөжүүлэхийн тулд төлбөрийн үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд, түүний дотор төлөөлөгч, цахим мөнгөний үйлчилгээний хувьд дистрибьютерийг ашиглах шаардлагатай болдог. Төлбөрийн байгууллагууд мөн өөрийн гишүүн улсаас өөр хүлээн авагч гишүүн улсад үйл ажиллагаа явуулах эрхээ салбар нэгжээрээ дамжуулан хэрэгжүүлж болно. Ийм тохиолдолд төлбөрийн байгууллага нь төлөөлөгч, дистрибьютер, салбартай холбоотой бүх мэдээллийг болон аливаа өөрчлөлтийн талаар үндэсний эрх бүхий байгууллагад цаг алдалгүй мэдээлэх нь зүйтэй. Эцсийн хэрэглэгчдэд нээлтэй, ил тод байдлыг хангахын тулд төлбөрийн байгууллагын нэрийн өмнөөс ажиллаж буй төлөөлөгч, дистрибьютер эсвэл салбарууд төлбөрийн үйлчилгээний хэрэглэгчдэд энэ тухай мэдээлэх нь зүйтэй.
- (46) Төлбөрийн байгууллагууд бизнесээ явуулахдаа үйл ажиллагааныхаа зарим чиг үүргийг аутсорсинг хийх шаардлагатай болдог. Төлбөрийн байгууллагад олгосон зөвшөөрлийн шаардлага эсвэл энэхүү удирдамжийн дагуу холбогдох бусад шалгуурыг үргэлжлүүлэн дагаж мөрдөхөд саад учруулахаас зайлсхийхийн тулд төлбөрийн байгууллага нь хор хөнөөл учруулахгүйн тулд үйл ажиллагааны чиг үүргийг аутсорсинг хийхээр төлөвлөж байгаа болон аутсорсингоор ажил үүргийг гүйцэтгэх аж ахуйн нэгжтэй холбоотой аливаа өөрчлөлтийн талаар үндэсний эрх бүхий байгууллагад цаг алдалгүй мэдэгдэхийг шаардах нь зүйтэй.
- (47) Үйл ажиллагааны чиг үүргийг аутсорсинг хийснээр үүсч болзошгүй эрсдлийг зохих ёсоор бууруулахын тулд төлбөрийн байгууллагуудаас ийм аутсорсинг нь энэхүү удирдамжийн шаардлагыг зөрчихгүй байх талаар үндэслэлтэй арга хэмжээ авахыг шаардах нь зүйтэй. Төлбөрийн байгууллага нь ажилчдынхаа аливаа үйлдэл, эсвэл

⁴⁰ 2018 оны 11-р сарын 29-ний өдрийн ЕХ-ны 2019/411 тоот, Европын парламент болон Зөвлөлийн зохицуулалтын техникийн стандартуудын тухай 2018 оны 11-р сарын 29-ний өдрийн 2019/411 тоот цахим нэгдсэн бүртгэлийг боловсруулах, ажиллуулах, засварлахад тавих техникийн шаардлагыг тодорхойлсон зохицуулалтын техникийн стандартуудын тухай төлбөрийн үйлчилгээний хүрээнд болон түүнд агуулагдах мэдээлэлд хандах талаарх Комиссийн журам (OJ L 73, 2019.3.15, х. 84).

төлөөлөгч, дистрибьютер эсвэл аутсорсингийн байгууллагын үйл ажиллагаанд бүрэн хариуцлага хүлээх ёстой.

- (48) Энэхүү удирдамжийн дагуу батлагдсан үндэсний хууль тогтоомжийн заалтуудыг үр дүнтэй дагаж мөрдөхийн тулд гишүүн улсууд төлбөрийн байгууллагад зөвшөөрөл олгох, хяналт тавих эрх бүхий байгууллагуудыг томилно. Гишүүн улсууд эрх бүхий байгууллагууд чиг үүргээ зохих ёсоор гүйцэтгэхэд шаардлагатай эрх мэдэл, нөөцөөр, түүний дотор боловсон хүчнээр хангагдах ёстой.
- (49) Эрх бүхий байгууллагууд төлбөрийн байгууллагуудад зохих ёсоор хяналт тавих боломжийг олгохын тулд тэдгээр эрх бүхий байгууллагад хяналт тавих, шалгалт хийх, захиргааны шийтгэл ногдуулах, үүргээ биелүүлэхэд шаардлагатай арга хэмжээ авах боломжийг олгох нь зүйтэй. Үүнтэй ижил шалтгаанаар мэдээлэл авах, газар дээр нь хяналт шалгалт хийх, зөвлөмж, заавар, заавал биелүүлэх захиргааны шийдвэр гаргах эрхийг эрх бүхий байгууллагад олгох нь зүйтэй. Гишүүн улсууд төлбөрийн байгууллагын зөвшөөрлийг түдгэлзүүлэх, эргүүлэн татахтай холбоотой үндэсний заалтуудыг гаргах ёстой. Гишүүн улсууд төлбөрийн үйлчилгээний бизнест хяналт тавих, эрх зүйн баримт бичгийг мөрдүүлэхтэй холбоотой заалтуудын зөрчлийг таслан зогсооход чиглэсэн захиргааны шийтгэл, арга хэмжээ авах эрхийг эрх бүхий байгууллагад олгох ёстой.
- (50) Төлбөрийн салбарт өргөн хүрээний боломжит бизнесийн загварууд байдаг тул хяналтын тодорхой эрх мэдлийг олгож ижил эрсдэлийг ижил аргаар шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлэх нь зүйтэй юм.
- (51) Төлбөрийн байгууллагуудын үүргээ биелүүлэхэд хяналт тавихдаа эрх бүхий байгууллагууд үндсэн эрх, ялангуяа хувийн нууцыг хамгаалах эрхийг зохих ёсоор харгалзан хяналтын эрх мэдлээ ашиглах ёстой. Гишүүн улсууд Европын Холбооны Үндсэн эрхийн дүрэмд нийцүүлэн, бие даасан эрх бүхий байгууллагын (Мэдээлэл хамгаалалтын үндэсний байгууллага гэх мэт) хяналтыг алдагдуулахгүйгээр бат бөх, үр дүнтэй хамгаалалтыг бий болгох ёстой. Хяналтын эрх мэдлийг хэрэгжүүлэх нь эдгээр эрхийг ноцтой зөрчихөд хүргэх, урвуулан ашиглах, дур зоргоороо үйлдэхэд хүргэж болзошгүй эрсдэлтэй үед эдгээр хамгаалалт зайлшгүй шаардлагатай болно. Тохиромжтой тохиолдолд тухайн гишүүн улсын шүүх эрх мэдлээс урьдчилан зөвшөөрөл авах зэрэг багтаж болно.
- (52) Хувь хүний болон бизнесийн эрхийг хамгаалахын тулд гишүүн улсууд эрх бүхий байгууллагад ажиллаж байсан эсвэл ажиллаж байгаа бүх хүмүүст мэргэжлийн нууцыг хадгалах үүргийг баталгаажуулах ёстой.
- (53) Төлбөрийн байгууллагуудын үйл ажиллагаа нь хил дамнасан байж болох бөгөөд янз бүрийн эрх бүхий байгууллагууд, түүнчлэн Европын банкны газар, Европын Төв Банк ('ЕСВ') болон үндэсний төв банкуудад мөнгөний болон хяналтын эрх бүхий байгууллагуудад хамааралтай байж болно. Тиймээс үр дүнтэй хамтын ажиллагаа, мэдээлэл солилцох боломжийг хангах нь зүйтэй. Мэдээлэл солилцох зохицуулалт нь

Европын парламент ба Комиссийн⁴¹ (ЕХ) 2016/679 тоот журам болон Европын парламент ба Комиссийн⁴² (ЕХ) 2018/1725 тоот журамд заасан мэдээлэл хамгаалах дүрэмд бүрэн нийцсэн байх ёстой.

- (54) Эрх бүхий байгууллагуудын хооронд хил дамнасан хамтын ажиллагааны хүрээнд санал зөрөлдөөн гарсан тохиолдолд тэдгээр эрх бүхий байгууллага нь ЕБГ-аас тусламж хүсэх боломжтой бөгөөд энэ нь цаг алдалгүй шийдвэр гаргах ёстой. Мөн ЕБГ нь эрх бүхий байгууллагуудад өөрсдийн санаачилгаар тохиролцоонд хүрэхэд нь туслах боломжтой байх ёстой.
- (55) Үүсгэн байгуулах эрх буюу үйлчилгээ үзүүлэх эрх чөлөөг хэрэгжүүлж буй төлбөрийн байгууллага нь өөрийн улсын гишүүн улсын эрх бүхий байгууллагыг бизнесийн үйл ажиллагааныхаа талаар холбогдох мэдээллээр хангах шаардлагатай. Түүнчлэн, төлбөрийн байгууллага нь үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж буй гишүүн улс(ууд)-ын талаар тухайн эрх бүхий байгууллагад мэдэгдэж, салбар, төлөөлөгч, дистрибьютер ашиглахаар төлөвлөж байгаа эсэхээ болон аутсорсинг хийх төлөвлөгөөний талаар мэдээлэх ёстой.
- (56) Эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах, байгуулах эрх буюу үйлчилгээ үзүүлэх эрх чөлөөний дагуу үйл ажиллагаа явуулж буй төлбөрийн байгууллагуудад үр дүнтэй хяналт тавихын тулд тухайн гишүүн улсын эрх бүхий байгууллагууд хүлээн авагч гишүүн улстай мэдээлэл солилцох нь тохиромжтой гэж үздэг. "А" улсад эрх олгогдсон төлбөрийн байгууллага нь "В" улсад байрлах төлөөлөгч, дистрибьютер, салбар гэх мэт зуучлагчийг өөр "С" улсад төлбөрийн үйлчилгээг санал болгохоор ажиллуулдаг "гурвалсан үнэмлэх"-ийн тохиолдолд хүлээн авагч Гишүүн улсыг эцсийн хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлдэг улс гэж хүлээн зөвшөөрөх ёстой. Эрх бүхий байгууллагуудын хил дамнасан хамтын ажиллагаанд тулгарч буй бэрхшээлийг хүлээн зөвшөөрч, ЕБГ нь хамтын ажиллагаа, мэдээлэл солилцохтой холбоотой зохицуулалтын техникийн стандартын төслийг боловсруулахыг зөвлөж байна. Энэхүү боловсруулалт нь (ЕХ)2017/2055⁴³ тоот Комиссийн Төлөөллийн эрх шилжүүлэх журмын хэрэгжилтийг харгалзан үзэх ёстой.
- (57) Гишүүн улсууд өөрийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг, төв оффис нь өөр гишүүн улсад байрладаг төлбөрийн байгууллагуудаас мэдээлэл, статистикийн зорилгоор өөрийн нутаг дэвсгэрт үйл ажиллагааныхаа талаар үе үе тайлагнаж байхыг

⁴¹ 2016 оны 4-р сарын 27-ны өдрийн Европын Парламент болон Зөвлөлийн (ЕХ) 2016/679 тоот Хувийн мэдээллийг боловсруулахтай холбоотой хувь хүмүүсийг хамгаалах, эдгээр мэдээллийг чөлөөтэй шилжүүлэх тухай журам, мөн 95/46/ЕС удирдамжийг хүчингүй болгох тухай (Өгөгдөл хамгаалах ерөнхий журам) (OJ L 119, 05/04/2016, хуудас 1).

⁴² Европын Парламент болон Зөвлөлийн 2018 оны 10-р сарын 23-ны өдрийн (ЕХ) 2018/1725 тоот журам нь Холбооны байгууллага, албан тушаалтан, оффис, агентлагуудын хувийн мэдээллийг боловсруулахтай холбоотой хувь хүмүүсийг хамгаалах, мэдээллийг саадгүй дамжуулахтай холбоотой журам. Энэхүү журам нь (ЕХ) No 45/2001 тоот журам болон шийдвэр No 1247/2002/ЕХ хүчингүй болгосон(OJ L 295, 2018.11.21, хуудас 39)

⁴³ Европын парламент болон Зөвлөлийн төлбөрийн үйлчилгээний байгууллагуудыг бий болгох, үйлчилгээ үзүүлэх эрх чөлөөтэй холбоотой зохицуулалтын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцох тухай техникийн стандартын тухай (ЕХ) 2017/2366 тоот журмыг байжуулсан 2017 оны 6-р сарын 23-ны өдрийн ЕХ-ны 2017/2055 тоот Комиссын Төлөөллийн эрхийн журам (OJ L 294, 11/11/2017, х. 1).

шаардах боломжтой байх ёстой. Эдгээр төлбөрийн байгууллагууд нь үүсгэн байгуулах эрхийн дагуу үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд хүлээн авагч гишүүн улс(ууд)-ын эрх бүхий байгууллагууд уг мэдээллийг мөн ХХХ[Төлбөрийн үйлчилгээний журам] дүрмийг дагаж мөрдөх хяналтад ашиглахыг шаардах боломжтой байх ёстой. Хүлээн авагч гишүүн улс(ууд)-д ямар ч байгууллага байхгүй, төлбөрийн байгууллага нь хүлээн авагч гишүүн улс(ууд)-д үнэ төлбөргүй үйлчилгээ үзүүлэх үндсэн дээр үйлчилгээ үзүүлж байгаа тохиолдолд энэ нь мөн адил хамаарна. Агент, дистрибьютер эсвэл салбаруудын сүлжээг эрх бүхий байгууллагаас хянах ажлыг хөнгөвчлөхийн тулд төлөөлөгч, дистрибьютер эсвэл салбарууд нь үйл ажиллагаа явуулдаг гишүүн орнууд өөрийн нутаг дэвсгэрт төвлөрсөн холбоо барих цэгийг томилохыг үндсэн төлбөрийн байгууллагаас шаардах боломжтой байх нь зүйтэй. ЕБГ нь төвлөрсөн холбоо барих цэгийг хэзээ томилох нь тохиромжтой, түүний чиг үүрэг ямар байх ёстойг тодорхойлох шалгуурыг тодорхойлсон зохицуулалтын стандартыг боловсруулах ёстой. Ингэхдээ ЕБГ нь Комиссийн Төлөөллийн эрх шилжүүлэх Журам (ЕХ) 2021/1722 ⁴⁴ болон 2020/1423 ⁴⁵ -ыг хэрэгжүүлэх явцад олж авсан туршлагыг харгалзан үзэх ёстой. Холбоо барих төв цэгийг томилох шаардлага нь хүлээн авагч гишүүн улсад ХХХ [Төлбөрийн үйлчилгээний журам] журмын холбогдох заалтуудыг дагаж мөрдөж байгаа талаар зохих харилцаа холбоо, мэдээллийн тайлагналын зорилгод хүрэхтэй адил тэгш байх ёстой.

- (58) Их хэмжээний залилан мэхлэх зэрэг хүлээн авагч гишүүн улсын төлбөрийн үйлчилгээний хэрэглэгчдийн хамтын ашиг сонирхолд учирч буй ноцтой аюулыг арилгах яаралтай арга хэмжээ авахыг шаардсан онцгой байдлын үед хүлээн авагч гишүүн улсын эрх бүхий байгууллагууд урьдчилан сэргийлэх арга хэмжээг хүлээн авагч болон гарал үүслийн улс орны гишүүн орнуудын эрх бүхий байгууллагуудын хил дамнасан хамтын ажиллагааны хүрээнд нэгэн зэрэг хэрэгжүүлэх чадвартай байх ёстой. Энэхүү арга хэмжээг тухайн байгууллагын гишүүн улсын эрх бүхий байгууллагаас авах арга хэмжээ авах хүртэлх хугацаанд гүйцэтгэгдэх ёстой бөгөөд арга хэмжээ нь тохирсон, зорьсон зорилготой хамааралтай, ялгаварлан гадуурхахгүй, түр зуурын шинж чанартай, сайтар үндэслэлтэй байх ёстой. Холбогдох төлбөрийн байгууллагын үндсэн харьяаллын гишүүн улсын эрх бүхий байгууллагууд болон бусад холбогдох байгууллагууд, тухайлбал, Комисс, ЕБГ зэрэгт урьдчилан мэдэгдэх ёстой бөгөөд онцгой байдлын улмаас урьдчилан мэдэгдэх боломжгүй тохиолдолд мэдээллийг цаг алдалгүй хүргүүлэх ёстой.

⁴⁴ 2021 оны 6-р сарын 18-ны өдрийн Төлөөллийн эрхийн журам (ЕХ) 2021/1722 нь Европын Парламент болон Зөвлөлийн 2015/2366 (ЕХ) удирдамжид нэмэлт үүрэг гүйцэтгэдэг. Энэхүү журам нь гарал үүслийн улс болон хүлээн авагч гишүүн орнуудын эрх бүхий байгууллагуудын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцох хүрээг тодорхойлсон зохицуулалтын техникийн стандартын тодорхойлолтод чиглэгддэг. Энэхүү хамтын ажиллагааны агуулга нь төлбөрийн үйлчилгээ эрхэлдэг хил дамнасан төлбөрийн байгууллагууд болон цахим мөнгөний байгууллагуудад хяналт тавихтай холбоотой (OJ L 343, 2021.9.28, хуудас 1).

⁴⁵ 2019 оны 3-р сарын 14-ний Комиссын Төлөөллийн эрхийн журам (ЕХ) 2020/1423 нь Европын Парламент болон Зөвлөлийн (ЕХ) 2015/2366 дугаар удирдамжийг нөхөж байгаа бөгөөд төлбөрийн үйлчилгээний салбарт төвлөрсөн холбоо барих цэгүүдийг томилох шалгуурыг тодорхойлж, эдгээр төвтэй холбоо барих цэгүүдэд өгөгдсөн чиг үүргийг тодорхойлсон зохицуулалтын техникийн стандарттай холбоотой журам(OJ L 328, 10/9/2020, хуудас 1).

- (59) Төлбөрийн үйлчилгээг санал болгож буй бүх байгууллагууд хууль эрх зүйн болон зохицуулалтын тодорхой стандартыг дагаж мөрдөх нь маш чухал юм. Иймд төлбөрийн үйлчилгээ үзүүлж буй бүх хүмүүс, тэр дундаа жижиг төлбөрийн байгууллага гэх мэт төлбөрийн байгууллага болох зөвшөөрөл авах бүх нөхцөлийг хангаагүй аж ахуйн нэгжүүдийн хувийн мэдээлэл, байршлыг бүртгэхийг зөвлөж байна. Энэ арга нь бүх нөхцлийг хангаж чадахгүй байгаа төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийг төлбөрийн байгууллага гэж үзэх боломжийг олгох механизмыг санал болгож буй Санхүүгийн арга хэмжээний ажлын хэсгийн 14-р зөвлөмжийн үндэслэлтэй нийцэж байна. Энэхүү зөвлөмжийн дагуу аж ахуйн нэгжүүд зөвшөөрөл олгох зарим болон бүх нөхцлөөс чөлөөлөгдсөн байсан ч гишүүн орнууд тэдгээрийг төлбөрийн байгууллагын бүртгэлд оруулах ёстой. Гэсэн хэдий ч зөвшөөрөл олгохоос чөлөөлөх асуудлыг авч үзэхдээ төлбөрийн гүйлгээний үнэ цэнэтэй холбоотой хатуу шаардлага тавих нь амин чухал юм. Ийм хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлдэг аж ахуйн нэгжүүд төлбөр тооцооны системд оролцоходоо байгуулах эрх, үйлчилгээ үзүүлэх эрх чөлөөтэй байх ёсгүй бөгөөд эдгээр эрхээ шууд бусаар хэрэгжүүлэх ёсгүй.
- (60) Жижиг төлбөрийн байгууллагуудад үзүүлэх хөнгөлөлт, чөлөөлөлх нөхцөлүүдтэй холбоотой ил тод байдлыг хангахын тулд энэ төрлийн шийдвэрийг Комиссд мэдэгдэхийг гишүүн орнуудаас шаардах нь зүйтэй.
- (61) Дансны мэдээллийн үйлчилгээг санал болгох үйл ажиллагааны онцлог шинж чанар, түүнтэй холбоотой эрсдлийг харгалзан дансны мэдээллийн үйлчилгээ үзүүлэгчдийн хувьд тодорхой зохистой байдлын тогтолцоог бий болгох нь зүйтэй. Энэхүү тогтолцоо нь зөвшөөрлийн иж бүрэн горимыг шаарддаггүй харин оронд нь бүртгэлийн илүү хялбаршуулсан шаардлагыг нэвтрүүлж байна. Энэхүү шаардлагыг холбогдох баримт бичиг, мэдээллийг ирүүлэх нь эрх бүхий байгууллагад үр дүнтэй хяналт тавихад туслах ёстой. Нэмж дурдахад дансны мэдээллийн үйлчилгээ үзүүлэгчдийг "паспорт"-н дүрмийн давуу талыг ашиглан хил дамнуулан үйлчилгээ үзүүлэхийг зөвшөөрөх ёстой.
- (62) Хорооны нэн тэргүүний зорилт болох бэлэн мөнгөний хүртээмжийг нэмэгдүүлэхийн тулд жижиглэнгийн худалдаачдад худалдан авагч худалдан авалт хийхгүйгээр ч гэсэн бодит дэлгүүрт бэлэн мөнгөний үйлчилгээ үзүүлэхийг зөвшөөрөх ёстой. Энэ заалт нь жижиглэн худалдаачдыг төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн зөвшөөрөл авах, бүртгүүлэх, төлбөрийн байгууллагын төлөөлөгчөөр ажиллахыг шаардах ёсгүй. Гэсэн хэдий ч эдгээр бэлэн мөнгөний үйлчилгээ нь үйлчлүүлэгчээс авсан аливаа хураамжийг ил тод мэдээлэх үүргийг дагаж мөрдөх ёстой. Жижиглэн худалдаачид дэлгүүрт бэлэн мөнгө байгаа эсэхээс хамаарч эдгээр үйлчилгээг сайн дураараа санал болгох ёстой. Төлбөрийн дансаар үйлчилдэггүй АТМ байршуулагчид болон худалдан авалт хийлгүйгээр бэлэн мөнгө авахыг санал болгодог жижиглэнгийн худалдаачдын хоорондох шударга бус өрсөлдөөнийг бууруулах, дэлгүүрүүд бэлэн мөнгөний нөөцөө хурдан шавхахаас урьдчилан сэргийлэхийн тулд гүйлгээний дээд хэмжээг 50 еврогоор тогтоох нь зүйтэй гэж үзсэн.

- (63) 2007/64/ЕС болон 2015/2366/ЕХ-ны удирдамжууд нь зарим АТМ хэрэглэгчдийг өөрийн зохицуулалтын хамрах хүрээнээс болзолтойгоор хассан. Энэ нь гишүүн улс орнуудад АТМ-н үйлчилгээг ялангуяа хүн ам багатай бүс нутгуудад банкны АТМ-н үйлчилгээ банкны АТМ-н үйлчилгээг нөхөн хөгжихөд түлхэц өгсөн. Гэсэн хэдий ч энэхүү болзолт чөлөөлөлт нь хамрагдсан байгууллагуудын талаарх тодорхой бус байдлаас шалтгаалан үүнийг хэрэглэхэд хүндрэлтэй болсон. Энэ асуудлыг шийдвэрлэхийн тулд өмнө нь зохицуулалтаас тодорхой нөхцөлийн үндсэн дээр чөлөөлөгдсөн АТМ үйлчилгээ үзүүлэгчид нь төлбөрийн дансанд үйлчилгээ үзүүлдэггүй гэдгийг тодорхой заах нь зүйтэй. Ийм төрлийн АТМ операторуудын үйл ажиллагаатай холбоотой хязгаарлагдмал эрсдэлийг хүлээн зөвшөөрч, бзохицуулалтын хүрээнээс бүрэн чөлөөлөхөөс зайлсхийж, оронд нь эдгээр эрсдэлд тохирсон зөвхөн бүртгэлийн горимыг шаарддаг арга хэмжээ авах нь илүү тохиромжтой.
- (64) (ЕХ) 2015/2366 дугаар удирдамжийн дагуу чөлөөлөгдөх эрх эдлэхийг эрэлхийлж буй үйлчилгээ үзүүлэгчид өөрсдийнхөө үйл ажиллагааны хамрах хүрээ нь Удирдамжийн дагуу байх эсвэл чөлөөлөгдөх эсэх дээр эрх баригчдаас зөвлөгөө авахын оронд өөрсдийн үнэлгээнд тулгуурлахыг илүүд үздэг. Энэ нь гишүүн орнуудад тодорхой удирдамжийн хөнгөлөлт, чөлөөлөлтийг нэгдмэл бус аргаар хэрэглэхэд хүргэсэн. Нэмж дурдахад төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид бизнесийн загвараа өөрчлөхийн тулд төлбөрийн үйл ажиллагааг удирдамжийн хамрах хүрээнээс гадуур, зарим хөнөгөлөт чөлөөлөлтийн нөхцөлүүдийг ашигласан байж магадгүй юм. Энэ нь төлбөрийн үйлчилгээний хэрэглэгчдэд эрсдэлийг нэмэгдүүлж, дотоод зах зээлд үйлчилгээ үзүүлэгчдийн хувьд ялгаатай нөхцөл байдлыг бий болгож байна. Үүнийг шийдвэрлэхийн тулд үйлчилгээ үзүүлэгчдийг холбогдох заалтад заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд дүгнэлт хийх, ийм боломжийг олгохын тулд холбогдох үйл ажиллагааны талаар эрх бүхий байгууллагад мэдэгдэх үүрэгтэй. Энэхүү мэдээллийн үйл явц нь дотоод зах зээлд дүрэм журмын тууштай тайлбарыг хангахад маш чухал юм. Түүнчлэн төлбөрийн гүйлгээний хэмжээ тогтоосон босго хэмжээнээс хэтэрсэн тохиолдолд төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч боломжит төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчээс ХХХ[Төлбөрийн үйлчилгээний журам] журамд заасан шалгуурыг үндэслэн хязгаарлагдмал сүлжээний хүрээнд явуулж буй үйл ажиллагааны талаар эрх бүхий байгууллагад мэдэгдэх шаардлагыг оруулах нь чухал юм. Эрх бүхий байгууллагууд зарласан үйл ажиллагааг үнэлж, энэ нь үнэхээр хязгаарлагдмал сүлжээний хамрах хүрээг хамарч байгаа эсэхийг тодорхойлох ёстой бөгөөд ингэснээр түүнийг зохицуулалтаас хассан болохыг батлах ёстой.
- (65) Европын Холбооны үйл ажиллагааны гэрээний 290-р зүйлд заасны дагуу инфляцийг харгалзан аливаа дүнг шинэчлэхтэй холбогдуулан акт гаргах эрх мэдлийг Комиссд шилжүүлэх ёстой. Комисс нь итгэмжлэгдсэн актуудыг бэлтгэх, боловсруулахдаа холбогдох баримт бичгийг Европын парламент болон Комиссд нэгэн зэрэг, цаг тухайд нь, зохих ёсоор шилжүүлэх үйл ажиллагааг ёсчлон хангах ёстой.
- (66) Холбогдох шаардлагуудыг тууштай хэрэгжүүлэхийн тулд Комисс нь удирдамж, зохицуулалтын техникийн стандартын төслийг бэлтгэх үүрэг хүлээсэн ЕБГ-н туршлага, дэмжлэгт найдах чадвартай байх ёстой. Эдгээр зохицуулалтын техникийн

стандартын төслийг батлах эрхийг Комиссд олгох ёстой. Эдгээр тодорхой үүрэг даалгавар нь Европын Парламент болон Комиссийн⁴⁶ (ЕХ)1093/2010 тоот журамд заасан ЕБГ-н үүрэг, хариуцлагатай бүрэн нийцэж байна.

- (67) Төлбөрийн үйлчилгээний дотоод зах зээлийн цаашдын интеграцлалыг гишүүн улсууд дангаараа хангалттай биелүүлж чадахгүй, учир нь энэ нь янз бүрийн гишүүн орнуудын хууль эрх зүйн тогтолцоонд одоо мөрдөгдөж буй өөр өөр дүрмүүдийг уялдуулах шаардлагатай тул энэ нь Холбооны түвшинд илүү үр дүнтэй байх болно. Холбоо нь Европын Холбооны тухай гэрээний 5 дугаар зүйлд заасан туслах зарчмын дагуу арга хэмжээ авч болно. Энэ зүйлд заасан пропорциональ байдлын зарчмын дагуу энэхүү удирдамж нь зорилгодоо хүрэхийн тулд шаардлагатай хүрээнээс хэтрээгүй болно.
- (68) Энэхүү удирдамжид Евросистемийн жижиглэнгийн төлбөрийн систем, тэр дундаа Системийн ач холбогдол бүхий төлбөрийн систем болон бусад системд тавих хяналтын тогтолцоотой давхцахаас зайлсхийх хэрэгцээг харгалзан төлбөрийн систем, төлбөрийн схем, төлбөрийн зохицуулалтын тусгай зөвшөөрлийн шаардлага болон Евросистемийн шинэ "PISA" тогтолцоо, үндэсний төв банкуудын хяналт зэргийг тусгаагүй болно. Нэмж дурдахад энэхүү заавар нь дижитал түрийвч боловсруулах, ажиллуулах зэрэг техникийн үйлчилгээ үзүүлэхийг удирдамжаар хамрах хүрээнээс хассан болно. Гэсэн хэдий ч төлбөрийн салбарын инновацийн динамик шинж чанар, шинэ эрсдэл гарч болзошгүй тул энэхүү удирдамжийг цаашид хянан үзэхдээ Комиссийн зүгээс эдгээр хөгжлийг сайтар судалж үзэх нь чухал юм. Комисс нь уг удирдамжийн хамрах хүрээг шинэ үйлчилгээ, аж ахуйн нэгжүүдэд хамруулах шаардлагатай байгаа эсэхийг үнэлж, төлбөрийн салбарын хувьсан өөрчлөгдөж буй орчинтой нийцүүлэхэд тэмүүлэх ёстой.
- (69) Хууль эрх зүйн тодорхой байдлыг хангах үүднээс энэхүү удирдамж хүчин төгөлдөр болохоос өмнө ЕХ-ны 2015/2366 тоот удирдамжийг шилжүүлэх тухай үндэсний хууль тогтоомжийн дагуу төлбөрийн байгууллагын үйл ажиллагааг эхлүүлсэн аж ахуйн нэгжүүдэд эдгээр үйл ажиллагааг үргэлжлүүлэх боломжийг олгох шилжилтийн зохицуулалтыг тухайн гишүүн улсын хүрээнд тодорхой хугацаанд хийх нь зүйтэй.
- (70) Хууль эрх зүйн тодорхой байдлыг хангах үүднээс 2009/110/ЕС-ийн удирдамжийг шилжүүлэх үндэсний хууль тогтоомжийн дагуу үйл ажиллагаагаа явуулж буй цахим мөнгөний байгууллагууд холбогдох гишүүн улсын хүрээнд эдгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх боломжийг заасан хугацаанд хангах шилжилтийн зохицуулалтыг хийх ёстой. Энэ хугацаа нь 2009/110/ЕС удирдамжийн 9-р зүйлд заасан заалтуудын дагуу хөнгөлөлт, чөлөөлөлтөд орсон цахим мөнгөний байгууллагуудын хувьд илүү урт байх ёстой.

⁴⁶ 2010 оны 11-р сарын 24-ний өдрийн Европын Парламент ба Зөвлөлийн (ЕХ) 1093/2010 тоот Европын хяналтын байгууллага (Европын банкны газар) байгуулах, 716/2009/ЕС шийдвэрт нэмэлт, өөрчлөлт оруулах, Зөвлөлийн 2009/78/ЕС (ОJ) шийдвэрийг хүчингүй болгох тухай журам. (OJ L 331, L 331, 2010.12.15, хуудас 12).

- (71) Төлбөрийн байгууллагууд нь Европын Парламент, Комиссийн⁴⁷ 98/26/ЕС-ийн удирдамжийн 2-р зүйлийн (b) хэсэгт заасан "байгууллага" гэсэн тодорхойлолтод хамаарах байгууллагуудын жагсаалтад ороогүй. Иймээс төлбөрийн байгууллагууд уг удирдамжийн дагуу гишүүн улсуудаас тогтоосон төлбөрийн системд оролцохоос эрхгүй. Төлбөрийн зарим үндсэн системд нэвтрэх боломжгүй байгаа нь төлбөрийн байгууллагуудад үйлчлүүлэгчдэдээ үр дүнтэй, өрсөлдөхүйц хэмжээний төлбөрийн үйлчилгээг үзүүлэхэд саад учруулж болзошгүй юм. Иймд төлбөрийн байгууллагуудыг уг удирдамжид "байгууллага" гэсэн тодорхойлолтод гэхдээ үүнд үнэт цаасны төлбөр тооцооны системд хамаарахгүйгээр зөвхөн төлбөрийн системийн зорилгоор оруулах нь зөв юм. Төлбөрийн байгууллагууд эдгээр системд оролцохыг зөвшөөрөх төлбөрийн системийн шаардлагыг хангаж, дүрмийг хүндэтгэх ёстой. ХХХ [Төлбөрийн үйлчилгээний журам] журамд төлбөрийн системийн операторуудад шинээр өргөдөл гаргагчдыг элсүүлэх, үүнд холбогдох эрсдлийн үнэлгээ хийх шаардлагыг тусгасан. Банк болон "банк бус"-ын хоорондын тэгш өрсөлдөөний нөхцлийг аль болох хурдан сэргээхийн чухлыг харгалзан, түүнчлэн өнөөгийн нөхцөл байдал төлбөрийн зах зээл дэх өрсөлдөөнд үзүүлж буй нөлөөлөл зэргийг харгалзан үзэж, гишүүн орнуудад 98/26/ЕС тоот удирдамжийн энэхүү шинэ заалтын дагуу өргөдөл гаргах хугацааг энэхүү удирдамжийн бусад заалттай харьцуулахад богиносгох шаардлагатай байна. Иймд гишүүн орнуудаас энэхүү удирдамжийн бусад заалтад хамаарах 18 сарын хугацаанд биш харин энэхүү удирдамж хүчин төгөлдөр болсноос хойш 6 сарын дотор уг шинэ заалтыг үндэсний хууль тогтоомждоо оруулахыг шаардах нь зүйтэй.
- (72) Гишүүн орнуудад ижил төстэй ойлголтыг бий болгохын тулд оролцогчид үнэт цаасны зуучлагч, төлбөр тооцооны агент, клирингийн төвийн үүрэг гүйцэтгэх эсвэл эдгээр ажлыг хэсэгчлэн эсвэл бүгдийг нь гүйцэтгэж болно гэсэн тодорхойлолтыг 98/26/ЕС удирдамжид дахин оруулах ёстой. Системийн эрсдэлээс шалтгаалсан үндэслэлтэй тохиолдолд гишүүн орнуудад шууд бус оролцогчийг системийн оролцогч гэж үзэж, ийм шууд бус оролцогчид 98/26/ЕС удирдамжийн заалтыг хэрэглэхийг зөвшөөрөх ёстой гэдгийг дахин оруулах хэрэгтэй. Гэсэн хэдий ч, энэ нь шууд бус оролцогч системд шилжүүлэх захиалгыг дамжуулж буй оролцогчийн хариуцлагыг хязгаарлахгүй байхын тулд хууль эрх зүйн тодорхой байдлыг хангах үүднээс уг зааварт тодорхой тусгасан байх ёстой.
- (73) Хэрэглэгчид Европын Парламент болон Комиссийн⁴⁸ (ЕХ) 20./...[FIDA] журмын дагуу хэрэглэгчид эсвэл мэдээлэл эзэмшигчдэд хүлээлгэсэн үүрэг хариуцлагатай

⁴⁷ Төлбөрийн болон үнэт цаасны төлбөр тооцооны систем дэх төлбөр тооцоог эцэслэх тухай Европын Парламент болон Зөвлөлийн 1998 оны 5-р сарын 19-ний өдрийн 98/26/ЕХ тоот удирдамж (OJ L 166, 11.6.1998, хуудас 45).

⁴⁸ (ЕХ) 20./... тоот Европын Парламент" болон Зөвлөлийн Санхүүгийн мэдээлэлд нэвтрэх эрх, нэмэлт өөрчлөлт оруулах (ЕХ) № 1093/2010, (ЕХ) № 1094/2010, (ЕХ) № 1095/2010 болон (ЕХ) 2022/2554 Тоот журмуудад өөрчлөлт оруулах тухай

- холбоотой эрхээ Европын Парламент ба Комиссийн ⁴⁹ (ЕХ)-2020/1828 тоот удирдамжид заасан төлөөллийн үйлдлээр баталгаажуулах эрхтэй. Үүнийг хөнгөвчлөхийн тулд уг удирдамж нь хэрэглэгчийн хамтын ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй (ЕХ) 20.../[FIDA]-ын заалтыг мэдээлэл хэрэглэгчид эсвэл мэдээлэл эзэмшигчдийн зөрчлийн эсрэг төлөөлөх арга хэмжээнд хэрэглэх боломжтой байх ёстой. Иймд уг удирдамжийн хавсралтыг энэхүү заалттай нийцүүлэн өөрчлөх шаардлагатай. Гишүүн улсууд (ЕХ) 2020/1828 удирдамжийн шаардлагын дагуу энэхүү нэмэлт өөрчлөлтийг шилжүүлэх арга хэмжээнд тусгах үүрэгтэй.
- (74) Зохицуулалт сайтай байх зарчмуудын дагуу энэхүү удирдамжийг дагалдах нөлөөллийн үнэлгээнд тусгагдсаны дагуу зорилгодоо хүрэх үр дүнтэй, үр ашигтай эсэхийг хянаж үзэх ёстой. Хяналт нь хүчин төгөлдөр болсноос хойш хангалттай хугацаа өнгөрч, зохих нотлох баримтад үндэслэсэн байх ёстой. Таван жил бол тохиромжтой хугацаа гэж үздэг. Хяналтын явцад уг удирдамжийг бүхэлд нь авч үзэх ёстой ч 2023 оны 4-р сарын 18-ны өдөр Комиссоос⁵⁰ санал болгосон дүрмийн нөлөөлөл болох төлбөрийн байгууллагуудын хөрөнгийн хамрах хүрээ, хамгаалалт зэрэг тодорхой сэдвүүдийг онцгойлон анхаарч үзэх хэрэгтэй. Хадгаламжийн баталгааны тогтолцооны тухай Европын Парламент болон Комиссийн 2014 оны 4-р сарын 16-ны өдрийн 2014/49/ЕХ-ны удирдамжид өөрчлөлт оруулах. Энэхүү удирдамжийн хамрах хүрээний тухайд (ЕХ) 2022/2554 дугаар журамд энэ асуудалд ач холбогдол өгсөн тул хүчин төгөлдөр болсноос хойш гурван жилийн өмнө хянан үзэх нь зүйтэй. Энэхүү хамрах хүрээг тоймлохдоо төлбөрийн систем, төлбөрийн схемээр гүйцэтгэдэг үйлчилгээ зэрэг хамрагдсан төлбөрийн үйлчилгээний жагсаалтыг өргөтгөх боломж, мөн одоогоор хасагдсан зарим техникийн үйлчилгээний хамрах хүрээг хамрах боломжийг харгалзан үзэх ёстой.
- (75) (ЕХ) 2015/2366 болон 2009/110/ЕС удирдамжид хэд хэдэн өөрчлөлт оруулах шаардлагатай байгаа тул эдгээр хоёр удирдамжийг хүчингүй болгож, энэхүү удирдамжаар солих нь зүйтэй.
- (76) Энэхүү удирдамжийн хүрээнд аливаа хувийн мэдээллийг боловсруулах нь дүрэм (ЕХ) 2016/679 болон (ЕХ) 2018/1725 журамд нийцсэн байх ёстой. Тиймээс (ЕХ) 2016/679 болон (ЕХ) 2018/1725 журмын дагуу хяналтын байгууллагууд энэхүү удирдамжийн хүрээнд хувийн мэдээллийн боловсруулалтад хяналт тавих үүрэгтэй. Гишүүн улсууд энэхүү удирдамжийг шилжүүлэхдээ үндэсний хууль тогтоомжид хувийн мэдээллийг боловсруулахад шаардлагатай мэдээллийн хамгаалалтын арга хэмжээг тусгасан байх ёстой.
- (77) (ЕХ) 2018/1725 журмын 42(1)-ийн дагуу Европын өгөгдөл хамгаалах хяналтын ажилтантай зөвлөлдөж, санал дүгнэлтээ өгсөн [XX XX 2023],

⁴⁹ Хэрэглэгчдийн хамтын ашиг сонирхлыг хамгаалах төлөөллийн үйл ажиллагааны тухай Европын Парламент болон Зөвлөлийн 2020 оны 11-р сарын 25-ны өдрийн (ЕХ) 2020/1828 тоот удирдамж, 2009/22/ЕХ удирдамжийг хүчингүй болгох (OJ L 409, 2020.04.12, х. 1).

⁵⁰ COM(2023)228 финал.

ЭНЭ УДИРДАМЖИЙГ БАТАЛСАН:

ГАРЧИГ I

ХАМРАХ ХҮРЭЭ, ТОДОРХОЙЛОЛТ

1 дүгээр зүйл

Сэдвийн сэдэв ба хамрах хүрээ

1. Энэхүү удирдамж нь дараах үйл ажиллагаатай холбоотой дүрмийг тогтооно.
(а) төлбөрийн байгууллагуудын холбооны хүрээнд төлбөрийн үйлчилгээ, цахим мөнгөний үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаанд нэвтрэх;
(б) хяналтын эрх мэдэл, төлбөрийн байгууллагуудад хяналт тавих арга хэрэгсэл.
2. Гишүүн улсууд 2013/36/ЕХ-ны удирдамжийн 2-р зүйлийн (5), (4)-ээс (23)-д дурдсан байгууллагуудыг энэхүү удирдамжийн заалтыг бүхэлд нь буюу хэсэгчлэн хэрэглэхээс чөлөөлж болно.
3. Хэрэв өөрөөр заагаагүй бол энэхүү удирдамжид төлбөрийн үйлчилгээний тухай дурдвал төлбөр болон цахим мөнгөний үйлчилгээ гэж ойлгоно.
4. Өөрөөр заагаагүй бол энэхүү удирдамжид төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай дурьдсан зүйлийг төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч болон цахим мөнгөний үйлчилгээ үзүүлэгч гэж ойлгоно.
- 5.

2 дугаар зүйл

Тодорхойлолт

Энэхүү удирдамжийн зорилгоор дараахь тодорхойлолтыг хэрэглэнэ.

- (1) “Гишүүн орон” гэдэг нь дараахь зүйлийн аль нэгийг хэлнэ:
 - (а) төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь бүртгэлтэй газартай гишүүн улс; эсвэл
 - (б) хэрэв төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь өөрийн үндэсний хууль тогтоомжийн дагуу бүртгэлийн газаргүй бол төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн төв байртай гишүүн улсад;
- (2) “хүлээн авагч гишүүн улс” гэж төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч нь төлөөлөгч, дистрибьютер, салбартай буюу төлбөрийн үйлчилгээ үзүүлж буй гишүүн улсад бусад гишүүн улсыг;
- (3) “төлбөрийн үйлчилгээ” гэж Хавсралт I-д заасан аливаа бизнесийн үйл ажиллагааг;
- (4) “төлбөрийн байгууллага” гэж 13 дугаар зүйлд заасны дагуу холбооны хэмжээнд төлбөрийн үйлчилгээ, цахим мөнгөний үйлчилгээ үзүүлэх эрх авсан хуулийн этгээдийг;

- (5) “төлбөрийн гүйлгээ” гэж төлбөр төлөгч болон түүний өмнөөс, эсхүл төлбөр авагч, эсхүл түүний нэрийн өмнөөс төлбөр төлөгч болон төлбөр авагчийн хооронд үүссэн аливаа үндсэн үүргээс үл хамааран байршуулсан төлбөрийн даалгаврын үндсэн дээр мөнгө байршуулах, шилжүүлэх, авах үйлдлийг хэлнэ;
- (6) “төлбөрийн гүйлгээг гүйцэтгэх” гэж төлбөрийн гүйлгээг эхлүүлсний дараа эхэлж, байршуулсан, татан авсан, шилжүүлсэн мөнгө төлбөр авагчид бэлэн болмогц дуусах үйл явцыг;
- (7) “төлбөрийн систем” гэж төлбөрийн гүйлгээг боловсруулах, төлбөр тооцоо хийх, төлбөр тооцоо хийх албан ёсны болон стандартчилагдсан зохицуулалт, нийтлэг дүрэм бүхий мөнгөн шилжүүлгийн системийг;
- (8) “төлбөрийн системийн оператор” гэж төлбөрийн системийг ажиллуулах хуулийн этгээдийг;
- (9) “төлбөр төлөгч” гэж төлбөрийн данс эзэмшиж, тухайн төлбөрийн данснаас төлбөрийн даалгавар гаргадаг хувь хүн, хуулийн этгээд, төлбөрийн дансгүй бол төлбөрийн даалгавар өгдөг хувь хүн, хуулийн этгээдийг;
- (10) “төлбөр хүлээн авагч” гэж төлбөрийн гүйлгээний зүйл болох мөнгөн хөрөнгийг хүлээн авахаар төлөвлөж буй хувь хүн буюу хуулийн этгээдийг;
- (11) “төлбөрийн үйлчилгээний хэрэглэгч” гэж төлбөр төлөгч, төлбөр авагч, эсхүл хоёулангийнх нь хувьд төлбөрийн үйлчилгээ, цахим мөнгөний үйлчилгээг ашиглаж буй хувь хүн, хуулийн этгээдийг;
- (12) “төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч” гэж XXX[Төлбөрийн үйлчилгээ үзүүлэх журам]-н 2(1)-д дурдсан байгууллага, эсхүл энэхүү удирдамжийн 34, 36, 38 дугаар зүйлд заасны дагуу хөнгөлөлт эдлэх хувь хүн, хуулийн этгээдийг;
- (13) "төлбөрийн данс" гэж төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн нэг буюу хэд хэдэн төлбөрийн гүйлгээг гүйцэтгэхэд ашигладаг, гуравдагч этгээдэд мөнгө шилжүүлэх, хүлээн авах боломжийг олгодог нэг буюу хэд хэдэн төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн нэр дээр эзэмшдэг дансыг хэлнэ;
- (14) “төлбөрийн даалгавар” гэж төлбөр төлөгч буюу төлбөр авагчаас төлбөрийн гүйлгээг гүйцэтгэхийг хүссэн төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдээ өгсөн даалгаврыг;
- (15) “төлбөрийн хэрэгсэл” гэж төлбөрийн гүйлгээг эхлүүлэх боломжийг олгодог төлбөрийн үйлчилгээ хэрэглэгч болон төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн хооронд тохиролцсон хувь хүний төхөөрөмж, төхөөрөмж ба/эсвэл журмын багцыг хэлнэ;
- (16) “дансны үйлчилгээ үзүүлэх төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч” гэж төлбөр төлөгчид төлбөрийн данс олгож, хөтлөгч төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийг;

- (17) “төлбөр эхлүүлэх үйлчилгээ” гэж төлбөр төлөгч буюу төлбөр авагчийн хүсэлтээр өөр төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч дэх төлбөрийн дансанд төлбөрийн даалгавар өгөх үйлчилгээг;
6. ЕБГ нь 2019/410⁵⁷-р Хорооны хэрэгжүүлэх журамд заасан мэдээллийн стандарт, форматыг багтаасан 1 дэх хэсгийн дагуу мэдэгдэх мэдээллийн дэлгэрэнгүй, бүтцийн талаар хэрэгжүүлэх техникийн стандартын төслийг боловсруулна.

ЕБГ-т техникийн стандартыг хэрэгжүүлэх төслүүдийн төслийг [ОН/ энэ удирдамж хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 18 сарын дараа оруулна уу] -т Комисст өргөн мэдүүлнэ.

(ЕХ) 1093/2010 тоот журмын 15 дугаар зүйлд заасны дагуу эхний дэд зүйлд дурдсан хэрэгжүүлэх техникийн стандартыг батлах эрхийг Комисст шилжүүлсэн.

7. ЕБГ нь 1-р хавсралтын 6, 7-д заасан төлбөрийн үйлчилгээг санал болгож буй үйлчилгээ үзүүлэгчдийн төвлөрсөн, машин унших боломжтой жагсаалтыг боловсруулж, ажиллуулж, хөтлөх бөгөөд энэ нь энэ хэсэгт дурдсан ЕБГ-ын бүртгэлд байгаа хамгийн сүүлийн үеийн мэдээлэлд үндэслэнэ. Энэхүү жагсаалт төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдийн нэр, таних тэмдэг, тэдгээрийн зөвшөөрлийн статусыг агуулсан байна.

2 ДУГААР БҮЛЭГ

ТӨЛӨӨЛӨГЧИД, ДИСТРИБЬЮТОРУУД, САЛБАР БА АУТСОРСИНГ

19 дүгээр зүйл

Төлөөлөгч ашиглах

1. Төлөөлөгчөөр дамжуулан төлбөрийн үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөж буй төлбөрийн байгууллага нь дараах бүх мэдээллийг өөрийн гишүүн улсын эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

(а) төлөөлөгчийн нэр, хаяг;

(б) 2015/849 (ЕХ) удирдамжийг дагаж мөрдөхийн тулд төлөөлөгчийн ашиглах дотоод хяналтын механизмын хамгийн сүүлийн үеийн тодорхойлолт / тайлбар;

(в) төлөөлөгчийн менежмент хариуцсан захирлууд болон бусад хүмүүсийн хувийн мэдээлэл, хэрэв төлөөлөгч төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч биш бол тэдгээр хүмүүс үүрэг хариуцлагаа биелүүлэхэд тохиромжтой, зохистой гэдгийг нотлох баримт;

(г) Төлбөрийн байгууллага нь төлөөлөгчдөд өөрийн нэрийн өмнөөс үзүүлэхийг зөвшөөрсөн санхүүгийн үйлчилгээ.;

⁵⁷ 2018 оны 11-р сарын 29-ний өдрийн Хорооны Хэрэгжүүлэх журам (ЕХ) 2019/410-д заасны дагуу төлбөрийн үйлчилгээний чиглэлээр эрх бүхий байгууллагаас Европын банкны байгууллагад мэдэгдэх мэдээллийн дэлгэрэнгүй, бүтэцтэй холбоотой техникийн стандартыг (ЕХ) Европын Парламент ба Зөвлөлийн 2015/2366 (ОJ L 73, 2019.3.15, х. 20) дагуу тогтоосон.

(д) боломжтой тохиолдолд төлөөлөгчийн өвөрмөц таних код эсвэл дугаар.

2. Гишүүн улсууд 1-д заасан мэдээллийг хүлээн авснаас хойш 2 сарын дотор гишүүн улсын эрх бүхий байгууллагууд /17 дугаар зүйлд заасан бүртгэлд/ төлөөлөгч бүртгэгдсэн эсэх талаар төлбөрийн байгууллагад мэдэгдэнэ. Бүртгэлд орсны дараа төлөөлөгч төлбөрийн үйлчилгээ үзүүлж эхэлж болно.
3. Эрх бүхий байгууллага 17 дугаар зүйлд заасан бүртгэлд төлөөлөгчийг бүртгэхийн өмнө 1 дэх хэсэгт дурдсан мэдээллийг буруу гэж үзвэл уг мэдээллийг баталгаажуулах нэмэлт арга хэмжээ авна.
4. 1 дэх хэсэгт дурдсан мэдээллийг баталгаажуулсны дараа эрх бүхий байгууллага уг мэдээлэл үнэн зөв гэдэгт эргэлзэж байвал 17 дугаар зүйлд заасан бүртгэлд бүртгүүлэхээс татгалзаж, энэ тухай төлбөрийн байгууллагад цаг алдалгүй мэдэгдэнэ.
5. Төлбөрийн байгууллага нь ЕХ-ны өөр гишүүн улсад төлөөлөгчөөр дамжуулан үйлчилгээгээ санал болгохыг хүсч байгаа эсвэл гуравдагч гишүүн улсад байрлах төлөөлөгчөөр дамжуулан өөр гишүүн улсад үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөж байгаа бол 30 дугаар зүйлд заасан журмыг дагаж мөрдөх ёстой.
6. Гишүүн улсууд Төлөөлөгч нь тухайн төлбөрийн байгууллагыг төлөөлж эсвэл тэдний өмнөөс ажиллаж байгаа тухай хэрэглэгчиддээ заавал мэдэгдэх байдлыг хангана.
7. Гишүүн улсууд төлбөрийн байгууллагууд төлөөлөгчтэй холбоотой аливаа өөрчлөлт, тэр дундаа нэмэлт төлөөлөгчийн талаарх өөрчлөлтийг 2, 3, 4 дэх хэсэгт заасан журмын дагуу цаг алдалгүй мэдээлэх зохицуулалтыг хангана.

20 дугаар зүйл

Цахим мөнгөний үйлчилгээ үзүүлэгч Дистрибьютор

1. Гишүүн улсууд цахим мөнгөний үйлчилгээ үзүүлдэг төлбөрийн байгууллагад дистрибьютерээр дамжуулан цахим мөнгө тараах, эргүүлэн авах боломжийг олгоно.
2. Гишүүн орнууд Дистрибьютерээр дамжуулан цахим мөнгөний үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөж буй төлбөрийн байгууллагууд 19 дүгээр зүйлд заасан шаардлагыг дагаж мөрдүүлнэ.
3. Төлбөрийн байгууллага цахим мөнгөний үйлчилгээг өөр гишүүн улсад дистрибьютерээр дамжуулан түгээхээр төлөвлөж байгаа тохиолдолд энэ удирдамжийн 30-р зүйлийн 5-д заасны дагуу баталсан актыг оролцуулан энэхүү удирдамжийн 31 дүгээр зүйлийн 4, (5) хэсгийг эс тооцвол 30-33 дугаар зүйлүүдийг хэрэглэнэ.

21 дүгээр зүйл

Салбарууд

1. Гишүүн орнууд ЕХ-ны өөр гишүүн улсад салбар байгуулах замаар үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөж байгаа эсвэл гуравдагч гишүүн улс дахь салбараараа дамжуулан өөр гишүүн улсад үйлчилгээ үзүүлэхээр төлөвлөж буй төлбөрийн байгууллагуудад 30 дугаар зүйлд заасан журмыг дагаж мөрдөхийг үүрэг болгох ёстой.
2. Гишүүн орнууд төлбөрийн байгууллагууд өөрсдийн нэрийн өмнөөс ажиллаж буй салбарууддаа энэхүү зохицуулалтын талаар төлбөрийн үйлчилгээний хэрэглэгчдэд мэдээлэх зааварчилгааг өгөх ёстой.

22 дугаар зүйл

Үйл ажиллагааг аутсорсинг хийх аж ахуйн нэгж

1. Гишүүн улсууд төлбөрийн болон цахим мөнгөний үйлчилгээний үйл ажиллагааны чиг үүргийг аутсорсинг хийхээр төлөвлөж буй төлбөрийн байгууллагууд нь энэ тухай өөрийн гишүүн улсын эрх бүхий байгууллагад мэдэгдэхийг баталгаажуулна.

Гишүүн улсууд төлбөрийн байгууллагуудад мэдээлэл, харилцаа холбооны технологи (МХТ) системийг удирдах зэрэг үйл ажиллагааны **чухал үүрэг** даалгаврыг төлбөрийн байгууллагын дотоод хяналтын чанарыг ихээхэн доройтуулах байдлаар шилжүүлэхгүй байхыг анхаарах ёстой. Уг удирдамжийн хэрэгжилтэд хяналт тавих эрх бүхий байгууллагууд төлбөрийн байгууллага энэхүү зааварт заасан бүх үүргээ хэрхэн биелүүлж байгаа эсэхийг үр дүнтэй хянаж, хянах боломжтой байх ёстой.

Төлбөрийн байгууллагын зөвшөөрлийн нөхцөлийг биелүүлэх, зааварт заасан үүргээ биелүүлэх, санхүүгийн үр дүнг хадгалах, төлбөрийн тогтвортой байдал, тасралтгүй байдлыг хангах болон цахим мөнгөний үйлчилгээнд төлбөрийн байгууллагын чадамжид ихээхэн хохирол учруулах, түүнийг хэрэгжүүлэх явцад гарсан аливаа асуудал, доголдол нь үйл ажиллагааны чиг үүргийг **чухал** гэж үзнэ.

Төлбөрийн байгууллагууд үйл ажиллагааныхаа чухал чиг үүргийг аутсорсинг хийхдээ дараах бүх нөхцлийг хангасан байх ёстой. Үүнд:

- (а) Аутсорсинг нь төлбөрийн байгууллагын дээд удирдлагаас татгалзах, хариуцлагаа шилжүүлэхэд хүргэж болохгүй.;
- (б) энэхүү удирдамжийн дагуу төлбөрийн байгууллагын төлбөрийн үйлчилгээний хэрэглэгчидтэй харилцах харилцаа, үүрэг өөрчлөгдөөгүй;
- (в) үйл ажиллагааны тодорхой чиг үүргийг аутсорсингоор гүйцэтгүүлсэн байсан ч төлбөрийн байгууллага нь аутсорсинг хийлгэж байгаа үйл ажиллагаа нь зөвшөөрөл

олгох, байнгын дагаж мөрдөх нөхцөлийг хангах чадварыг сулруулж, эрсдэлд оруулахгүй байх ёстой. Тус байгууллага нь эрх бүхий статусаа хадгалахын тулд шаардлагатай шаардлагыг биелүүлэх үүрэгтэй хэвээр байна;

(г) төлбөрийн байгууллагын зөвшөөрөл олгосон бусад нөхцлүүдийн аль нь ч хасагдсан эсвэл өөрчлөгдөөгүй байх.

2. Гишүүн улсууд төлбөрийн байгууллагууд үйл ажиллагаа нь аутсорсинг хийдэг аж ахуйн нэгжийн ашиглалттай холбоотой аливаа өөрчлөлтийг өөрийн гишүүн улсын эрх бүхий байгууллагад цаг алдалгүй мэдээлэх үүрэгтэй.

23 дугаар зүйл

Хариуцлага

1. Гишүүн улсууд үйл ажиллагааны чиг үүргээ хэрэгжүүлэхэд нь гуравдагч этгээдээс хамааралтай төлбөрийн байгууллагууд удирдамжид заасан шаардлагыг дагаж мөрдөх үндэслэлтэй арга хэмжээ авах ёстойг баталгаажуулах үүрэгтэй.

3. Гишүүн улсууд төлбөрийн байгууллагуудаас ажилчдынхаа үйлдэл, түүнчлэн төлөөлөгч, дистрибьютер, салбар, үйл ажиллагаагаа аутсорсинг хийдэг аж ахуйн нэгжийн хийсэн аливаа үйлдлийн төлөө бүрэн хариуцлага хүлээхийг шаардах үүрэгтэй.

3 ДУГААР БҮЛЭГ

ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГА БА ХЯНАЛТ

24 дүгээр зүйл

Эрх бүхий байгууллагуудыг томилох

1. Гишүүн улсууд төлбөрийн байгууллагад зөвшөөрөл олгох, зохистой хяналт тавих эрх бүхий байгууллагуудыг томилох шаардлагатай. Эдгээр эрх бүхий байгууллагууд нь төрийн байгууллага эсвэл үндэсний хуулиар албан ёсоор хүлээн зөвшөөрөгдсөн байгууллага, түүний дотор төв банк байж болно.

Гишүүн улсууд төлбөрийн байгууллага, зээлийн байгууллага, шуудангийн сүлжээ байгууллагыг эрх бүхий байгууллага болгон томилж болохгүй.

Эрх бүхий байгууллага нь эдийн засгийн байгууллагаас хараат бус байж, ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх ёстой.

Гишүүн улсууд эхний дэд хэсэгт заасны дагуу томилогдсон эрх бүхий байгууллагын нэр, холбоо барих хаягийг Комисст хүргүүлнэ.

2. 1 дэх хэсэгт заасан эрх бүхий байгууллагууд үүргээ биелүүлэхэд шаардлагатай бүх эрх мэдлээр хангагдахыг Гишүүн улсууд баталгаажуулна.

Гишүүн улсууд эрх бүхий байгууллагуудыг үүрэг даалгавраа хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөц, ялангуяа тусгайлсан ажилтнуудтай байлгахыг баталгаажуулна.

3. Гишүүн улсууд энэ бүлэгт заасан асуудлаар нэгээс олон тооны эрх бүхий байгууллагыг томилсон, эсхүл зээлийн байгууллагуудад хяналт тавих эрх бүхий байгууллагаар томилогдсон бол тусын үүргээ биелүүлэхийн тулд тэдгээр нь хоорондоо нягт, үр дүнтэй хамтран ажиллах нөхцлийг бүрдүүлнэ.
4. 1-д дурдсан эрх бүхий байгууллагад хүлээлгэсэн үүрэг, даалгавар нь тухайн гишүүн улсын эрх бүхий байгууллагын үүрэг байна.
5. 1-р зүйл нь эрх бүхий байгууллагууд төлбөрийн байгууллагуудын бизнесийн бүх үйл ажиллагаанд хяналт тавих үүрэгтэй биш бөгөөд тэдний хяналт нь 10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн (а) хэсэгт дурдсан төлбөрийн үйлчилгээ үзүүлэх, үйл ажиллагаа явуулахтай холбоотой байна.

25 дугаар зүйл

Хяналт

1. Энэ заалтыг үргэлжлүүлэн дагаж мөрдөж байгаа эсэхийг шалгах эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлж буй хяналтын үйл ажиллагаа нь төлбөрийн байгууллагуудын нүүр тулгарч буй эрсдлийн эсрэг пропорциональ, хангалттай, хариу үйлдэл үзүүлж буй эсэхийг баталгаажуулна.

Энэ гарчигтай нийцэж байгаа эсэхийг шалгахын тулд эрх бүхий байгууллагууд ялангуяа дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

(а) Эрх бүхий байгууллага нь төлбөрийн байгууллагаас хяналтыг хэрэгжүүлэхтэй холбоотой мэдээ, мэдээллийг авах эрхтэй бөгөөд мэдээлэл авах зорилго, тухайн мэдээллийг өгөх эцсийн хугацааг тусгаж өгнө.

(б) төлбөрийн байгууллагын ажлын байр, төлбөрийн байгууллагад харъяалагдах төлбөрийн үйлчилгээ, цахим мөнгөний үйлчилгээ үзүүлж буй аливаа төлөөлөгч, дистрибьютер, салбар болон үйл ажиллагааг нь аутсорсингаар гүйцэтгэж буй аливаа байгууллагын ажлын байранд газар дээр нь шалгалт хийх;

(в) зөвлөмж, удирдамж, шаардлагатай бол заавал биелүүлэх захиргааны заалтуудыг гаргах;

(г) 16 дугаар зүйлд заасны дагуу зөвшөөрлийг түдгэлзүүлэх буюу эргүүлэн татах.

2. 16 дугаар зүйл болон үндэсний эрүүгийн хуулийн аливаа заалтын нөлөөллийг эс тооцвол гишүүн орнууд өөрсдийн эрх бүхий байгууллагад илэрсэн зөрчлийг шийдвэрлэх, түүний үндсэн шалтгааныг арилгахад чиглэсэн шийтгэл, арга хэмжээг хэрэгжүүлэхийг зөвшөөрөх ёстой. Энэ нь энэхүү удирдамжийг шилжүүлэхэд заасан дүрмийг зөрчсөн төлбөрийн байгууллага эсвэл эдгээр байгууллагын бизнесийг хянадаг хувь хүмүүст хамаарна.
3. 5 дугаар зүйл, 6 дугаар зүйлийн 1, (2), 7 дугаар зүйл, 8 дугаар зүйлд заасан тодорхойлолтыг үл харгалзан гишүүн улсууд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хөндлөнгийн эрх мэдэлтэй байх ёстой. Энэ нь төлбөрийн байгууллагуудын хөрөнгийн зохих түвшинг хангахад чиглэгддэг, ялангуяа төлбөрийн үйлчилгээ эсвэл цахим мөнгөний үйлчилгээнээс гадуурх үйл ажиллагаа нь санхүүгийн тогтвортой байдалд аюул учруулах эсвэл эрсдэлд оруулах магадлалтай үед ялангуяа хамааралтай.

26 дугаар зүйл

Мэргэжлийн нууцлал

1. Гишүүн улсууд үндэсний эрүүгийн хуультай харшлахгүйгээс бусад тохиолдолд эрх бүхий байгууллагад ажиллаж байсан болон ажиллаж байгаа нийт хүн болон эрх бүхий байгууллагын нэрийн өмнөөс ажиллаж байгаа аливаа шинжээч нар мэргэжлийн нууцлалыг хадгалах үүрэгтэй.
2. Хувь хүний болон бизнесийн эрхийг хамгаалах үүднээс 28 дугаар зүйлд заасны дагуу солилцсон мэдээллийг мэдээлэл хуваалцсан болон хүлээн авагч аль аль тал мэргэжлийн нууцлалыг хадгалах үүрэгтэй.
3. Гишүүн улсууд 2013/36/ЕХ-ны удирдамжийн 53-61 дүгээр зүйл, шаардлагатай бүх өөрчлөлтийг харгалзан энэхүү заалтыг хэрэглэж болно.

27 дугаар зүйл

Шүүхэд хандах эрх

1. Гишүүн улсууд энэхүү удирдамжийн дагуу батлагдсан хууль тогтоомж, дүрэм журам, захиргааны зохицуулалтын дагуу төлбөрийн байгууллагын талаар эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг шүүхэд маргаан үүсгэх боломжтой байдлыг баталгаажуулна.
2. 1 дэх заалт эс үйлдэхүйд мөн хамааралтай хэрэглэгдэнэ.

28 дугаар зүйл

Хамтран ажиллах ба мэдээлэл солилцох

1. Гишүүн орнуудын эрх бүхий байгууллагууд өөр хоорондоо болон шаардлагатай тохиолдолд Европын Төв банк, гишүүн орнуудын үндэсний төв банкууд, ЕБГ болон Холбооны бөгөөд үндэсний хуулийн дагуу төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдэд хамаарах асуудал эрхлэх холбогдох бусад эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллана.
2. Гишүүн улсууд эрх бүхий байгууллага болон дараах байгууллага хооронд мэдээлэл солилцохыг зөвшөөрнө:
 - (а) Өргөдөл гаргагч төлбөрийн байгууллагад зөвшөөрөл олгох, төлбөрийн байгууллагуудад хяналт тавих үүрэгтэй бусад гишүүн улсын эрх бүхий байгууллагууд;
 - (б) Мөнгөний болон хяналтын байгууллагын хувьд Европын төв банк болон гишүүн орнуудын үндэсний төв банкууд, шаардлагатай тохиолдолд төлбөр тооцооны системд хяналт тавих үүрэгтэй төрийн бусад байгууллага;
 - (в) энэхүү удирдамжийн дагуу томилогдсон болон холбооны бусад хууль, түүний дотор (ЕХ) 2015/849 удирдамжийн дагуу байгуулагдсан төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчдэд хамаарах бусад холбогдох эрх бүхий байгууллага;
 - (г) ЕХ-ны 1093/2010 тоот журмын 1(5) зүйлийн (а) хэсэгт дурдсан хяналтын механизмыг үр дүнтэй, тууштай ажиллуулахад хувь нэмэр оруулах чадавхаараа ЕБГ .

29 дүгээр зүйл

Гишүүн орнуудын эрх бүхий байгууллагуудын хоорондын санал зөрөлдөөнийг шийдвэрлэх

1. 28, 30, 31, 32, 33 дугаар зүйлд заасны дагуу өөр гишүүн улсын эрх бүхий байгууллагатай тодорхой асуудлаар хил дамнасан хамтын ажиллагаа хэрэгжүүлэх нөхцөл хангагдаагүй гэж үзсэн гишүүн улсын эрх бүхий байгууллага (ЕХ) 1093/2010 тоот журмын 19 дүгээр зүйлд заасны дагуу ЕБГ-г хандаж, тусламж хүсч болно.
2. 1-д заасны дагуу туслалцаа үзүүлэх хүсэлт ирсэн тохиолдолд ЕБГ нь (ЕХ) 1093/2010 тоот журмын 19(3) зүйлийн дагуу шийдвэрээ цаг алдалгүй гаргана. Мөн ЕБГ нь тухайн журмын 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн хоёр дахь хэсэгт заасны дагуу эрх бүхий байгууллагад өөрийн санаачилгаар тохиролцоонд хүрэхэд тусалж болно. Аль ч тохиолдолд холбогдох эрх бүхий байгууллага уг журмын 19 дүгээр зүйлд заасны дагуу шийдвэр гарах хүртэл өөрсдийн шийдвэрээ хойшлуулна.

30 дугаар зүйл

**Үүсгэн байгуулах эрх, үйлчилгээ үзүүлэх эрх чөлөөг
хэрэгжүүлэх хүсэлт гаргах**

1. Гишүүн улсууд төлбөрийн болон цахим мөнгөний үйлчилгээг өөрийн гишүүн улсаас өөр гишүүн улсад, тэр дундаа гуравдагч гишүүн улс дахь байгууллагаар дамжуулан анх удаа үзүүлэхийг хүссэн аливаа төлбөрийн байгууллага нь **үүсгэн байгуулах эрх болон үйлчилгээ үзүүлэх эрх чөлөө**-ний хүрээнд дараах мэдээллийг өөрийн гишүүн улсын эрх бүхий байгууллагад уламжилна. Үүнд:

- (а) төлбөрийн байгууллагын нэр, хаяг, шаардлагатай бол зөвшөөрлийн дугаар;
- (б) төлбөрийн байгууллага ажиллахаар төлөвлөж буй гишүүн улс(ууд) болон энэ гишүүн улсад үйл ажиллагаагаа эхлүүлэхээр төлөвлөж буй огноо;
- (в) төлбөрийн байгууллагаас үзүүлэхээр төлөвлөж буй төлбөрийн болон цахим мөнгөний үйлчилгээ(нүүд);
- (г) төлбөрийн байгууллага нь төлөөлөгч буюу дистрибьютерийг ашиглахаар төлөвлөж байгаа бол 19(1) ба 20(2) зүйлд дурдсан мэдээлэл;
- (д) төлбөрийн байгууллага салбараа ашиглахаар төлөвлөж байгаа бол:
 - (i) хүлээн авагч гишүүн улсад төлбөрийн болон цахим мөнгөний үйлчилгээний бизнесийн талаар 3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн (b) болон (e) хэсэгт дурдсан мэдээлэл;
 - (ii) салбарын зохион байгуулалтын бүтцийн тайлбар;
 - (iii) салбарын удирдлагыг хариуцах хүмүүсийн нэр.

Гишүүн улсууд төлбөрийн болон цахим мөнгөний үйлчилгээний үйл ажиллагааны чиг үүргийг хүлээн авагч улсын бусад аж ахуйн нэгжид аутсорсинг хийх гэж буй бол энэ тухай өөрийн гишүүн улсын эрх бүхий байгууллагад мэдэгдэх үүрэгтэй.

2. Тухайн гишүүн улсын эрх бүхий байгууллага 1 дэх хэсэгт дурдсан бүх мэдээллийг хүлээн авснаас хойш 1 сарын дотор тухайн мэдээллийг хүлээн авагч гишүүн улсын эрх бүхий байгууллагад илгээнэ. Үйлчилгээг гуравдагч гишүүн улсаар дамжуулан үзүүлж байгаа тохиолдолд төлбөрийн үйлчилгээний хэрэглэгчдэд үйлчилгээ үзүүлж байгаа газрын гишүүн улсад мэдэгдэх ёстой.

Тухайн улсын эрх бүхий байгууллагаас мэдээлэл хүлээн авснаас хойш 1 сарын дотор хүлээн авагч улсын эрх бүхий байгууллага мэдээллийг хянаж үзээд **үүсгэн байгуулах эрх болон үйлчилгээ үзүүлэх эрх чөлөө**-ний хүрээнд төлбөрийн болон цахим мөнгөний үйлчилгээг санал болгох талаар холбогдох дэлгэрэнгүй мэдээллийг хуваалцах ёстой.

Төлөөлөгч, дистрибьютер, салбар байгуулах гэж байгаатай холбогдуулан Хүлээн авагч гишүүн улсын эрх бүхий байгууллага нь (ЕХ) 2015/849 Удирдамжийн хүрээнд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой анхаарал татахуйц асуудлын тухай тухайн гишүүн улсын эрх бүхий байгууллагад мэдээлэх ёстой. Үүнээс өмнө хүлээн авагч гишүүн улсын эрх бүхий байгууллага (ЕХ) 2015/849 Захирамжийн 7(2) зүйлд дурдсанаар өөрийн холбогдох эрх бүхий байгууллагатай холбогдож, ийм үндэслэл байгаа эсэхийг тогтооно.

Хүлээн авагч гишүүн улсын эрх бүхий байгууллагуудын үнэлгээтэй санал нийлэхгүй байгаа гишүүн улсын эрх бүхий байгууллагууд энэ талаарх үндэслэлээ танилцуулна.

Хүлээн авагч гишүүн улсын эрх бүхий байгууллагаас хүлээн авсан мэдээллийн дагуу тухайн улсын эрх бүхий байгууллагын үнэлгээ таатай биш байх бол тухайн улсын гишүүн улсын эрх бүхий байгууллага төлөөлөгч, салбар, дистрибьютерийг бүртгэхээс татгалзах, эсвэл бүртгэл хийгдсэн бол түүнийг цуцална.

3. Гарал үүслийн гишүүн улсын эрх бүхий байгууллага 1 дэх хэсэгт дурдсан мэдээллийг хүлээн авснаас хойш 3 сарын дотор шийдвэрээ хүлээн авагч гишүүн улсын эрх бүхий байгууллага болон төлбөрийн байгууллагад мэдэгдэнэ.

17 дугаар зүйлд дурдсан бүртгэлд бүртгүүлсний дараа төлөөлөгч, дистрибьютер эсвэл салбар нь холбогдох хүлээн авагч гишүүн улсад үйл ажиллагаагаа эхлүүлж болно.

Гишүүн улсууд төлбөрийн байгууллага нь тухайн хүлээн авагч гишүүн улс дахь төлөөлөгч, дистрибьютер эсвэл салбараараа дамжуулан төлбөрийн байгууллагын нэрийн өмнөөс явуулж буй үйл ажиллагаа эхлэх огноог тухайн улсын гишүүн улсын эрх бүхий байгууллагад мэдэгдэхийг баталгаажуулна. Гарал үүслийн гишүүн улсын эрх бүхий байгууллагууд энэ тухай хүлээн авагч гишүүн улсын эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ.

4. Гишүүн улсууд 1-р зүйлд дурдсанчлан өмнө нь хуваалцсан мэдээлэлд гарсан аливаа чухал өөрчлөлтийг гарал үүслийн гишүүн улсын эрх бүхий байгууллагад нэн даруй мэдэгдэх ёстой. Үүнд төлбөрийн байгууллагын үйл ажиллагаа явуулдаг хүлээн авагч гишүүн дэх аутсорсингийн үйл ажиллагаа эрхэлдэг нэмэлт төлөөлөгч, дистрибьютер, салбар, аж ахуйн нэгжийн талаарх шинэчлэлийн мэдээлэл орно. 2 ба 3-р зүйлд дурдсан үйл ажиллагаа мөн хийгдэх ёстой.

5. ЕБГ нь энэ зүйлд заасны дагуу тухайн улсын болон хүлээн авагч гишүүн улсын эрх бүхий байгууллага хоорондын хамтын ажиллагаа, мэдээлэл солилцох хүрээг тодорхойлсон зохицуулалтын техникийн стандартын төслийг боловсруулна. Эдгээр зохицуулалтын техникийн стандартын төсөлд хил дамнасан зарчмаар үйл ажиллагаа явуулж буй төлбөрийн байгууллагуудад мэдэгдэх хамтын ажиллагааны арга, хэрэгсэл, дэлгэрэнгүй мэдээллийг тусгасан байна. Ялангуяа, мэдээлэх үйл явцыг тууштай, үр дүнтэй явуулахын тулд нийтлэг нэр томъёо, стандарт мэдэгдлийн загваруудыг багтаасан мэдээллийн хамрах хүрээг багтаана.

ЕБГ нь эдгээр зохицуулалтын техникийн стандартын төслийг Комисст [ОН/ энэ удирдамж хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 18 сарын дараа огноог оруулна уу] - ээр хүргүүлнэ.

(ЕХ) No 1093/2010 журмын 10-14 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулалтын техникийн стандартыг батлах эрхийг Комисст шилжүүлсэн.

31 дүгээр зүйл

Үйлчилгээ үзүүлэх эрх чөлөө, байгуулах эрхээ эдэлж буй төлбөрийн байгууллагуудад хяналт тавих

1. Хэрэв төлбөрийн байгууллага нь ижил зохицуулалтын тогтолцоонд (Гишүүн улс) өөр улсад төлөөлөгч, дистрибьютер, салбар зэрэг үйл ажиллагаа явуулдаг бол тухайн улсын эрх баригчид (байгууллага байрладаг) хүлээн авагч улсын эрх бүхий байгууллагатай хамтран ажиллах ёстой. Энэхүү хамтын ажиллагаанд тухайн хүлээн авагч улсын эрх баригчид тухайн байгууллагын үйл ажиллагааг тухайн хүлээн авагч улсад шалгахаар төлөвлөж байгаа эсэхийг урьдчилан мэдэгдэх зэрэг багтана.

Гарал үүслийн улсын эрх бүхий байгууллага (төлбөрийн байгууллага байрладаг) тухайн байгууллагад газар дээр нь шалгалт хийх үүрэг хариуцлагыг хүлээн авагч улсын (байгууллага үйл ажиллагаа явуулж байгаа) эрх бүхий байгууллагад даалгах эсвэл шилжүүлэхээр сонгож болно.

2. Төлбөрийн байгууллага нь төлөөлөгч, дистрибьютер эсвэл салбартай улс орны эрх баригчид тухайн улс дахь үйл ажиллагааныхаа талаар тогтмол тайлан гаргаж байх шаардлагыг тавьж болно.

Тайлан нь мэдээллийн болон статистикийн зориулалтаар ашиглагдана. Мөн төлөөлөгч, дистрибьютер эсвэл салбарууд төлбөрийн үйлчилгээ эсвэл цахим мөнгөний үйлчилгээ үзүүлж байгаа тул ХХХ журмын [PSR] II ба III бүлэгт нийцэж байгаа эсэхэд хяналт тавихад мөн шаардлагатай. Ийм төлөөлөгч, дистрибьютер эсвэл салбар нь 26-р зүйлд заасантай дүйцэхүйц мэргэжлийн нууцлалын шаардлагыг хангана.

Төлбөрийн байгууллага тодорхой журамд заасан дүрмийг дагаж мөрддөггүйг нотлох баримттай бол үйл ажиллагаа явуулж буй улсын эрх бүхий байгууллага нь тухайн байгууллагаас нэмэлт мэдээлэл авах хүсэлтийг тухай бүр гаргаж болно.

3. Гарал үүслийн улсын (төлбөрийн байгууллага байрладаг) болон хүлээн авагч улсын (байгууллага нь үйл ажиллагаа явуулдаг) эрх бүхий байгууллагууд чухал болон шаардлагатай мэдээллийг бие биетэйгээ хуваалцах үүрэгтэй бөгөөд ялангуяа төлбөрийн байгууллагын төлөөлөгч, дистрибьютер эсвэл салбаруудын **үйлчилгээ**

үзүүлэх эрх чөлөө, байгуулах эрхийг эдлэхтэй холбогдуулан зөрчил, зөрчилтэй байх магадлалтай байгаа тохиолдолд энэ нь онцгой чухал юм.

Эрх бүхий байгууллагын хүсэлтийн дагуу холбогдох бүх мэдээллийг хуваалцаж, төлбөрийн байгууллага тогтоосон нөхцөлийг дагаж мөрдөж байгаа талаарх дэлгэрэнгүй мэдээллийг оруулах шаардлагатай. Эрх бүхий байгууллагууд хүсэлтийн дагуу холбогдох бүх мэдээлэл, тэр дундаа төлбөрийн байгууллага 13 дугаар зүйлийн 3-т заасан нөхцөлийг дагаж мөрдөж байгаа эсэх мэдээллийг хуваалцана.

4. Зохицуулалтын хүрэн дэх улс орнууд үндсэн оффис нь өөр улсад байдаг агентуудаар дамжуулан нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулдаг төлбөрийн байгууллагууд хил доторх төв холбоо барих цэгийг томилох шаардлага тавьж болно. Энэ нь үр дүнтэй харилцаа холбоог хангах, мэдээллийг тодорхой журмын дагуу зөв тайлагнаж, гарал үүслийн улсын болон хүлээн авагч улсын (агентуудаар дамжуулан үйл ажиллагаа явуулдаг) эрх баригчдад хяналт тавихад хялбар болгох зорилготой юм. Томилогдсон төв холбоо барих цэг нь эрх бүхий байгууллагын хүсэлтээр бичиг баримт, мэдээллээр хангах үүрэгтэй.
5. Европын Банкны байгууллага /ЕВА/ нь пропорциональ зарчимд үндэслэн төвлөрсөн холбоо барих цэгийг томилох шаардлагыг тухай шийдвэрлэх шалгуурыг тодорхойлсон нарийвчилсан дүрэм (зохицуулалтын техникийн стандарт) бий болгох үүрэгтэй. Эдгээр төв холбоо барих цэгүүд ямар үүрэг гүйцэтгэх ёстойг эдгээр дүрмүүд мөн тодорхойлно.

Ялангуяа дээрх зохицуулалтын техникийн стандартын төсөлд дараах зүйлийг харгалзан үзнэ. Үүнд:

- (а) хүлээн авагч гишүүн улсуудад төлбөрийн байгууллагаас хийсэн гүйлгээний нийт хэмжээ, үнэ цэнэ;
- (б) үзүүлж буй төлбөрийн үйлчилгээний төрөл;
- (в) хүлээн авагч гишүүн улсад байгуулагдсан төлөөлөгчдийн нийт тоо.

Европын Банкны байгууллага /ЕВА/ нь эдгээр зохицуулалтын техникийн стандартын төслийг Комисст [ОН/ энэ удирдамж хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 18 сарын дараа огноог оруулна уу] -ээр ирүүлнэ.

(ЕХ) No 1093/2010 журмын 10-14 дүгээр зүйлд заасны дагуу зохицуулалтын техникийн стандартыг батлах эрхийг Комисст шилжүүлсэн.

**Зөрчлийн үед авах арга хэмжээ,
түүний дотор урьдчилан сэргийлэх арга хэмжээ**

1. Хүлээн авагч гишүүн улсын эрх бүхий байгууллага өөрийн нутаг дэвсгэрт төлөөлөгч, дистрибьютер эсвэл салбартай төлбөрийн байгууллагын үйл ажиллагаа нь энэхүү гарчиг эсвэл ХХХ дүрмийн II, III хэсэгтэй нийцэхгүй, дагаж мөрдөхгүй байна хэмээн үзвэл энэ тухай төлбөрийн байгууллага байрладаг гишүүн улсын эрх бүхий байгууллагад цаг алдалгүй мэдэгдэнэ.

Гарал үүслийн улсын эрх бүхий байгууллага нь эхний дэд хэсэгт заасны дагуу хүлээн авсан мэдээлэлд үнэлгээ хийсний дараа холбогдох төлбөрийн байгууллага дагаж мөрдөөгүй байдлаа таслан зогсоохын тулд зохих бүх арга хэмжээг цаг алдалгүй авна. Гарал үүслийн улсын эрх бүхий байгууллага эдгээр арга хэмжээг хүлээн авагч гишүүн улсын эрх бүхий байгууллага болон холбогдох бусад гишүүн улсын эрх бүхий байгууллагад цаг алдалгүй мэдэгдэнэ.

2. Хүлээн авагч гишүүн улсын төлбөрийн үйлчилгээ хэрэглэгчдийн хамтын ашиг сонирхолд ноцтой аюул занал учруулж буй онцгой байдлын үед яаралтай арга хэмжээ авах шаардлагатай бол хүлээн авагч гишүүн улсын эрх бүхий байгууллагууд 31 дүгээр зүйлд заасан эрх бүхий байгууллага болон гарал үүслийн улсын эрх бүхий байгууллагаас хүлээгдэж буй хил дамнасан хамтын ажиллагааны зэрэгцээ урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.
3. 2-т заасан урьдчилан сэргийлэх аливаа арга хэмжээ нь хүлээн авагч гишүүн улсын төлбөрийн үйлчилгээний хэрэглэгчдийн хамтын ашиг сонирхолд ноцтой аюул занал учруулахаас хамгаалах зорилготой зохистой бөгөөд пропорциональ байна. Хэрэгжүүлсэн аливаа арга хэмжээ нь үйл ажиллагаа явуулдаг улсынхаа төлбөрийн байгууллагын хэрэглэгчдэд (хүлээн авагч гишүүн улс) бусад орны (бусад гишүүн улс) хэрэглэгчдэд давуу эрх олгох ёсгүй. Энэ нь зохицуулалтын хүрээнд байршил харгалзахгүйгээр бүх хэрэглэгчдэд шударга ёс, тэгш байдлыг хангах зорилготой юм.

Тодорхойлогдсон ноцтой аюул заналхийллийн хариуд авсан урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь түр зуурынх байх бөгөөд аюул заналхийллийг арилгасны дараа эдгээр арга хэмжээг цуцлана. Шийдвэрийг 29 дүгээр зүйлийн 1-д заасны дагуу тухайн улсын гишүүн улсын эрх бүхий байгууллагуудын туслалцаа, хамтын ажиллагаа эсвэл ЕБГ-ын оролцоотойгоор гүйцэтгэж болно.

4. Онцгой байдлын нөхцөл байдалд нийцэж байгаа тохиолдолд хүлээн авагч гишүүн улсын эрх бүхий байгууллагууд 2 дахь хэсгийн дагуу авсан урьдчилан сэргийлэх арга хэмжээ болон түүний үндэслэлийн талаар өөрийн гишүүн улсын эрх бүхий байгууллага болон холбогдох бусад гишүүн улсын эрх бүхий байгууллага, Комисс болон ЕБГ-т ямар ч тохиолдолд хойшлуулалгүйгээр урьдчилан мэдээлнэ.

33 дугаар зүйл

Шалтгаан ба харилцан мэдээлэх

1. 25, 30, 31, 32 дугаар зүйлийн дагуу эрх бүхий байгууллагаас авсан торгууль, үйлчилгээ үзүүлэх эрх чөлөө, эсхүл байгуулах эрх чөлөөг хязгаарлахтай холбоотой аливаа арга хэмжээ нь зохих ёсны үндэслэлтэй байх ёстой бөгөөд холбогдох төлбөрийн байгууллагад мэдэгдэнэ.
2. 30, 29, 32-р зүйлийн агуулга нь (ЕХ) 2015/849 заавар болон (ЕХ) 2015/847-д заасан зохицуулалтын байгууллагуудын хариуцлагыг үгүйсгээгүй эсвэл бууруулаагүй болно. Тодруулбал, (ЕХ) 2015/849 удирдамжийн 47(1) зүйл, (ЕХ) 2015/847 журмын 22(1) зүйлд тусгасны дагуу эдгээр баримт бичигт заасан шаардлагуудын хэрэгжилтэд хяналт тавьж, баталгаажуулах эрх бүхий байгууллагуудын үүрэг хэвээр байна.

II БҮЛЭГ

Чөлөөлөлт ба мэдэгдэл

34 дүгээр зүйл

Нэмэлт чөлөөлөлт

1. Гишүүн улсууд I хавсралтын 1-5-д заасны дагуу төлбөрийн үйлчилгээ үзүүлж буй хувь хүн, хуулийн этгээдийг, эсвэл цахим мөнгөний үйлчилгээ үзүүлж буй журмын I бүлгийн 1, 2, 3-т заасан нөхцөлүүдийг бүх буюу хэсэгчлэн хэрэглэхээс чөлөөлж, эсвэл чөлөөлөхийг зөвшөөрч болно. Үүнд 17, 18, 24, 26, 27 болон 28 дугаар зүйлс хамаарахгүй бөгөөд дараах нөхцлийг харгалзана. Үүнд:
 - (а) төлбөрийн үйлчилгээний хувьд холбогдох хүний гүйцэтгэсэн төлбөрийн гүйлгээний өмнөх 12 сарын нийт үнийн дүнгийн сарын дундаж нь /түүний хариуцлагыг бүрэн хариуцах аливаа төлөөлөгчийг оролцуулан/ гишүүн улсын тогтоосон хязгаараас хэтрэхгүй байх, гэхдээ энэ нь ямар ч тохиолдолд 3 сая еврогоос ихгүй байх; эсвэл
 - (б) цахим мөнгөний үйлчилгээний хувьд нийт бизнесийн үйл ажиллагаа нь гишүүн улсаас тогтоосон хязгаараас хэтрээгүй боловч ямар ч тохиолдолд 5 сая еврогоос хэтрээгүй цахим мөнгөний дундаж үлдэгдэл хэмжээг бий болгодог; болон
 - (в) төлбөрийн үйлчилгээ болон цахим мөнгөний үйлчилгээний хувьд тухайн бизнесийн удирдлага, үйл ажиллагааг хариуцах хувь хүмүүсийн хэн нь ч мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй холбоотой гэмт хэрэг, санхүүгийн бусад гэмт хэрэгт буруутгагдаж байгаагүй.

(а) дахь дэд хэсгийн хүрээнд эрх бүхий байгууллагаас уг төлөвлөгөөнд засвар оруулахыг шаардаагүй бол хязгаарыг хэтрүүлсэн эсэхийг үнэлэхдээ бизнесийн төлөвлөгөөнд тусгагдсан төлбөрийн нийт гүйлгээний дүнг үндэслэн тооцно.

Хэрэв төлбөрийн байгууллага нь бусад төлбөрийн үйлчилгээ, үйл ажиллагааны хамт /10 дугаар зүйлд заасан/ цахим мөнгөний үйлчилгээг санал болгож байгаа бөгөөд гүйлгээнд байгаа цахим мөнгөний хэмжээг урьдчилан тооцоолох боломжгүй бол зохицуулах байгууллага нь эхний дэд хэсгийн (б) төлөөллийн хэсэгт үндэслэн тухайн байгууллагад тодорхой дүрмийг хэрэглэхийг зөвшөөрч болно. Энэхүү төлөөллийн хэсгийг түүхэн өгөгдлийг ашиглан тодорхойлсон бөгөөд эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсны үндсэн дээр үндэслэлтэй тооцоолсон байх ёстой.

ГАРЧИГ III

ТӨЛӨӨЛЛИЙН ДҮРЭМ БОЛОН ЗОХИЦУУЛАЛТЫН ТЕХНИКИЙН СТАНДАРТ

40 дүгээр зүйл

Төлөвлөсөн үйлдлүүд

Комисс нь 41 дүгээр зүйлд заасан бүрэн эрхийн дагуу 5 дугаар зүйл, 34 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 37 дугаар зүйлд заасан үнийн дүнг инфляцийн дагуу шинэчлэн тогтоох эрхтэй.

41 дүгээр зүйл

Төлөөллийг хэрэгжүүлэх

1. Энэ зүйлд заасан нөхцлийн дагуу төлөөллийн эрх шилжүүлсэн акт гаргах эрхийг Комиссд олгоно.
2. 40 дүгээр зүйлд заасны дагуу төлөөллийн эрх шилжүүлсэн акт гаргах эрх нь энэхүү удирдамж хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш тодорхой бус хугацаагаар Комиссд олгоно.
3. 40 дүгээр зүйлд заасан эрх мэдлийг Европын парламент эсвэл Зөвлөл хэдийд ч цуцалж болно. Хүчингүй болгох шийдвэр нь тухайн шийдвэрт заасан эрх мэдлийг шилжүүлэхийг дуусгавар болгоно. Энэхүү хүчингүй болгох шийдвэр нь Европын Холбооны албан ёсны сэтгүүлд нийтлэгдсэний маргааш буюу түүнд заасан хожуу өдөр хүчин төгөлдөр болно. Энэ нь аль хэдийн хүчин төгөлдөр болсон эрх шилжүүлсэн актуудын хүчин төгөлдөр байдалд нөлөөлөхгүй.
4. Төлөвлөсөн актыг баталсны дараа Комисс нь Европын Парламент болон Зөвлөлд нэн даруй мэдэгдэнэ.
5. 40-р зүйлд заасны дагуу баталсан хууль тогтоомж нь Европын парламент болон Зөвлөлийн аль аль нь уг актыг хоёр байгууллагад мэдэгдсэнээс хойш 3 сарын дотор эсэргүүцэл илэрхийлээгүй тохиолдолд л хүчин төгөлдөр болно. Өөрөөр хэлбэл, энэ хугацаа дуусахаас өмнө Европын парламент, Зөвлөл хоёулаа Комисст эсэргүүцэхгүй гэдгээ мэдэгдсэн тохиолдолд уг акт хүчин төгөлдөр болно. Энэ хугацааг Европын парламент эсвэл Зөвлөлийн санаачилгаар 3 сараар сунгаж болно.

ГАРЧИГ IV

ТӨГСГӨЛИЙН ЗААЛТУУД

42 дугаар зүйл

Эрх зүйн баримт бичгүүдийн бүрэн зохицол

1. Энэхүү заавар нь уялдуулсан заалтуудыг агуулсан тул 6(3) болон 34 дүгээр зүйлд харшлахгүйгээр гишүүн улсууд энэхүү зааварт зааснаас өөр эрх зүйн баримт бичиг мөрдөх болон батлахгүй.
2. 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг эсвэл 34 дүгээр зүйлд дурдсан хувилбаруудын аль нэгийг ашигласан гишүүн улс энэ тухай болон дараагийн өөрчлөлтийн талаар Комисст мэдэгдэнэ. Комисс нь мэдээллийг вэб сайт эсвэл бусад хялбар хандах боломжтой хэрэгслээр олон нийтэд ил болгоно.
3. Гишүүн улсууд төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид энэхүү удирдамжийг шилжүүлэн суулгах үндэсний хууль тогтоомжийн заалтуудыг чанд мөрдөж, үндэсний хууль тогтоомжид тодорхой зөвшөөрөөгүй бол төлбөрийн үйлчилгээний хэрэглэгчдэд хохирол учруулах аливаа хязгаарлалтаас зайлсхийхийг баталгаажуулах үүрэгтэй. Гэсэн хэдий ч төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчид төлбөрийн үйлчилгээний хэрэглэгчдэд илүү ашигтай нөхцөл санал болгох өөрийн үзэмжтэй байна.

43 дугаар зүйл

Хяналтын заалт

1. Комисс нь [хугацааг зааж өгөх = энэхүү удирдамж хүчин төгөлдөр болсноос хойш 5 жилийн дараа огноог оруулна уу] Европын парламент, Зөвлөл, ЕБГ болон Европын эдийн засаг, нийгмийн хороонд энэхүү Удирдамжийн хэрэгжилтийн нөлөөллийн талаарх тайланг хүргүүлнэ. Үүнд:
 - а) энэхүү Удирдамжийн хамрах хүрээний зохистой байдал, ялангуяа төлбөрийн системийн үйл ажиллагаа, техникийн үйлчилгээ үзүүлэх, түүний дотор дижитал түрийвч боловсруулах зэрэг зарим үйлчилгээний хүрээнд хамрагдаагүй боломжийн талаар;
 - б) 2014/49/ЕХ-ны удирдамжийн шинэчилсэн найруулга нь төлбөрийн байгууллагуудын харилцагчийн хөрөнгийг хамгаалахад үзүүлэх нөлөө. Шаардлагатай бол Комисс хууль тогтоомжийн төслийг тайлангийн хамт өргөн мэдүүлнэ.
2. Комисс нь [хугацааг зааж өгөх = Төлбөрийн үйлчилгээний журмыг мөрдөж эхэлсэн өдрөөс хойш гурван жилийн дараа] Европын парламент, Зөвлөл, ЕБГ болон Европын эдийн засаг, нийгмийн хороонд энэхүү Удирдамжийн хамрах хүрээний, ялангуяа төлбөрийн систем, төлбөрийн схем болон техникийн үйлчилгээ үзүүлэгчдийн

талаархи тайланг хүргүүлнэ. Шаардлагатай бол Комисс уг тайлангийн хамт хууль тогтоомжийн төслийг өргөн мэдүүлнэ.

44 дүгээр зүйл

Шилжилтийн заалтууд

1. Гишүүн улсууд (ЕХ) 2015/2366 дугаар удирдамжийн 11 дүгээр зүйлд заасны дагуу зөвшөөрөл авсан төлбөрийн байгууллагуудад [огноо оруулах = энэ удирдамж хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 18 сарын дараа] хугацаанд төлбөрийн үйлчилгээг үзүүлэх, үйл ажиллагааг үргэлжлүүлэн явуулахыг зөвшөөрөх бөгөөд энэхүү удирдамжийн 3-р зүйл болон энэхүү удирдамжийн II-р хэсэгт дурдсан бусад заалтыг дагаж мөрдөхийг [огноо оруулах = энэхүү удирдамж хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 24 сарын дараа] хүртэл шаардахгүй. Гишүүн улсууд эхний дэд зүйлд дурдсан төлбөрийн байгууллагуудаас эдгээр эрх бүхий байгууллагуудад дараах үйлдлийн аль нэгэнд үнэлгээ өгөх боломжтой мэдээллийг [огноо оруулах = энэхүү удирдамж хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 24 сарын дараа] хугацаанд эрх бүхий байгууллагад ирүүлэхийг шаардах бөгөөд үүнд:
 - а) эдгээр төлбөрийн байгууллагууд II-р зүйлд нийцэж байгаа эсэх, хэрэв нийцэхгүй бол дагаж мөрдөхийн тулд ямар арга хэмжээ авах шаардлагатай;
 - б) зөвшөөрлийг эргүүлэн татах эсэх.Эхний дэд зүйлд дурдсан төлбөрийн байгууллагууд нь эрх бүхий байгууллагаар II бүлэгт нийцэж байгааг баталгаажсны дараа энэхүү удирдамжийн 13 дугаар зүйлд заасны дагуу төлбөрийн байгууллага гэж хүлээн зөвшөөрч, 17, 18 дугаар заалтуудын дагуу бүртгэлд бүртгэнэ. Төлбөрийн байгууллагууд нь [Огноог оруулах = Энэ заавар хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 24 сарын дараа] хугацаанд Гарчиг II заасан шаардлагыг дагаж мөрдөөгүй бол төлбөрийн үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.
2. ЕХ-ны Гишүүн орнууд 1 дэх хэсэгт дурдсан төлбөрийн байгууллагууд автоматаар зөвшөөрөл олгох, 17 дугаар зүйлд заасан бүртгэлд зохих ёсоор бүртгүүлэх журмыг тогтоож болно. Эрх бүхий байгууллага нь төлбөрийн байгууллагууд 3, 13-р зүйлд нийцсэн үйл ажиллагаа явуулж байгаа гэсэн нотлох баримт байгаа тохиолдолд автомат зөвшөөрлийг олгож болно. Эрх бүхий байгууллагууд автомат зөвшөөрлийн талаар холбогдох төлбөрийн байгууллагуудыг зөвшөөрөл олгохоос өмнө урьдчилан мэдэгдсэн байх ёстой.
3. Гишүүн улсууд (ЕХ) 2015/2366 дугаар удирдамжийн 32 дугаар зүйлд заасны дагуу [Огноог оруулах = энэ удирдамж хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 18 сарын дараа] хугацаны дотор чөлөөлөлтөд хамрагдсан, энэхүү удирдамжийн Хавсралт I заасан төлбөрийн үйлчилгээ үзүүлж байсан хувь хүн болон хуулийн этгээдэд дараахь үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрнө. Үүнд:
 - а) холбогдох гишүүн улсын хэмжээнд [Огноог оруулах = энэ удирдамж хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 24 сарын дараа] хүртэл эдгээр үйлчилгээг үргэлжлүүлэн үзүүлэх;

- b) энэхүү удирдамжийн 34 дүгээр зүйлд заасны дагуу чөлөөлөгдөх, хөнгөлөлт эдлэх эрхээ авах, эсхүл,
 - c) энэхүү удирдамжийн Хэсэг II дурдсан бусад заалтыг дагаж мөрдөх.
- Эхний дэд зүйлд дурдсанчлан энэхүү удирдамжийн дагуу [Огноог оруулах = энэ удирдамж хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 18 сарын дараа] хугацаанд зөвшөөрөл аваагүй эсвэл чөлөөлөгдөөгүй аливаа этгээд төлбөрийн үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.
4. Гишүүн улсууд энэхүү удирдамжийн 34 дүгээр зүйлд заасан чөлөөлөлтийг өмнө нь (ЕХ) 2015/2366 дугаар удирдамжийн 32 дугаар зүйлийн дагуу хөнгөлөлт эдэлж байсан хувь хүн болон хуулийн этгээдэд сунгах эрхтэй. Үүний зэрэгцээ эдгээр хувь хүн болон хуулийн этгээд нь 34 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа нотлох баримтын үндсэн дээр эрх бүхий байгууллага нь энэхүү удирдамжийн 17, 18 дугаар зүйлд заасан бүртгэлд зохих ёсоор бүртгүүлж болно. Эрх бүхий байгууллага энэ тухайгаа холбогдох төлбөрийн байгууллагуудад мэдэгдэх ёстой.
- 5.

45 дугаар зүйл

Шилжилтийн нөхцөл – 2009/110/ЕС удирдамжийн дагуу олгогдсон эрх бүхий цахим мөнгөний байгууллагууд

1. Гишүүн улсууд 2009/110/ЕС Удирдамжийн 2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт тодорхойлсон, энэхүү удирдамжийг хэрэгжүүлэх [Огноо оруулах = энэхүү Удирдамж хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 18 сарын дараа] хугацаанд үндэсний хуулийн дагуу үйл ажиллагаагаа эхэлсэн цахим мөнгөний байгууллагуудыг төв оффис нь байрладаг гишүүн улсад үргэлжлүүлэн үйл ажиллагаагаа явуулахыг зөвшөөрнө. Тус зөвшөөрөл нь энэхүү удирдамжийн 3 дугаар зүйл болон II хэсэгт заасан бусад заалтыг дагаж мөрдөх шаардлагагүйгээр үйл ажиллагаагаа гишүүн улс эсвэл өөр гишүүн улсад үргэлжлүүлэн явуулах эрхийг олгоно.
2. Гишүүн улсууд 1-р зүйлд дурдсан цахим мөнгөний байгууллагуудаас удирдамжийг дагаж мөрдөж байгаа эсэхэд үнэлгээ өгөх шаардлагатай бүх мэдээллийг эрх бүхий байгууллагад [Огноо оруулах = энэхүү удирдамж хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 24 сарын дараа оруулна уу] дотор ирүүлэхийг шаардана. Ийм үнэлгээгээр цахим мөнгөний байгууллагууд эдгээр шаардлагыг дагаж мөрддөггүй нь тогтоогдвол эрх бүхий байгууллага эдгээр шаардлагыг хангуулахын тулд ямар арга хэмжээ авах, эсвэл зөвшөөрлийг түтгэлзүүлэх шаардлагатай эсэхийг шийдвэрлэнэ. Эхний дэд хэсэгт дурдсан цахим мөнгөний байгууллагыг эрх бүхий байгууллагаас шалгасны дараа II бүлэгт нийцсэн үйл ажиллагаа явуулж байгаа тохиолдолд энэхүү удирдамжийн 13 дугаар зүйлд заасны дагуу төлбөрийн байгууллагаар эрх олгож, 17, 18 дугаар зүйлд заасны дагуу бүртгэлд оруулна. Цахим мөнгөний байгууллагууд нь II бүлэгт заасан шаардлагыг [Огноо оруулах = энэхүү удирдамж хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 24 сарын дараа] хангаагүй тохиолдолд цахим мөнгөний үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.
3. Гишүүн улсуудын эрх бүхий байгууллагад холбогдох цахим мөнгөний байгууллагууд энэхүү удирдамжийг дагаж мөрдөж байгаа талаарх нотлох баримттай тохиолдолд 1-

р зүйлд дурдсан цахим мөнгөний байгууллагуудыг төлбөрийн байгууллагаар автоматаар зөвшөөрч, 17 дугаар зүйлд дурдсан бүртгэлд оруулахыг зөвшөөрч болно. Ийм автомат зөвшөөрөл олгохоос өмнө эрх бүхий байгууллагууд цахим мөнгөний холбогдох байгууллагад мэдэгдэх ёстой.

4. Гишүүн улсууд 2009/110/ЕС тоот удирдамжийн 9-р зүйлийг хэрэгжүүлэх үндэсний хууль тогтоомжийн дагуу [Огноо оруулах = энэхүү удирдамж хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 18 сарын дараа] үйл ажиллагаа явуулж байсан хуулийн этгээдэд үйл ажиллагаагаа гишүүн улсад энэхүү удирдамжийн дагуу [огноо оруулах = энэхүү удирдамж хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш 24 сарын дараа] хүртэл удирдамжийн 3-р зүйлийг дагуу дахин зөвшөөрөл авахгүйгээр үргэлжлүүлэн явуулахыг зөвшөөрнө. 1 дэх хэсэгт дурдсан цахим мөнгөний байгууллагууд энэ хугацаанд энэхүү удирдамжийн 34 дүгээр зүйлд заасны дагуу зөвшөөрөл аваагүй, чөлөөлөгдөөгүй байсан ч цахим мөнгөний үйлчилгээ үзүүлэхийг хориглоно.

46 дугаар зүйл

98/26/ЕС удирдамжийн нэмэлт өөрчлөлт

98/26/ЕС Удирдамжийн 2-р зүйлд дараах байдлаар өөрчлөлт оруулав.

(1) (b) утгыг дараах байдлаар сольсугай.

'(b) 'байгууллага' гэж дараахь зүйлсийн аль нэгийг ойлгоно:

- Европын парламент ба Зөвлөлийн (ЕХ) 575/2013 тоот журмын 4(1) зүйлийн 1 дэх хэсэгт заасан зээлийн байгууллага*;
- Европын Парламент ба Зөвлөлийн 2014/65/ЕХ-ны удирдамжийн 4(1)-ийн (1)-д заасан хөрөнгө оруулалтын компани, үүнээс 2(1)-д заасан байгууллагуудыг эс тооцвол,
- төрийн эрх бүхий байгууллага, төрийн баталгаатай аж ахуйн нэгж,
- төв оффис нь Холбооны гадна байрладаг, чиг үүрэг нь Холбооны зээлийн байгууллага эсвэл хөрөнгө оруулалтын фирмүүдийн чиг үүрэгт нийцдэг, төлбөрийн системд оролцдог бөгөөд тухайн системийн хүрээнд шилжүүлэх захиалгаас үүсэх санхүүгийн үүргээ биелүүлэх үүрэгтэй аливаа аж ахуйн нэгж (эхний болон хоёрдугаар догол мөрөнд тодорхойлсон);
- 34, 36, 38 дугаар зүйлд заасны дагуу хөнгөлөлт эдэлдэг төлбөрийн байгууллагуудаас бусад ХХХ [Төлбөрийн үйлчилгээний удирдамж3]- н 2 дугаар зүйлийн (4)-д заасан төлбөрийн байгууллага, (i)-ийн эхний догол мөрөнд тодорхойлсон шилжүүлгийн захиалгыг биелүүлэхээс бүрддэг системд оролцдог бөгөөд уг системийн хүрээнд ийм шилжүүлгийн захиалгаас үүсэх санхүүгийн үүргээ биелүүлэх үүрэгтэй аливаа аж ахуйн нэгж,
-

Хэрэв систем нь үндэсний хууль тогтоомжийн хяналтан дор ажилладаг бөгөөд (i)-ийн хоёрдугаар догол мөрөнд тодорхойлсон шилжүүлгийн захиалгыг гагцхүү тэдгээр захиалгаас үүдэлтэй төлбөрийн хамт гүйцэтгэдэг бол гишүүн улс ийм системд оролцогч байгууллагуудыг өөрийн үзэмжээр сонгох эрхтэй бөгөөд байгууллагын хувьд тухайн системийн хүрээнд шилжүүлэх захиалгаас үүсэх санхүүгийн үүргээ биелүүлэх үүрэгтэй.

Гэсэн хэдий ч, ийм тэмдэглэгээг ашиглахын тулд тухайн системийн хамгийн багадаа гурваас доошгүй оролцогч эхний дэд зүйлд заасан ангилалд багтах нь урьдчилсан нөхцөл юм. Түүнчлэн, тэдгээрийг институци гэж ангилах шийдвэр нь системийн эрсдэлийг харгалзан үзсэн дээр үндэслэх ёстой.

(2) (f) утгыг дараах байдлаар сольсугай.

‘(f) “оролцогч” гэж (ЕХ) 648/2012 тоот журмын 17 дугаар зүйлд заасан эрх бүхий байгууллага, төвлөрсөн зуучлагч байгууллага (central counterparty, Олон улсын төлбөр тооцооны бакны “Төлбөр тооцооны системд хэрэглэгддэг нэр томъёоны тайлбар толь” дээр үнэт цаасны зуучлагч гэж орчуулсан байдаг ч энэ тохиолодол тохирохгүй тул ТЗБ гэж оруулав. орч.тэм.) төлбөр тооцооны агент, клирингийн төв, төлбөрийн системийн оператор эсвэл ТЗБ-ын клирингийн гишүүнийг хэлнэ.

Системийн дүрмийн дагуу нэг оролцогч нь ТЗБ, төлбөр тооцооны агент, клирингийн төвийн үүрэг гүйцэтгэх эсвэл эдгээр ажлыг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн гүйцэтгэж болно.

Гишүүн улс нь энэхүү удирдамжийн зорилгын үүднээс системийн эрсдэлд үл хамаарах үндэслэлээр шууд бус оролцогчийг оролцогч гэж үзэж болох боловч энэ нь шууд бус оролцогчийн дамжуулж буй системд захиалгын хариуцлагыг хязгаарлахгүй;’.

47 дугаар зүйл

Удирдамжид нэмэлт өөрчлөлт оруулах (ЕХ) 2020/1828

(ЕХ) 2020/1828 удирдамжийн Хавсралт I дараах ухагдахууныг нэмэв:

“(68) Европын Парламент болон Зөвлөлийн Санхүүгийн мэдээлэлд нэвтрэх Журам(ЕХ) 20.../..., болон (ЕХ)1093/2010, (ЕХ)1094/2010, (ЕХ)1095/2010 болон (ЕХ) 2022/2554 (OJ) L[...], [.....], [P...] нэмэлт өөрчлөлт оруулах тухай’

48 дугаар зүйл

Хүчингүй болгох

(ЕХ-ны) 2015/2366 тоот удирдамжийг [огноо оруулах = энэ удирдамж хүчин төгөлдөр болсноос хойш 18 сарын дараа] хүчингүй болгов.

2009/110/ЕС-ийн удирдамжийг [огноо оруулах = энэ удирдамж хүчин төгөлдөр болсноос хойш 18 сарын дараа] хүчингүй болгов.

Энэхүү удирдамж хэрэгжиж эхэлснээс хойш хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль эрх зүйн актуудад (ЕХ) 2015/2366 болон 2009/110/ЕС удирдамжийн тухай дурдагдсаныг энэхүү заавар эсвэл ХХХ [Төлбөрийн үйлчилгээний удирдамж]-н ишлэл гэж тайлбарлах ёстой. Ийм ишлэлийг энэхүү удирдамжийн III хавсралтад өгсөн хамаарлын хүснэгттэй уялдуулан ойлгох хэрэгтэй.

49 дүгээр зүйл

Хөрвүүлэх

1. Гишүүн улсууд 46-р зүйлийн дагуу энэхүү удирдамжийг дагаж мөрдөхөд шаардлагатай хууль, зохицуулалт, захиргааны заалтуудыг [огноо оруулах = энэ удирдамж хүчин төгөлдөр болсноос хойш 18 сарын дараа] дотор, [огноо оруулах = энэ удирдамж хүчин төгөлдөр болсноос хойш 6 сарын дараа]-ээс хэтрэхгүй хугацаанд баталж, нийтэлнэ. Тэд эдгээр эрх зүйн зохицуулалтуудыг Комисст нэн даруй мэдэгдэх ёстой.
2. Тэд эдгээр арга хэмжээг [огноо оруулах = энэ удирдамж хүчин төгөлдөр болсноос хойш 18 сарын дараа], 46 дугаар зүйлийн хувьд [огноо оруулах = энэ удирдамж хүчин төгөлдөр болсноос хойш 6 сарын дараа]-аас тус тус хэрэгжүүлнэ.

Гишүүн орнууд тэдгээр арга хэмжээг хэрэгжүүлж байгаа тохиолдолд тэдгээр нь энэхүү удирдамжийн ишлэлийг агуулсан байх ёстой бөгөөд эсвэл албан ёсоор нийтэлсэн бол ийм лавлагаатай байх ёстой. Гишүүн орнууд ийм төрлийн лавлагааг хэрхэн гүйцэтгэхээ ёстойг тодорхойлох ёстой.

3. Гишүүн улсууд энэхүү удирдамжийн хүрээнд авч хэрэгжүүлж буй үндэсний хууль тогтоомжийн үндсэн арга хэмжээний талаар Комисст мэдэгдэнэ.

50 дугаар зүйл

Хүчин төгөлдөр болох

Энэхүү заавар нь Европын холбооны албан ёсны сэтгүүлд нийтлэгдсэн өдрөөс хойш хорь дахь өдөр хүчин төгөлдөр болно.

51 дүгээр зүйл

Хаяг

Энэхүү удирдамж нь гишүүн орнуудад зориулагдсан болно.

*Брюссель,
Европын парламент
Ерөнхийлөгч*

*Европын холбооны Зөвлөл
Ерөнхийлөгч*